

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2021 оны эхний хагас жил/

2021 оны 06 дугаар сарын 29

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд 2021 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Монгол Улсын хууль, Улсын Их Хурал болон УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гарсан шийдвэр, зүйл, заалтыг хяналтад авч, яамны нэгжүүдийн 2021 оны эхний хагас жилийн байдлаар ирүүлсэн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг удирдлага болгов.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн цахим хуудсанд байршуулсан шийдвэр, зүйл, заалтыг 2021 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар тасалбар болгон Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 5 дугаар хэвсгалтын дагуу салбар тус бүрээр Геологи, эрдэс баялгийн, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн түүний нөөцийн, Уул уурхайн, Хүнд үйлдвэрийн, Нийтлэг асуудал гэсэн таван ангиллаар хэрэгжилтийг гаргуулав.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

2021 оны эхний хагас жилийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим системд байршуулсан нийт 153 шийдвэрийн 263 зүйл, заалтыг дээр дурдсан агуулгаар ангилж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг **84.3** хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

- Геологи, эрдэс баялгийн бодлогын хүрээнд 14 шийдвэрийн 15 зүйл, заалтын хэрэгжилт - 83.3%;

- Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлогын 19 шийдвэрийн 30 зүйл, заалтын хэрэгжилт - 81.3%;
- Уул уурхайн бодлогын 6 шийдвэрийн 99 зүйл, заалтын хэрэгжилт - 83.1%;
- Хүнд үйлдвэрийн бодлогын 11 шийдвэрийн 13 зүйл, заалтын хэрэгжилт - 71.5%;
- Нийтлэг асуудлын 53 шийдвэрийн 106 зүйл, заалтын хэрэгжилт - 87.6%-ийн тус тус биелэлттэй байна.

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

/2021 оны эхний хагас жил/

Хүснэгт-1

Салбар, чиглэлийн нэр	Хяналтанд авсан тоо		Хэрэгжилтийн явц /хувиар/				Үнэлээгүй	Үнэлгээ %/
	шийдвэр	зүйл заалт	100%	70%	30%	0%		
НЭГ. ГЕОЛОГИ, ЭРДЭС БАЯЛГИЙН БОДЛОГО (ГЭББ)								
Монгол Улсын хууль	2	2	2	-	-	-	-	100.0
УИХ-ын тогтоол	1	1	1	-	-	-	-	100.0
УИХ-ын Байнгын хорооны тогтоол	1	1	-	1	-	-	-	70.0
Засгийн газрын тогтоол	7	8	4	3	1	-	-	80.0
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	3	3	1	2	-	-	-	80.0
ГЭББ-ын дүн	14	15	8	6	1	-	-	83.3
ХОЁР. ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ТҮҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААРХ БОДЛОГ (ГТГТБТНТБ)								
Монгол Улсын хууль	2	3	2	1	-	-	-	90.0
УИХ-ын тогтоол	2	3	2	1	-	-	-	90.0
УИХ-ын Байнгын хорооны тогтоол	3	6	5	1	-	-	-	95.0
Засгийн газрын тогтоол	3	4	2	1	1	-	-	75.0
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	9	14	7	3	4	-	-	73.5
ГТГТБТНТБ-ын дүн	19	30	18	7	5	-	-	81.3
ГУГАВ. УУЛ УУРХАЙН БОДЛОГО (УУБ)								
Монгол Улсын хууль	3	9	7	-	2	-	-	84.4
УИХ-ын тогтоол	8	21	14	2	4	-	1	83.0
УИХ-ын Байнгын хорооны тогтоол	2	2	2	-	-	-	-	100.0
ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл	1	1	1	-	-	-	-	100.0
Засгийн газрын тогтоол	18	26	13	7	4	-	2	79.5
Ерөнхий сайдын захирамж	2	2	1	1	-	-	-	85.0
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	22	38	21	9	3	-	5	85.4
УУБ-ын дүн	56	99	59	19	13	-	8	83.1
ДӨРӨВ. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГО (ХҮБ)								
УИХ-ын тогтоол	1	1	1	-	-	-	-	100.0
Засгийн газрын тогтоол	4	6	1	2	3	-	-	55
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	6	6	4	1	1	-	-	83.3
ХҮБ-ын дүн	11	13	6	3	4	-	-	71.5
ТАВ. НИЙТЛЭГ АСУУДАЛ								

Монгол Улсын хууль	7	31	27	2	2	-	-	93.5
УИХ-ын тогтоол	2	4	4	-	-	-	-	100.0
УИХ-ын Байнгын хорооны тогтоол	3	3	3	-	-	-	-	100.0
Ерөнхийлөгчийн зарлиг	1	1	1	-	-	-	-	100.0
ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл	2	2	2	-	-	-	-	100.0
Засгийн газрын тогтоол	20	29	23	2	1	-	3	95.0
Ерөнхий сайдын захирамж	3	3	1	1	1	-	-	66.6
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	12	20	9	5	6	-	-	71.5
ЗГ-ын албан даалгавар	3	13	6	4	2	-	1	78.3
Нийтлэг асуудлын дүн	53	106	76	14	12	-	4	87.6
Эрх зүйн баримт бичгийн дүн	153	263	107	49	35	0	12	84.3

Нийт 153 шийдвэрийн 263 зүйл, заалтын 12 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй бөгөөд хэрэгжилтийг дүгнэсэн 251 зүйл, заалтын 167 зүйл, заалт буюу 66.5% нь "бүрэн хэрэгжсэн" 100 хувийн биелэлттэй, 49 зүйл, заалт буюу 19.5% нь "хэрэгжих шатанд" 70 хувийн биелэлттэй, 35 зүйл, заалт буюу 13.9% нь "хэрэгжилт хангалтгүй" 30 хувийн биелэлттэй байна.

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ
/Хууль тогтсومжийн төрлөөр/

Хүснэгт-2

	Бүгд	Монгол Улсын хууль	Улсын Их Хурлын тогтоол	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	
Хяналтад авагдсан шийдвэрийн тоо	153	14	14	9	1	3	52	5	52	3	
Заалтын тоо	263	45	30	12	1	3	73	5	81	13	
Үүнээс	"бүрэн хэрэгжсэн" 100%	107	38	22	10	1	3	43	2	42	6
	"хэрэгжих шатанд" 70.0%	49	3	3	2	0	0	15	2	20	4
	"хэрэгжилт хангалтгүй" 30.0%	35	4	4	0	0	0	10	1	14	2
	"хэрэгжээгүй" 0%	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Үнэлгээ өгөөгүй	12	0	1	0	0	0	5	0	5	1
	Үнэлгээ	84.3	91.7	87.2	95.0	100.0	100.0	83.1	74.0	79.2	78.3

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг терлөөр нь авч үзвэл:

- Монгол Улсын 14 хуулийн 45 заалтын хэрэгжилт – 91.7%;
- Улсын Их Хурлын 14 тогтоолын 30 заалтын хэрэгжилт – 87.2%;
- УИХ-ын Байнгын хорооны 9 тогтоолын 12 заалтын хэрэгжилт – 95.0%;
- Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 1 заалтын хэрэгжилт – 100.0%;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 шийдвэрийн 3 заалтын хэрэгжилт – 100.0%;
- Засгийн газрын 52 тогтоолын 73 заалтын хэрэгжилт – 83.1%;
- Ерөнхий сайдын 5 захирамжийн 5 заалтын хэрэгжилт – 74.0%;
- Засгийн газрын хуралдааны 52 төмдөглэлийн 81 заалтын хэрэгжилт – 79.2%;
- Засгийн газрын 3 албан даалгаврын 13 заалтын хэрэгжилт – 78.3% байна.

Дөрөв. Дүгнэлт.

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан 153 шийдвэрийн 263 зүйл, заалтын 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг 84.3 хувийн биелэлттэй гэж дүгнэлээ.
2. Нийт 263 зүйл, заалтын 12 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй, 167 зүйл, заалт “бүрэн хэрэгжсэн” 100 хувийн биелэлттэй, 49 зүйл, заалт “хэрэгжих шатанд” 70 хувийн биелэлттэй, 35 зүйл, заалт “хэрэгжилт хангалтгүй” 30 хувийн биелэлттэй байна.
3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа боловч хэрэгжилтийг тайлагнахдаа ажлын гол үр дүнг товч тодорхой, баримт нотолгоонд суурилсан байдлаар тайлагнах шаардлагатай байна.
4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн нэгтгэн боловсруулсан тайланг албажуулж, тогтоосон хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэх шаардлагатай байна.

Тав. Зөвлөмж.

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тухайн зүйл, заалтыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад тагилцуулахдаа хэрэгжилтийг хариуцан тайлагнах нэгжийг тодорхой цохуулж эзэнжүүлэх;
2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрээс өөрийн нэгжид хамаарах хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, биелэлтийг нэгтгэн Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлэх үүргийг нэгжүүдэд эзэнжүүлж, уг үүргийг тухайн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тусгах;
3. Төрийн захиргааны удирдлагын газраас хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг (дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж) нэгтгэн боловсруулахдаа тухайн зүйл, заалтаар өгөгдсөн үүрэгт хамаарах хэрэгжилтийг оновчтой, тодорхой байдлаар гаргуулах, холбогдох

тушаал, шийдвэр болон албан бичгүүдийн огноо, дугаарыг тодорхой бичүүлж хэвших;

4. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын нэгдүгээр хавсралтад зааснаар Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 01 дүгээр сарын 15, 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ЗГХЭГ-т хүргүүлдэг бөгөөд энэ хугацаанаас ажлын 5 хоногийн өмнө нэгтгэн боловсруулсан тайланг албажуулж Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлж байх.
5. “хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувийн биелэлттэй дүгнэгдсэн, хэрэгжилтийн явц удаашралтай байгаа ажлуудыг эрчимжүүлэх, он удаан жил хэрэгжилт хангагдахгүй байгаа холбогдох шийдвэрийн зүйл, заалтыг хүчингүй болгуулах, дараагийн шийдвэрийг гаргуулах талаар тодорхой арга хэмжээг авч ажиллах.

Жич: Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хийсэн үнэлгээний тайлан, нэгтгэлийг хавсаргав.

Хянасан:

ХШҮДАГ-ын дарга



Ц.Одхүү

Үнэлгээ хийж, танилцуулга боловсруулсан:

ХШҮДАГ-ын шинжээч



Н.Цогтбаяр

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР БАТЛАГДСАН
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
/2021 оны эхний хагас жилийн байдлаар/

2021 оны 06 дугаар сарын 29-ний өдөр

№	Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	3	4	5	6
САЛБАР ЧИГЛЭЛ: 1. ГЕОЛОГИ, ЭРДЭС БАЯЛГИЙН БОДЛОГ						
1.а. Монгол Улсын хууль						
1	1	1	<p>Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай 2009-07-16 Дугаар 2009.07.16</p> <p>4.3. Энэ хуулийн 4.1-д заасан газрын хилийн заагийг Засгийн газар тогтооно. (4.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно.)</p>	<p>ЗГ-ын 2011.06.08-ны өдрийн 174 дүгээр тогтоолоор Ашигт малтмал хайх ашиглахыг хориглосон гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хэсэгчлэн тогтоосон хилийн заагийг хавсралтаар баталсан. Уг тогтоолд ЗГ-ын 2014 оны 260, 2015 оны 130 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон. Монгол Улсын ЗГ-ын 2012.06.05-ны өдрийн 194 дугаар тогтоолоор МУ-ын нутаг дэвсгэр дэх гол мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн заагийг 1 дүгээр, Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийн заагийг 2 дугаар, Ойн сан бүхий газрын хилийн заагийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсан. ЗГ-ын 2014 оны 260, 2014 оны 281, 2015 оны 130, 302, 2016 оны 155 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон. ЗГ-ын 2015.03.03-ны өдрийн 120 дугаар тогтоол “Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээний загвар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсан. ЗГ-ын 2015.07.07-ны өдрийн 289 дүгээр тогтоолоор “ЗГ-ын 2012 оны 194 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан МУ-ын нутаг дэвсгэр дэх гол мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн зааг-ийн солбицолд оруулах өөрчлөлтийг 1 дүгээр, уг тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Ойн сан бүхий газрын хилийн зааг”-ийн</p>	100%	

				солбицолд оруулах өөрчлөлтийг 2 дугаар хавсралтаар баталсан. Мөн энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хилийн заагийг хэсэгчлэн тогтоох тухай” ЗГ-ын 174 дүгээр тогтоол, “Хилийн заагийг тогтоох” тухай 194 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болгосон. Засгийн газрын 2015.03.03-ны өдрийн 120 дугаар тогтоол “Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам”-д заасны дагуу Энгийн хамгаалалтын бүсэд гэрээ байгуулсан 38 аж ахуйн нэгжийн 40 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн гэрээний хэрэгжилтийг дүгнэж, гэрээний хугацааг АМГТГ-аас сунгаж ажилласан.		
2	2	2	<p>Ашигт малтмалын тухай /Шинэчилсэн найруулга/ 2006-07-08 Дугаар 2006.08.26</p> <p>16.6.. Улсын төсвийн хөрөнгөөр хийх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг хянаж хүлээн авах журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуульд нийцүүлэн батална.</p>	Улсын төсвийн хөрөнгөөр хийх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох тухай журмыг Уул уурхайн сайдын 2015 оны 108 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж захиргааны хэм хэмжээ тогтоосон актын Улсын бүртгэлд 2015.07.01-ний өдрийн 3542 дугаарт бүртгүүлсэн.	100%	Журмыг батлуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.
1.б. Улсын Их Хурлын тогтоол						
3	1	1	<p>Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (УИХ 2016.07.21-ний 12 дугаар тогтоолд “21.Үндэсний геологийн алба” гэж нэмсүгэй) 2020-01-30 Дугаар 2020 №12</p> <p>3.. Үндэсний геологийн албыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтаан байгуулж ажиллуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасгай.</p>	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Үндэсний геологийн албыг Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоолоор байгуулсан. Тус тогтоолоор Үндэсний геологийн албаны үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт зөвшөөрсөн. Үндэсний геологийн албаны орон тооны дээд хязгаарыг 68 байхаар тогтоосон боловч Засгийн газрын 38 дугаар тогтоолоор орон тооны дээд хязгаарыг 35 байхаар өөрчлөлт оруулсан. Өнөөдрийн байдлаар Үндэсний геологийн албаны үйл ажиллагаа жигд явагдаж байна.	100%	Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.
1.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол						
4	1	1	Засгийн газарт чиглэл өгөх тухай БОХХААБХ/ӨБХ/	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5-д зааснаар хайрга, дайрганы түгээмэл тархацтай ашигт	70%	

			<p>2019-05-28 Дугаар 2019 №04/01</p> <p>1.17. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн биелэлтийг нийслэл болон Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт хангасан талаар танилцуулах;</p>	<p>малтмалын тусгай зөвшөөрөл олгох эрх нь орон нутгийн удирдлага засаг даргад хадгалагддаг.</p> <p>Орон нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход Ашигт малтмал, газрын тосны газраас дүгнэлт гаргадаг бөгөөд Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар давхцал байгаа тохиолдолд олгох боломжтой дүгнэлтийг гаргахгүй хориотой юм.</p> <p>Харин урт нэртэй хууль гарахаас өмнө Ашигт малтмалын тухай хуулийн дагуу Төв аймгийн Алтанбулаг, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт олгогдсон байдаг бөгөөд уг газруудыг Засаг дарга цуцлаад шийдвэр болон холбогдох мэдээллийг Ашигт малтмал, газрын тосны газарт ирүүлсэн тохиолдолд УУККС бүртгэх боломжтой.</p>		
1.г. Ерөнхийлөгчийн зарлиг						
1.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл						
1.е. Засгийн газрын тогтоол						
5	1	1	<p>Төслийн нэгж байгуулах тухай 2019-05-01 Дугаар 2019_176</p> <p>3.. Төслийн нэгжийг 5 жилийн хугацаатай ажиллуулж, үр дүнгийн тайланг тухайн жилийн 12 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Эрдэнэс Монгол” ХХК (П.Ганхүү)-д даалгасугай.</p>	<p>Газрын ховор элементийн төслийн нэгж нь Ховор металл, газрын ховор элементийн чиглэлээр дараах судалгааг хийсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - ГХЭ-ийн зах зээлийн болон технологийн мөн хөгжингүй орнуудын ховор, газрын ховор элементийн талаар баримталж байгаа бодлогын талаарх судалгаа; - Монгол орны газрын ховор метал, газрын ховор элементийн ордууд, томоохон илрэлүүд, эрдэсжсэн цэгийн мэдээллийн санг бүрдүүлж, баяжуулалт хийж байна. <p>Мэдээллийн санг Геологийн баримтын төвөөс авсан 14 тайлангийн материалаар нэмж, баяжуулсан байна. Монгол орны газрын ховор элемент болон ордуудын тухай мэдээлэл, Төслийн нэгжийн судалгааны мэдээллийг бэлтгэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд хүргүүлсэн. Монгол орны Газрын ховор элементийн ашиглалтын тусгай зөвшөөрөл, ханшийн судалгааны ажлыг гүйцэтгэж байна.</p>	100%	
6	2	2	<p>Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнд тавих хяналтыг сайжруулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох талаар авах зарим арга хэмжээний тухай 2020-01-15 Дугаар 2020_17</p> <p>1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн иж бүрдлийг бүрэн хангуулах, цахим</p>	<p>АМГТГ нь Ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд өөрийн олгосон Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хувийн хэргийг цахим болон бичгийн хэлбэрээр бүрдүүлэлт хийж байна. Хувийн хэргийн бүрдүүлэлтэнд АМГТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистикийн хэлтэс болон УУХҮЯ-ны ХШҮДАГ хяналт тавьж ажиллаж байна. АМГТГ-ын даргын 2020 оны А/87 дугаар тушаалаар ажлын хэсгийг байгуулан дараах ажлуудыг хийж хэрэгжүүлж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн иж бүрдэл хангасан, хангаагүй байгааг ялгаж ангилан судалгааг гаргасан. 2. Тусгай зөвшөөрлийн хувийн хэргүүдийг цахим хэлбэрт хөрвүүлэн оруулах ажлыг ХБНГУ-ын БГР “Монгол улсын эрдэс баялгийн салбар 	70%	

			<p>мэдээллийн төрөлжсөн санг 2020 оны I улиралд багтаан байгуулах, тус мэдээллийн санг холбогдох төрийн байгууллагууд ашиглах, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт тус тус даалгасугай.</p>	<p>дахь институцын болон боловсон хүчний чадавхийг хөгжүүлэх-II" төслийн дэмжлэгтэйгээр эхлүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 130 хувийн хэрэг материал цахим хэлбэрт оруулаад байна. 2021 онд бүрэн цахим хэлбэрт шилжүүлнэ.</p> <p>3. 1997 оны ашигт малтмалын тухай хууль хэрэгжиж эхлэхээс өмнө олгогдсон 384 тусгай зөвшөөрлийн мэдээллийг УУККС-д нөхөн оруулсан. Төрийн байгууллагатай мэдээлэл солилцох ажлын хүрээнд "ХУР", "ДАН", "ЦАХИМ-МОНГОЛ"-д нэгдэх бэлтгэл ажлыг хангуулах, цаасан мэдээллийг цахимжуулах, УУККС-ийг төрийн бусад байгууллагуудтай холбох сервис хөгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгохоос бусад цахим мэдээллийн төрөлжсөн санг шинээр байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна. УУККС-ийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сантай "ХУР" системээр дамжуулж мэдээлэл солилцох сервисийг хөгжүүлж байна. БОАЖЯ-тай мэдээлэл солилцох, мэдээллийн санг холбох талаар тохиролцох, гэрээ хийх ажил хийгдэж байна. Цаашдаа ЗГХЭГ болон бусад төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох дундын сервисүүдийг бий болгохоор системийн хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна. Нэгдсэн бодлого зохицуулалтгүйгээс төрийн байгууллагуудын эрхэлдэг мэдээллийн сангуудын хөгжүүлэлт өөр өөр түвшинд байхаас гадна техникийн шийдлийн хувьд ч өөр өөр байгаа нь мэдээлэл солилцоход бэрхшээлүүд тулгарч байна.</p>		
7	2	3	<p>5.. Ашигт малтмалын ордын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлөх журам"-ыг шинэчлэн боловсруулж 2020 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт үүрэг болгосугай.</p>	<p>АМГТГ-ын даргын 2020.04.03-ны өдрийн А/35 тоот тушаалаар "Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлөх журам"-ын явц, хэрэгжилтийн үр дүн, биелэлтийг судалж, цаашид авах арга хэмжээний саналыг танилцуулах үүрэг бүхий 9 гишүүнтэй ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор ажлын хэсэг хуралдаагүй болно.</p>	30%	
8	3	4	<p>Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай 2020-03-25 Дугаар 2020_110</p>	<p>Ашигт малтмал, газрын тосны газраас Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн нэгдсэн мэдээллийн санг 2010 онд байгуулсан бөгөөд мэдээллийн санг шинэчлэх сайжруулалтын ажил тухай бүр хийгдэж байсан. Германы хамтын ажиллагааны BGR төслийн шугамаар Кадастрын хэлтсийн мэдээллийн сангийн нэмэлт сайжруулалт болон цахим архив тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн системийг</p>	70%	

			4. Ашигт малтмалын ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөл, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу болон бичил уурхай эрхлэх зориулалтаар ашиглах талбайн мэдээллийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд тухай бүр бүртгэж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. 2020 оны 1 дүгээр улиралд багтааж цахим архив болон тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн системийн хөгжүүлэлт суурилуулалтын ажил хийгдэж дуусах байсан боловч системийг хөгжүүлэгч Германы ГАФ АГ компанийн үйл ажиллагаа COVID-19 өвчний улмаас түр зогсож ажилтнууд нь гэрээсээ ажиллаж байгаа тул системийн хөгжүүлэлт суурилуулалтын ажил удаашралтай явагдаж байна. Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газартай хамтарсан ажлын хэсгийг 2020 оны А/270, 2021 оны А/140 дугаартай тушаалаар байгуулсан. Эрхэлсэн асуудлын хүрээнд бүрдүүлдэг газрын нэгдмэл санд оруулах орон зайн өгөгдлийн /Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбайн хил зааг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайн хил зааг, Бичил уурхайн зориулалтаар олгосон талбайн хил зааг, Нөөцөд авсан талбайн хил зааг, Газрын тос, уламжлалт бус газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбай, Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн гэрээ байгуулсан талбайн хил зааг, Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг хязгаарлах, хориглох тусгай хэрэгцээний газрын хил зааг/ судалгааг гаргаж ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.		
9	4	5	<p>Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай 2020-04-29 Дугаар 2020_153</p> <p>4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай.</p>	Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг концессын гэрээгээр гүйцэтгэх "Макс рөүд" ХХК-д тус замын бүтээн байгуулалтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын 54 талбайг хайх, ашиглах эрхийг холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан талбайтай давхцуулахгүй олгосон. Тус компани замын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай 1,549,000 м.куб элс, дайрга, хайргыг ашиглахаар уг тогтоолд тусгасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалыг бүрэн ашиглаж замын ажлыг дуусгасан байна.	100%	Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.
10	5	6	<p>Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай 2020-10-07 Дугаар 2020_135</p> <p>3. Авто замын барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг авто зам, гүүрийн</p>	<p>3. Зам, гүүрний бүтээн байгуулалтын ажил дуусмагц гүйцэтгэгч аж ахуйн нэгж талбайн нөхөн сэргээлтийг хийх бөгөөд хяналтыг тухайн орон нутаг тавих тул УУХҮЯ-наас биелэлт гаргахгүй болно.</p> <p>4. Засгийн газрын тогтоолоор бүтээн байгуулалтын зорилгоор тусгай хэрэгцээнд авсан замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын албайнууд нь холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд одоогоор замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой, ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна.</p>	100%	

			барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд үүрэг болгосугай. 4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгасугай.		
11	6	7	Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай 2020-11-04 Дугаар 2020_170 2. Энэ тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан газартай давхцалтай иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж байгаа газар, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг нөхөх олговортойгоор эргүүлэн авах, эсхүл солиход гарах зардлын хэмжээ, нүүлгэн шилжүүлэх хугацааг тохиролцох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт даалгасугай.	Тогтоолын дагуу улсын тусгай хэрэгцээнд авсан газартай давхцалтай иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж байгаа газар, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг нөхөх олговортойгоор эргүүлэн авах, эсхүл солиход гарах зардлын хэмжээ, нүүлгэн шилжүүлэх хугацааг тохиролцох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын тушаалаар ГЗБГЗЗГ, ЗТХЯ, Монгол төмөр ТӨХК, АМГТГ, Дорноговь аймгийн ГХБХБГ, Өмнөговь аймгийн ГХБХБГ, холбогдох сумдын газрын даамал нар ажиллаж байна	70%
12	7	8	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай 2021-05-05 Дугаар 2021_130 2. Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 361 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол"-ын 61 дэх заалтын дараа	1. Тогтоолын хавсралтад нэмэлтээр оруулсан түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тайлбайнуудыг хуулиар хориглосон, хязгаарласан болон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудтай давхцуулахгүйгээр боловсруулан нэмэлт оруулж батлуулсан. 2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлыг харъяалах аймгийн Засаг даргын тамгын газар зохицуулах арга хэмжээг авч, замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайнуудаас шаардлагатай материалыг замын бүтээн байгуулалтын ажилд ашиглаж байна. ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна.	100%

			хавсралтад дурдсан агуулгатай 62-76 дахь заалтыг нэмсүгэй. 2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай.		
1.ё. Ерөнхий сайдын захирамж					
1.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					
13	1	1	<p>2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр 74 дугаар тэмдэглэл 2020-12-30 Дугаар 2020_74</p> <p>ХХИХ.7. . “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн эзэмшдэг “Овоот хяр” нэртэй ХҮ-21670 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайд дахь “Хойд бүргэд” нэртэй алтны үндсэн ордод “Геологийн судалгааны төв” ТӨҮГ болон “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн хамтран гүйцэтгэсэн геологичайгуулын ажлын үр дүнгийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Хойд бүргэд” нэртэй алтны үндсэн ордын нарийвчилсан хайгуулын ажлыг дуусгах, уг тусгай зөвшөөрөл бүхий талбайд илэрсэн алт, алт-зэсний илрэлүүдэд нөөц тогтоох эрэл, хайгуулын нэмэлт ажилд шаардагдах эх үүсвэрийн асуудлыг судлан саналаа боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгав.</p>	<p>“Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн шийдвэрээр “Овоот хяр” хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хийгдэх нарийвчилсан хайгуулын ажилд шаардагдах санхүүжилтийг 2020 оны орлогоос буюу өөрийн хөрөнгөөр гүйцэтгэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/37 дугаар тушаалаар геологи, хайгуулын ажлын 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдсан. Үүнд: Овоот хяр хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд Геофизикийн соронзон хайгуулын ажил, Овоот хяр хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд Геофизикийн цахилгаан хайгуулын ажил, Шар хөндий-Хан худгийн хайгуулын талбайнуудад гүйцэтгэх өрөмдлөгийн ажил, Бүргэдийн хайгуулын талбайнуудад гүйцэтгэх өрөмдлөгийн ажил, Овоот хярын хайгуулын талбайд гүйцэтгэх өрөмдлөгийн ажил, Топогеодези /цооногийн топо холболт, байрзүйн зураг/-ийн ажил, Лабораторийн шинжилгээ, Овоот хярын эрлийн талбайн геологийн нөөцийн тайлан боловсруулах ажил, Овоот хяр хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд Археологийн судалгаа, Овоот хяр хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн судалгаа зэрэг ажлын тендерийг www.tender.gov.mn цахим хуудаст байршуулан сонгон шалгаруулах ажиллагааг явуулж байна.</p>	70%

14	2	2	<p>2021 оны 2 дугаар сарын 17-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2021-02-17 Дугаар 2021_11</p> <p>XII.12. 8. Бүс нутгийн логистикийн төвүүдийн байршлыг Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан тодорхойлох судалгааг хамтран хийж, 2021 оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт;</p>	<p>МУ-ын Ерөнхий сайдын 2021.03.24-ний 76 дугаар захирамжаар байгуулагдсан Богдхан төмөр зам төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг 2021.04.05-ны өдөр хуралдаж бэлтгэл ажлын төлөвлөгөөнд тусгах саналыг ажлын хэсгийн гишүүдээс авсан. Салбарын яамны зүгээс бэлтгэл ажлын төлөвлөгөөнд холбогдох саналыг боловсруулан 2021.04.08-ны өдөр Ажлын хэсэгт хүргүүлсэн.</p>	100%	
15	3	3	<p>2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр 58 дугаар тэмдэглэл 2020-11-04 Дугаар 2020_58</p> <p>XVI.2. -. “Геологийн судалгааны төв” болон “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ыг Үндэсний геологийн албаны харьяанд ажиллуулах боломжийг судлан саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Үндэсний геологийн алба (О.Чулуун), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт;</p>	<p>Үндэсний геологийн албаны харьяанд Геологийн судалгааны төв болон Геологийн төв лабораторийг ажиллуулах талаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж яамдаас санал авсан. Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Засгийн газрын тогтоол гаргах шаардлагагүй бөгөөд 2 байгууллагын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах замаар удирдлагын багийг Үндэсний геологийн албаны харьяанд ажиллуулах боломжтой гэж үзсэн. Үүний дагуу холбогдох дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 5 дугаар сард ҮГА-аас албан бичгээр хүргүүлсэн ба тус газрын хуралдааныг хүлээж байна.</p>	70%	
<u>14</u>	<u>15</u>	<p><u>Геологи, эрдэс баялгийн бодлогын дундаж: 83.3 хувь</u></p>				

САЛБАР ЧИГЛЭЛ: 2. ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН НӨӨЦИЙН ТАЛААРХ БОДЛОГО

2.а. Монгол Улсын хууль

16	1	1	<p>Хөрөнгө оруулалтын тухай 2013-10-03 Дугаар 2013.11.01</p> <p>11.2.1.. Барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих; (11.2.Доор дурдсан тохиолдолд импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:)</p>	<p>Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай 2019.11.28-ны өдөр батлагдсан хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, гаалийн албан татварыг хөнгөлөх тухай Монгол Улсын Засгийн газрын 2020.05.13-ны өдрийн 172 дугаар тогтоол батлагдан гарсан. Тус тогтоолоор Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт барих газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын хотхоны барилга, байгууламжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах дотоодын үйлдвэрээс хангах боломжгүй импортоор оруулах ирэх бараа материалын жагсаалтыг баталсан болно.</p>	<p>100%</p> <p>ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>	
17	1	2	<p>11.2.2.. Нано, био болон инновацийн технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих; (11.2.Доор дурдсан тохиолдолд импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно:)</p>	<p>Тус хуулийн заалтын дагуу Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг Монгол Улсын Засгийн газрын 2018.08.01-ний өдрийн 234 дүгээр тогтоолоор баталсан.</p>	<p>100%</p> <p>ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>	
18	2	3	<p>ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2014-07-01 Дугаар 2014_06</p> <p>8.1.9. газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм батлах;</p>	<p>Хуулийн тус заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд АМГТГ-аас ОХУ-ын "Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн орчуулгад тулгуурлан "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийн төслийг боловсруулсан. Захиргааны ерөнхий хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан тус дүрмийн төслийг төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулж, санал шүүмж авах хэлэлцүүлгийг Нээлттэй нийгэм форумтай хамтран 2018.03.21-ний өдөр зохион байгуулсан ба дүрмийн төсөлтэй холбоотой тодорхой санал, шүүмжүүдийг ирүүлсэн. Энэхүү дүрмийн орчуулгын эх хувь болох ОХУ-ын "Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм 2018 онд шинэчлэгдсэн, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018.06.21-ний өдрийн 27-р тогтоолоор MNS ISO 45001:2018 "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо-Шаардлага, хэрэглэх заавар" стандартыг баталж, 2018.07.16-ны өдрөөс мөрдөж эхэлсэн, мөн манай</p>	<p>70%</p>	

			улсын газрын тосны салбарт хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж буй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой олон улсын стандартууд, дүрэм, заавар, зааварчилгааг судлан нэгтгэх, дүрмийн төсөлд тусгах, уялдуулах зэрэг хүчин зүйлс, учир шалтгаантай холбоотойгоор тус дүрмийн төслийг орчин үеийн нөхцөл, байдалд нийцүүлэн боловсруулах хэрэгцээ, шаардлага тулгарч байна. Энэхүү үйл ажиллагаанд тодорхой хэмжээний төсөв, мөнгө шаардагдаж байгаа тул газрын тосны салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх олон улсын туршлага, стандарт, дүрэм журмын талаар судалгаа хийж, санал, дүгнэлт боловсруулах тухай эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгүүлэх төсвийг УУХҮ-ийн сайдын 2021 оны төсвийн багцад суулгасан. УУХҮЯ-ны ТНБД-ын 2021 оны А/01 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо тус судалгааны ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байна.			
2.5. Улсын Их Хурлын тогтоол						
19	1	1	<p>Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай 2012-01-05 Дугаар 2012 №01</p> <p>1.1.. 1.Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай: 1.1. Газрын тос боловсруулах бага болон дунд хүчин чадлын үйлдвэрийг газрын тосны ордод түшиглэсэн байдлаар ойрын хугацаанд барьж байгуулах ажлыг түргэтгэх;</p>	<p>ҮАБЗ-ийн 2014.03.17-ны өдрийн хуралдаанаас газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах зөвлөмж гаргасан. БНЭУ-аас олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахаар шийдвэрлэж, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд 2016.04.28-ны өдөр байгуулсан “Зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийг Монгол Улсын Их хурал 2017.05.31-ний өдөр соёрхон баталсан. Засгийн газрын 2017.03.20-ны өдрийн 92 дугаар тогтоолоор ГТБҮ-ийн төслийг хэрэгжүүлэх төрийн өмчит компанийг байгуулсан. Үйлдвэрийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг БНЭУ-ын төрийн өмчит “Инженерс Индиа Лимитэд” компани боловсруулж, 2018 оны 11 дүгээр сард Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хэлэлцэж, хүлээн авсан. Газрын тос боловсруулах үйлдвэр нь үндсэн технологийн 12 байгууламж болон дагалдах, туслах барилга байгууламжуудаас бүрдэнэ.</p> <p>“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нь Төслийн менежментийн зөвлөх (ТМЗ) үйлчилгээ үзүүлж буй Engineers India Limited компанитай хамтран үйлдвэрийн анхдагч процессийн байгууламжууд, хангамжийн систем, дагалдах байгууламж, цахилгаан станцыг Монгол орны нөхцөл, стандартын шаардлагад нийцүүлэн төлөвлөж, ерөнхий дизайн, инженерчлэлийн багц (Basic design engineering package, BDEP) болон суурь инженерчлэлийн зураг төсөл (Front End Engineering Design, FEED)-ийг боловсруулсан. Төслийн</p>	<p>100%</p> <p>УИХ-ын тогтоолын заалт нь бүрэн хэрэгжээгүй, цаг хугацааны ач холбогдолгүй болсон, ҮАБЗ, УИХ, ЗГ-аас гарсан шийдвэрүүдээр газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн зорилго үйл ажиллагаа өөрчлөгдсөн тул ХЯНАЛТААС</p>	

			<p>хүрээнд үйлдвэрийн гаднах дэд бүтэц (17,5 км тусгай зориулалтын хүнд даацын авто зам, 27,7 км салаа төмөр зам, дэд өртөөний барилга байгууламж, 18,2 км 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/10кВ-ын дэд станц)-ийн барилга байгууламжийг Монгол Улсын Хөгжлийн банкны зээлээр барьж байгуулан, 2019 оны 11 дүгээр сард ашиглалтад хүлээн авсан. Мөн газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл нь үндсэн 4 хэсгээс бүрдэнэ. Үүнд:</p> <p>ЕРС-1: Технологийн бус барилга байгууламж ЕРС-2: Анхдагч процессийн болон дагалдах байгууламж ЕРС-3: Үйлдвэрийн цахилгаан станц ЕРС-4: Лицензит технологийн байгууламж</p> <p>Өнөөгийн байдлаар үйлдвэрийн барилга-угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчид болон гүн боловсруулалтын технологийн лиценз эзэмшигчдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд технологийн бус барилга байгууламжийн барилга-угсралтын ажил эхлээд байна.</p>	ХАСУУЛАХ САНАЛТАЙ.	
20	1	2	<p>1.2.. Дотоодын түүхий эдийг боловсруулах үйлдвэр барих санаачилга гаргаж байгаа аж ахуйн нэгжийг дэмжих замаар бензин, түлш шатахууныхаа хэрэгцээг хангах зорилтыг хэрэгжүүлэх;</p> <p>Уул уурхайн яам /хуучнаар/-наас газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг нийт 15 компанид олгосон хэдий ч тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын хөрөнгө санхүүжилт, техник технологи болон зарим тодорхойгүй шалтгааны улмаас дорвитой ажил хийгдээгүй. Нүүрс шингэрүүлж шатахуун үйлдвэрлэхээр тусгай зөвшөөрөл авсан "Багануур Энержи Корпорэйшн", "Гермон Газ", "МАК Си Ти Эл" компаниуд тодорхой ажлууд хийж эхэлсэн ч үйл ажиллагаа нь удааширч зогссон. Заримыг дурдвал "Дархан-Газрын тос боловсруулах үйлдвэр" ХХК жилд 2 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дархан хотод, "Хэт" ХХК жилд 120 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дорнод аймагт, "М-Ойл" ХХК жилд 300 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Улаанбаатар хот, Рашаант өртөөнд, "Сүмбэр Ойл" ХХК-ийн жилд 100 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр, "М Ойл энд Жи" ХХК нь жилд 330 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дорноговь аймгийн Зүүнбаянд тус тус барих төсөл ирүүлснийг яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. ҮАБЗ-ийн 2014.03.17-ны өдрийн 14/06 тоот зөвлөмжөөр газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах зөвлөмж гарсантай холбогдуулан Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг байгуулах төслийг хэрэгжүүлж байна.</p>	100%	<p>УИХ-ын тогтоолын заалт нь бүрэн хэрэгжээгүй, цаг хугацааны ач холбогдолгүй болсон, ҮАБЗ, УИХ, ЗГ-аас гарсан шийдвэрүүдээр газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн зорилго үйл ажиллагаа өөрчлөгдсөн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>

21	2	3	<p>Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2016-11-17 Дугаар 2016 №69</p> <p>2/2.. Түүхий нефтийн экспортоос нөөц ашигласны төлбөрийг тооцож авах, борлуулалтын орлогыг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх хуулийн шаардлагыг бүтээгдэхүүн хуваах гэрээнд тусгах гэрээ хэлцлийг хийж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах. (2/Төсвийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр:)</p>	<p>Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь олборлосон түүхий тос, байгалийн хийн 5-15 хувь байна гэж хуульчилсан бөгөөд 2014 онд Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдахаас өмнө байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд болох Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт орших БХГ-97 талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний хувьд газрын тосны нөөц ашигласны төлбөр 7%, Дорнод аймгийн Тамсагийн сав газарт орших Тосон-Уул-ХИХ талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнд газрын тосны нөөц ашигласны төлбөрийг шууд авахаар дурьдаагүй хэдий ч Монгол Улсад ногдох хувь хэмжээнд нөөц ашигласны төлбөрийг хамаарахаар гэрээнд тусгасан байдаг, харин Тамсаг-ХХI талбайн хувьд газрын тосны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг 7,5%-иар гэрээнд тусгаж өгсний дагуу экспортолж буй газрын тосноос нөөц ашигласны төлбөрийг гэрээнд заасны дагуу авч Улсын төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/12-р тушаалаар байгуулагдсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх хэлэлцээр хийх үүрэг бүхий ажлын хэсэг Гэрээлэгч компаниудтай хэлэлцээр хийж, холбогдох арга хэмжээг авч ажилласан бөгөөд хайгуулын үе шатанд хэрэгжиж буй бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг бүрэн шинэчилсэн. Харин газрын тосны ашиглалт, экспортын үйл ажиллагаа явуулж буй Гэрээлэгч компаниудтай удаа дараа хэлэлцээр хийсэн боловч Гэрээлэгч тал өнөөг хүртэл хөрөнгө оруулалтаа нөхөж аваагүй алдагдалтай ажиллаж байгаагаас гадна 2014 онд батлагдсан Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын холбогдох заалтууд нь хууль батлагдахаас өмнө БХГ байгуулсан Гэрээлэгчийн эрх ашиг, эдийн засгийн нөхцөл байдалд хохирол учруулах, сөрөг нөлөө үзүүлэхээр байгаа тул нэгэнт байгуулсан гэрээг өөрчлөхгүй байх зарчмын байр суурийг тухай бүр илэрхийлсээр байна.</p>	70%	
2.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол						
22	1	1	<p>Валютын ханш, газрын тосны бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах талаар цаашид авах арга хэмжээний тухай 2012-02-08 Дугаар 2012 №10 ЭЗБХ</p> <p>1.8.. Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдийн тоог ОХУ-ын болон бусад нийлүүлэгч компанийн тооноос</p>	<p>Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 2013.02.07-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр ГТБ-нийг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдааны үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээр тусгасан. Мөн Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т импортлогч нь "газрын тосны бүтээгдэхүүнийг нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр импортлох" үүрэг хүлээхээр хуульчилсан. Түүнчлэн УУХҮС-ийн 2018.01.12-ны өдрийн А/08 дугаар тушаалаар батлагдсан "Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам"-д ГТБ импортлох тусгай зөвшөөрлийг бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдэд олгох нэмэлт зохицуулалт оруулсан. Онцгой албан татварын</p>	100%	Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.

			хамааруулан цөөлөх, газрын тосны бөөний худалдаа эрхлэгч томоохон аж ахуй нэгжүүдээс уул уурхайн салбарын томоохон хэрэглэгчдэд нийлүүлж буй шатахуунд онцгой албан татварын болон аливаа татварын хөнгөлөлтийг үзүүлэхгүй байх, газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаанд үнийг хямд, тогтвортой байлгах зорилгоор өрсөлдөөнийг дэмжих бусад бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу тус хуулийн 6.2-т заасан хэмжээгээр автобензин, дизелийн түлшийг импортлох үед онцгой албан татварыг авч байгаа тул уул уурхайн салбарын томоохон хэрэглэгчдэд нийлүүлж буй шатахуунд онцгой албан татварын болон бусад аливаа татварын хөнгөлөлтийг үзүүлээгүй болно.		
23	2	2	<p align="center">Чиглэл өгөх тухай 2017-06-30 Дугаар 2017 №07 ЭЗБХ</p> <p>1.1/. Зээлийн ерөнхий хэлэлцээрүүдийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн явц, хэрэгжилтийн талаар хагас жил тутам Байнгын хороонд мэдээлэл хийж байх;</p>	БНЭУ-ын Эксим банкны санал болгосон компаниудын дунд Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах компанийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017.05.26-ны өдрийн Б/208 тоот тушаалаар байгуулагдсан "Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, хэлэлцээр хийх" ажлын хэсэг 2017.06.06-ны өдөр "Газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах шугам хоолой"-н нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл боловсруулахаар шалгарсан БНЭУ-ын Зөвлөх болох EIL компанийн төлөөлөгч нартай холбогдох уулзалтыг зохион байгуулж, гэрээний төсөл болон бусад асуудлуудаар хэлэлцээр хийсэн. Улмаар УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдлын байнгын хороодоор тус тус хэлэлцүүлж, Монгол Улсын Засгийн газарт БНЭУ-ын Экспорт-Импорт банкаар дамжуулан олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн зориулалтыг "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэхийг Байнгын хороод дэмжсэний дагуу тус хуулийн төслийг Монгол Улсын Их хуралд өргөн барьж 2017.05.31-ний өдрийн УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн соёрхон баталсан. Төслийн хэрэгжилтийн явц, холбогдох танилцуулга мэдээллийг тухай бүр ЗГХЭГ-т танилцуулж байна.	100%	Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.
24	2	3	1.2/. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Экспорт-Импорт банк хоорондын 1 тэрбум ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн нарийвчилсан техник эдийн засгийн	ЗГ-ын тэмдэглэлийн дагуу уг асуудлыг УИХ-ын Эдийн засгийн, Төсвийн, Аюулгүй байдлын Байнгын хороодоор хэлэлцүүлж дэмжүүлсэн. Монгол Улсын Засгийн газарт БНЭУ-ын Экспорт-Импорт банкаар дамжуулан олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн зориулалтыг "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэхийг Байнгын хороод дэмжсэний дагуу хуулийн төслийг Монгол Улсын Их хуралд өргөн барьж 2017.05.31-ний өдрийн УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн соёрхон баталсан.	100%	Зээлийн хэлэлцээрийг соёрхон баталсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.

			үнэлгээ, зээлийн эдийн засгийн үр нөлөө, эргэн төлөгдөх нөхцөл болон төслийн хэрэгжилтийн явцын талаар хэрэгжилтийг ханган ажиллаж буй холбогдох яамд, байгууллагууд Байнгын хорооны хуралдаанд танилцуулах.			
25	3	4	<p>Чиглэл өгөх тухай 2018-10-30</p> <p>Дугаар 2018 №32 ЭЗБХ</p> <p>2.2/. Газрын тосны зарим төрлийн бэлэн болон завсрын бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах, экологийн ангилал, импортолж байгаа боомтоос хамааруулан автобензин, дизелийн гүлшний албан татварыг ялгавартай тогтоох, шатахууны үнийн огцом хэлбэлзлийг онцгой албан татварын хувь хэмжээгээр тухай бүр шуурхай зохицуулах зэрэг асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;</p>	Тус заалтын хэрэгжилтийг хангах, автобензин, дизелийн түлшний Онцгой албан татварыг чанар, стандарттай уялдуулан, импортолж буй боомтоос хамааруулан ялгавартай тогтоох, зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд Онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд тус яамнаас Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2017 оны 12 дугаар сар, 2018 оны 12 дугаар сар, 2019 оны 03 дугаар сар, 2020 оны 11 дүгээр сар, 2021 оны 1 дүгээр сард тус тус Сангийн яаманд албан бичгээр явуулж, эрхлэх асуудлын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх саналыг хүргүүлж ажилласан. СЯ-аас тухай бүр дэмжих боломжгүй хариу ирүүлж байсан. Тухайлбал 2021.01.05-ны өдрийн 4-2/04 албан бичгээр тус асуудал нь Засгийн газрын тухай хуулийн 20.4.6-д заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудалд хамаарахыг анхааруулж, уг саналыг цар тахлын эдийн засгийн үед авч үзэх боломжгүй тухай хариу ирүүлсэн.	100%	Тогтоолын дагуу УУХҮЯ-наас шалтгаалах холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.
26	3	5	2.4/. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн олон талт эх үүсвэртэй байх бодлого баримтлах, Гашуунсухайт-Ганц модны боомтоор шатахуун импортлох ажлыг эхлүүлэх.	Манай улс БНХАУ-аас бага хэмжээний газрын тосны бүтээгдэхүүнийг зөвхөн Замын-Үүд боомтоор импортолж байгаа ба 2018 онд 52.6 мянган тонн, 2019 онд 53.58 мянган тонн, 2020 онд 75.0 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүн тус тус импортолсон. БНХАУ-ын нийлүүлэгч "Чайна Ойл" компани болон Монголын шатахуун импортлогч компаниуд 2016 оноос Ганц Мод-Гашуун сухайт боомтоор шатахуун нийлүүлэх, импортлох талаар хэлэлцээр хийж бэлтгэл ажлыг хангах явцад Хятадын талын холбогдох байгууллагаас Ганц модны боомт дээр аюултай бүтээгдэхүүн тээвэрлэх автомашины тусгай зогсоол, гарах терминал байгуулах шаардлагатай гэсэн тул түр хугацаагаар хойшлуулсан. БНХАУ-ын "Чайна Ойл" компаниас 2018 оны 07 дугаар сард Гашуун сухайт боомтоор газрын тосны бүтээгдэхүүн Монгол Улс руу экспортлох асуудал нааштайгаар шийдвэрлэгдэж байгааг мэдэгдсэн. Үүнтэй холбогдуулан Өмнөговь аймгийн Гашуун сухайт, Шивээ хүрэнгийн боомтоор автоцистернээр шатахуун импортлоход тухайн боомтуудын хил, гаалийн нөхцөл байдал, тусгай терминал байгуулах шаардлагатай эсэх, тээвэрлэлтийн асуудлаар ЗТХЯ, ГЕГ, Автотээврийн үндэсний төв	70%	

			<p>зэрэг газруудаас тодруулга мэдээлэл авсан. Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай хоёр улсын Зам, тээврийн яам хоорондын протоколд улс хоорондын аюултай ачаа тээвэрлэлтэд гүйцэтгэхэд “F” төрлийн онцгой зөвшөөрөл авахаар заасан ба тус зөвшөөрлийг Автотээврийн үндэсний төвөөс олгож байгаа талаар ЗТХЯ-наас, Гашуунсухайт боомтоор шатахуун импортлоход гаалийн байгууллагын хүний нөөц, гаалийн хяналтын бүсийн нөхцөл шаардлага, эрх зүйн зохицуулалтын хувьд хүндрэл гарахгүй, бүх төрлийн шатахууны гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардлагатай гаалийн лаборатори одоогоор байхгүй байгаа боловч 2019 оны төсөвт тус боомтод гаалийн лаборатори байгуулахаар тусгагдсан талаар ГЕГ-аас мэдэгдсэн. Гашуунсухайт-Ганцмод боомтоор газрын тосны бүтээгдэхүүн импортлох асуудлаар 2019 оноос эхлэн БНХАУ-ын гол нийлүүлэгч Чайна ойл ХХК-тай удаа дараа уулзалт хэлэлцээр хийж, хил гаалийн бүрдүүлэлт, тээвэрлэлттэй холбоотой зөвшөөрөл, бичиг баримтын бүрдлийг хангах чиглэлээр тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Энэ хүрээнд М-Ойл компани болон Чайна ойл компаниудын хооронд байгуулсан шатахуун худалдах, худалдан авах гэрээний дагуу 2019 онд хятадын талын шатахуун тээврийн 4 автоцистернд хоёр талын тээврийн байгууллагаас холбогдох зөвшөөрлийг авсан боловч Хятадын талын боомтын аюултай ачаанд хяналт хийх талбайн бүтээн байгуулалттай холбоотойгоор тус асуудал түр хойшилсон. 2021 оны 2 дугаар сард Хятад талын нийлүүлэгч Чайна ойл ХХК-тай хоёр талын газрын тосны бүтээгдэхүүний чиглэлийн хамтын ажиллагаа, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөлдөх цахим уулзалтыг зохион байгуулсан. Тус уулзалтын үеэр Гашуунсухайт-Ганц мод, Шивээхүрэн-Сэхэ, Булган-Такашкен болон бусад боомтуудаар шатахуун нийлүүлэх, импортлох боломж, нөхцлийн талаар хэлэлцэж, мэдээлэл солилцсон. Хятадын талаас Гашуунсухайт-Ганц мод боомтоор дизелийн түлш экспортод гаргах, нэвтрүүлэх асуудал шийдэгдсэн ба одоогоор “КОВИД-19” цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор түр хүлээлтийн байдалд байгаа талаар мэдээлэл хийсэн. Булган-Такашкен боомтын хувьд өнгөрсөн жил хил, гаалийн бүрдүүлэлттэй холбоотой ажлууд хийгдсэн ба улс хоорондын аюултай ачаа тээвэрлэх “F” төрлийн зөвшөөрөл авах ажил хийгдэж байна. Энэ хүрээнд тус боомтоор шатахуун импортлохтой холбогдуулан “Шунхлай” ХХК, “М-Ойл” ХХК-ууд улс хоорондын аюултай ачаа тээвэрлэх “F” төрлийн зөвшөөрөл авах хүсэлтээ 2021 оны 4 дүгээр сард Автотээврийн үндэсний төвд гаргаж зөвшөөрөл авсан. Энэхүү зөвшөөрлийн хүрээнд 2021 оны 5 дугаар сард 6 автоцистернээр туршилтын тээвэрлэлт хийж, евро-5 стандартын дизелийн түлш импортлосон. Мөн Хятадын талаас Ханги-Мандалын боомтоор</p>		
--	--	--	--	--	--

				шатахуун нийлүүлэх боломжтой талаар мэдэгдсэн ба манай талаас тус асуудлыг судалж байна.		
27	3	6	3.. Тогтоолын хэрэгжилтийг 2019 оны нэгдүгээр улиралд багтаан Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/-нд даалгасугай.	Автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг чанар, стандарттай уялдуулан, боомтоос хамааруулан ялгавартай тогтоох, зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд Онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2019.09.07-ны өдрийн 01/2545 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.	100%	Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.
2.г. Ерөнхийлөгчийн зарлиг						
2.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл						
2.е. Засгийн газрын тогтоол						
28	1	1	Шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2020-01-08 Дугаар 2020_14 2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан охин компанийг байгуулах, түүнд хөрөнгө оруулах, бүтээгдэхүүн нийлүүлэх сонирхол илэрхийлсэн гадаадын хөрөнгө оруулагчтай хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулж, дүнг 2020 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай.	2. Засгийн газрын 2020.01.08-ны өдрийн 14 дүгээр тогтоол, мөн өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.04.21-ний өдрийн А/81 тушаалыг үндэслэн төрийн өмчит "Эрчис ойл" ХХК-ийг үүсгэн байгуулсан. Төрийн өмчит Эрчис Ойл ХХК-д хөрөнгө оруулж, хамтран ажиллах санал ирүүлсэн ОХУ-ын хөрөнгө оруулагчтай хэлэлцээр хийх ажил явагдаж байна. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.03.26-ны өдрийн А/56 дугаар тушаалаар "Эрчис Ойл" ХХК-д хөрөнгө оруулах, хамтран ажиллах, гэрээ хэлэлцээ хийх талаар санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа ба ажлын хэсгийн хүрээнд ЗТХ-ийн дэд сайд Ж.Бат-Эрдэнэ, Буянт-Ухаа олон улсын нисэх онгоцны буудлын дарга Н.Мягмарсүрэн, ИНЕГ-ийн харьяа үйлчилгээний албаны холбогдох хүмүүстэй уулзалтуудыг зохион байгуулж холбогдох асуудлаар санал солилцсон. Ковид 19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор хөрөнгө оруулагч талтай хийх уулзалт, хэлэлцээрүүд хойшлоод байна.	70%	
29	2	2	Журам батлах тухай 2021-03-17 Дугаар 2021_68 2. "Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай. 2. Газрын тосны бүтээгдэхүүний	Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг сэлгэн хадгалах гэрээний үлгэрчилсэн загвар, мэдээ тайлангийн маягтын загварыг УУХҮ-ийн сайдын 2021.04.28-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар баталсан. Тус тушаал, журмын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллах тухай 2021.04.30-ны өдрийн 01/1150 тоот албан бичгийг АМГТГ-т хүргүүлсэн ба журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	100%	

			улсын нөөц бүрдүүлэх журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгасугай.		
30	3	3	<p>Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2021-03-24 Дугаар 2021_74</p> <p>1. Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлт, Оросын Холбооны Улсаас нийлүүлж буй шатахууны импортын үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор дотоодын зах зээл дээр борлуулж буй шатахууны хангамж доголдож болзошгүй нөхцөл байдал үүссэн тул өргөн хэрэглээний АИ-92 автобензиний хангамжийн тогтвортой байдлыг хангах ажлын хүрээнд тус бүтээгдэхүүний улсын нөөцийг 30,000 (гучин мянга) тонноор нэмэгдүүлэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т тус тус үүрэг болгосугай.</p>	Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүн худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу улсын нөөцийг нэмэгдүүлэх АИ-92 төрлийн автобензиний худалдан авалтын ажлыг зохион байгуулахыг төрийн өмчит “Монгол ГТБҮ” ТӨХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл болон “Эрчис ойл” ХХК-нд чиглэл болгож, худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулаад байна.	30%
31	3	4	3. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг 2022 онд нэмж бүрдүүлэхэд шаардагдах зардлын санхүүжилтийг Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд	Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг 2022 онд нэмж бүрдүүлэхэд шаардагдах зардлын санхүүжилтийг Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах саналыг боловсруулан 2021.05.31-ний өдрийн 01/1380 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.	100%

үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус даалгасугай.

2.ё. Ерөнхий сайдын захирамж

2.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл

32	1	1	<p>2020 оны 2 дугаар сарын 12-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2020-02-12 Дугаар 2020_9</p> <p>XVI.5. . Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн хуралдаанаас Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт нийлүүлэх дотоодын түүхий тосыг дамжуулах хоолойгоор тээвэрлэхээр шийдвэрлэсэнтэй холбогдуулан төслийн санхүүжилтийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцсөний үндсэн дээр дамжуулах хоолойн санхүүжилтийг шийдвэрлэх санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.</p>	<p>Засгийн газрын 2020.02.19-ний өдрийн хуралдаанаар Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий тосыг тээвэрлэх дамжуулах хоолойн дэд бүтцийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар танилцуулга хийж 11 дүгээр тэмдэглэл гаргуулсан. Дээрх шийдвэрийн дагуу тус яамнаас дамжуулах хоолойн санхүүжилтийн талаар санал боловсруулж ЗГ-ын хуралдаан танилцуулж өгөх хүсэлтийг УУХҮ-ийн сайдын 2020.02.17-ны өдрийн 01/464 дугаар болон 2020.04.10-ны өдрийн 01/1002 дугаар албан бичгүүдээр Сангийн сайдад хандсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021.01.25-ны өдрийн А/08-р тушаалаар "Түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж, барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах" Үнэлгээний хороо байгуулагдсан. Мэргэжил, санхүүгийн чадавхитай олон улсын компаниудыг тендерт оролцуулах зорилгоор урьдчилсан сонголтын урилгын зарыг АНУ-ын "Gulf Publishing" компанийн "Pipeline and Gas Journal" сэтгүүл болон вебсайтад нийтэлсэн бөгөөд урьдчилсан сонголтонд 9 улсын 22 компани оролцох хүсэлтээ ирүүлсэн. Эдгээрээс шалгуур хангасан 15 компанид тендерийн баримт бичгийг 2021.04.23-ны өдөр хүргүүлсэн ба тендерийг баримт бичгийг 2021.05.23-ны өдрийн дотор ирүүлэх мэдэгдлийг хүргүүлсэн. Тендерийн урьдчилсан сонголтаар тендерт оролцох нөхцөл хангасан нэр бүхий 6 компаниас 2021.04.30-ны өдрийг хүртэлх хугацаанд техник, технологийн шийдлийг тооцоолох, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд нэг сар хангалтгүй гэсэн шалтгаанаар тендер ирүүлэх хугацааг сунгах хүсэлт гаргасан. Тендерийн үнэлгээний хороо нь хүсэлтийг харгалзан үзэж тендер хүлээн авах хугацааг 2021.06.23 болгож 1 сараар сунгасан.</p>	70%
33	2	2	<p>2020 оны 2 дугаар сарын 19-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2020-02-19 Дугаар 2020_11</p> <p>XIX.1. . Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий тосыг тээвэрлэх дамжуулах</p>	<p>Уг тэмдэглэлийн дагуу тус яамнаас дамжуулах хоолойн санхүүжилтийн талаар санал боловсруулж ЗГ-ын хуралдаанд танилцуулж өгөх хүсэлтийг УУХҮ-ийн сайдын 2020.02.17-ны өдрийн 01/464 дугаар тоотод хандсан. СЯ-ны 2020.03.03-ны өдрийн 8-3/1247 тоотод уг төсөл нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан байх шаардлагыг хангаагүй тул Өрийн удирдлагын тухай хуулийн 33.11-д заасныг үндэслэн өрийн баталгаа гаргахгүйгээр шийдвэрлэх талаар хариу ирүүлсэн. Дээрх тоотын хариуг 2020.04.10-ны өдрийн 01/1002 дугаар тоотод ЗГ-ын 2019 оны 290 дүгээр тогтоолоор уг төсөл нь Улсын</p>	70%

			<p>хоолойн дэд бүтцийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг дор дурдсан Засгийн газрын гишүүдэд даалгав: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт: 2.1. Санхүүгийн эх үүсвэр шийдэгдэж, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэний дараа бүтээн байгуулалтын ажлыг удирдан зохион байгуулах.</p>	<p>хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан тул зохих дэмжлэг үзүүлэх хүсэлтийг Сангийн сайдад хүргүүлсэн. Газрын тос дамжуулах хоолойг барих төслийн хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтын урилга, туршлагын талаарх маягтуудад санал авахаар 2020.12.04 өдрийн 01/2971 тоотойр СЯ-нд хандаж саналыг 2020.10.04 өдрийн 6-1/7563 тоотойр авсан. Мөн газрын тос дамжуулах хоолойг барих төслийн хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах танилцуулгыг 2020.12.09-ний өдрийн ЗГ-ын хуралдаанд танилцуулж тэмдэглэл гаргуулсан.</p>		
34	2	3	<p>Үй.5. . Мөнгөл Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулсан “Зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1)-ыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулж, түүнтэй хэлэлцээ хийж дууссан талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажлыг сонгон шалгаруулалтын нөхцөл, хэлэлцээний үр дүн, зайлшгүй шаардлагатай бусад шаардлагыг харгалзан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гэрээ байгуулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд</p>	<p>Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1)-ын ерөнхий гүйцэтгэгчээр шалгарсан БНЭУ-ын “JMC Projects (India) Ltd” компанитай 2020.10.13-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.</p>	100%	<p>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>

			Г.Ёндон, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нарт даалгав.		
35	3	4	<p>2020 оны 12 дугаар сарын 23-ны өдөр 73 дугаар тэмдэглэл 2020-12-23</p> <p>Дугаар 2020_73</p> <p>XIX.4. . Стратегийн ач холбогдол бүхий өргөн хэрэглээний АИ-92 автобензинийн үнийг тогтвортой хадгалах зохицуулалтын хүрээнд санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан үнийг тогтворжуулах гэрээний хэрэгжилт болон олон улсын зах зээл дээрх үнийн өсөлтөөс шалтгаалан, дотоодод үүсэх эрсдэлийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан өргөн хэрэглээний АИ-92 автобензиний жижиглэнгийн үнийг тогтворжуулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт даалгав.</p>	<p>Санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан бүх төрлийн шатахуун, дизель түлшний жижиглэнгийн үнийг тогтворжуулах боломж нөхцлийг судлах, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, дүнг тухай бүр танилцуулж ажиллах чиглэл хүргэх тухай 2020.12.03-ны өдрийн 01/2963 тоот албан бичгийг боловсруулж, АМГТГ-т хүргүүлсэн.</p> <p>Мөн газрын тосны бүтээгдэхүүний хангамж, гадаад зах зээлийн нөхцөл байдал, жижиглэн борлуулалтын үнийн талаарх асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, холбогдох танилцуулгыг нэгтгэн боловсруулж, УУХҮСайдын 2021.03.01-ний өдрийн 01/460 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p>	70%
36	4	5	<p>2021 оны 2 дугаар сарын 14-ний өдөр 10 дугаар тэмдэглэл 2021-02-14</p> <p>Дугаар 2021_10</p> <p>I.2. 14. Эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдолтой төслүүдийг тодорхойлж Засгийн газрын 2 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд</p>	<p>Эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдолтой төслүүдийг тодорхойлж, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбараас оруулах төсөл, арга хэмжээний саналыг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн.</p>	100%

			Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан нарт;			
37	4	6	I.2. 19. Халдварт цар тахлын хүндрэлтэй нөхцөлд бүх төрлийн шатахуун, дизель түлшний жижиглэнгийн үнийг нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд;	Засгийн газрын 2021.02.14-ний өдрийн 10 дугаар тэмдэглэлийн 19 дүгээр заалтын дагуу газрын тосны бүтээгдэхүүний хангамж, гадаад зах зээлийн нөхцөл байдал, жижиглэн борлуулалтын үнийн талаарх асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, холбогдох танилцуулгыг бэлтгэж, УУХҮСайдын 2021.03.01-ний өдрийн 01/460 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.	100%	
38	4	7	I.2. 21. Хариуцсан салбартаа тулгамдаж байгаа асуудалтай газар дээр нь биечлэн танилцаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд.	Тус салбарт нэн яаралтай тулгамдаж байгаа асуудалгүй бөгөөд шийдвэрлэж болохуйц асуудалд тухай бүр арга хэмжээ авч ажиллаж байна.	100%	
39	5	8	2021 оны 3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03 Дугаар 2021_14 XII.4. 4. Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тос дамжуулах хоолой барих санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, сонгон шалгаруулалтыг шуурхай зохион байгуулж, тус бүтээн байгуулалтын ажлыг ойрын үед эхлүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт, Газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай түүхий эдийг ОХУ болон бусад улсаас нийлүүлэх боломжийг судлахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд;	УУХҮЯ-ны ТНБД-ын 2021.01.25-ны өдрийн А/08 дугаар тушаалаар тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, барих гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулах ажлыг зохион байгуулах Үнэлгээний хороог байгуулж, үнэлгээний хороо олон улсын сонгон шалгаруулалтын зарыг "Pipeline and Gas journal" сэтгүүлийн 2021.03.01-ний өдрийн дугаарт нийтлүүлсэн. Урилгын дагуу сонирхсон компаниудын саналыг 2021.03.25-ны өдрөөр тасалбар болгож санал ирүүлсэн 9 орны 24 компаниас 21-ийг хураангуй жагсаалтад оруулсан. Сонгон шалгаруулалтыг 2021.06.23-ны өдөр зохион байгуулахаар ажиллаж байна.	30%	
40	6	9	2020 оны 3 дугаар сарын 19-ний өдөр 18 дугаар тэмдэглэл 2020-03-19 Дугаар 2020_18	1. ОХУ-ын "Роснефть" компаниас нийлүүлж буй шатахууны 2020 оны 04 дүгээр сарын хилийн үнэ өмнөх сартай харьцуулахад А-80, Аи-92, Аи-95, Аи-98 автобензин тонн тутамдаа 209 ам.доллар, дизелийн түлш тонн тутамдаа 187 ам.доллараар буурсан ба А-80 автобензин 330 ам.доллар/тн, Аи-92 автобензин 360 ам.доллар/тн, Аи-95 автобензин	100%	

			<p>III.2. . Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т даалгав: 1. Дэлхийн зах зээл дээр түүхий газрын тосны үнэ буурч байгаатай холбогдуулан Монгол Улсад шатахууны жижиглэнгийн үнийг үе шаттайгаар бууруулах; 2. Шатахууны үнэ хямд байгаа үед шатахууны улсын нөөцийг нэмэгдүүлэх талаар зохих арга хэмжээ авах.</p>	<p>430 ам.доллар/тн, Аи-98 автобензин 480 ам.доллар/тн, дизелийн түлш 369 ам.доллар/тн болж тус тус буурсан. Үүнтэй холбоотойгоор 4 дүгээр сарын 13-наас эхлэн шатахууны худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүд шатахууны жижиглэнгийн үнийг 300-350 төгрөгөөр үе шаттайгаар бууруулсан ба шатахууны жижиглэнгийн үнэ дунджаар А-80 автобензин 1390 төгрөг, Аи92 автобензин 1470 төгрөг, Аи95 автобензин 2000 төгрөг, ДТ 2150 төгрөг болж тус тус буурсан. Шатахууны улсын нөөцийг нэмэгдүүлэхтэй холбогдуулан “Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журам”-ыг Засгийн газрын 2021.03.17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн ба 68 дугаар тогтоолоор журмыг баталсан. Мөн газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх асуудлыг Засгийн газрын 2021.03.24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн, 74 дүгээр тогтоолоор улсын нөөцийг 30000 тонноор нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна.</p>		
41	7	10	<p>2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр 58 дугаар тэмдэглэл 2020-11-04 Дугаар 2020_58</p> <p>ХҮ1.2. ". Монгол Улсын Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, газрын тос дамжуулах хоолойн төслийн техникийн даалгаврыг боловсруулах, сонгон шалгаруулалт зарлах боломжтой эсэхийг судлан танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК (Д.Алтанцэцэг) нарт;</p>	<p>Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт хэрэгжиж буй газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хүрээнд үйлдвэрт шаардагдах дотоодын түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, барих гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулах ажлыг зохион байгуулах Үнэлгээний хороог ТНБД-ын 2021.01.25-ны өдрийн А/08 дугаар тушаалаар байгуулсан. Сонгон шалгаруулалтыг 2021.06.23-ны өдөр зохион байгуулахаар ажиллаж байна.</p>	30%	
42	7	11	<p>ХҮ1.2. 6. Автобензин, дизель түлшний онцгой албан татварыг чанар, стандарттай уялдуулан ялгавартай тогтоох, зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулах чиглэлээр</p>	<p>Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2017 оны 12 дугаар сар, 2018 оны 12 дугаар сар, 2019 оны 03 дугаар сар, 2020 оны 11 дүгээр сар, 2021 оны 1 дүгээр сард тус тус Сангийн яаманд хүргүүлж ажилласан. СЯ-аас тухай бүр татгалзсан хариу ирүүлж байсан бөгөөд 2021.01.05-ны өдрийн 4-2/04 албан бичгээр тус асуудал нь Засгийн газрын тухай хуулийн 20.4.6-</p>	100%	

			Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт;	д заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудалд хамаарахыг анхааруулж, уг саналыг цар тахлын эдийн засгийн үед авч үзэх боломжгүй тухай хариу ирүүлсэн.		
43	7	12	ХҮ1.2.7. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаарх санал, дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт.	Монгол Улсын Ерөнхий сайд УИХ-д газрын тосны салбарын талаар танилцуулга хийхтэй холбогдуулан БХГ-ний хэрэгжилт, салбарын өнөөгийн байдал, хэтийн төлвийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэж, УУХҮСайдын 2021.05.21-ний өдрийн 01/1335 дугаар албан бичгээр Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны дарга Ж.Энхбаярт хүргүүлсэн.	100%	
44	8	13	2020 оны 12 дугаар сарын 9-ны өдөр 69 дугаар тэмдэглэл 2020-12-09 Дугаар 2020_69 ХҮ1.8. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт дотоодын түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, барьж байгуулах гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулах талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан газрын тос боловсруулах үйлдвэрт дотоодын түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, барьж байгуулах гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд олон улсад нээлттэй сонгон шалгаруулж, шалгарсан этгээдтэй байгуулах гэрээний төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул	УУХҮЯ-ны ТНБД-ын 2021.01.25-ны өдрийн А/08 дугаар тушаалаар тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, барих гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулах ажлыг зохион байгуулах Үнэлгээний хороог байгуулж, үнэлгээний хороо олон улсын сонгон шалгаруулалтын зарыг "Pipeline and Gas journal" сэтгүүлийн 2021.03.01-ний өдрийн дугаарт нийтлүүлсэн. Урилгын дагуу сонирхсон компаниудын саналыг 2021.03.25-ны өдрөөр тасалбар болгож санал ирүүлсэн 9 орны 24 компаниас 21-ийг хураангуй жагсаалтад оруулсан. Сонгон шалгаруулалтыг 2021.06.23-ны өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	30%	

			уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгав.			
45	9	14	<p>2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр 17 дугаар тэмдэглэл 2021-03-10</p> <p>Дугаар 2021_17</p> <p>XII.7.6. “Чингис хаан” олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжийн ашиглалтын бэлэн байдлыг хангуулах, агаарын хөлгийн шатахууныг олон эх үүсвэрээс нийлүүлэх болон “Жет А-1” төрлийн түлш импортлох боломжийг судалж шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Иргэний нисэхийн ерөнхий газар (Л.Бямбасүрэн)-т</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 14 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн өмчит “Эрчис ойл” ХХК-тай хамтран Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын шатахуун хангамжийн байгууламжийг ашиглах санал ирүүлсэн хөрөнгө оруулагчтай гэрээ, хэлэлцээр хийх бэлтгэл ажлын хүрээнд гэрээлэгчтэй хамтран ажиллах зарчмыг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮ-ийн сайдын 2021.03.12-ны өдрийн А/50 дугаар тушаалаар байгуулсан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2020.01.08-ны өдрийн шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай 14 дугаар тогтоолын дагуу шинэ олон улсын нисэх буудлын шатахуун хангамжтай холбоотой үйл ажиллагааг эрхлэх зорилгоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн дэргэд “Эрчис ойл” ХХК-ийг 2020.04.22-ны өдөр үүсгэн байгуулсан. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021.03.15-ны өдрийн А/50 тушаалаар төрийн өмчит “Эрчис ойл” ХХК-тай хамтран “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын шатахуун хангамжийн байгууламжийг хамтран ашиглах санал ирүүлсэн гадаадын хөрөнгө оруулагчтай гэрээ, хэлэлцээр хийх бэлтгэл ажлын хүрээнд гэрээлэгчтэй хамтран ажиллах зарчмыг тодорхойлох үүрэг бүхий ХЗДХЯ, УУХҮЯ, ЗТХЯ, ИНЕГ, “Эрчис ойл” ХХК-уудын төлөөлөл бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг уг шатахуун хангамжийн байгууламжийг ашиглаж болох боломжит 4 хувилбарыг боловсруулснаас МУ-д ашигтай нэг хувилбарыг сонгон ОХУ-ын “РН-Аеро” ХХК-тай хийх гэрээ, хэлэлцээрийг 6 дугаар сард эхлүүлэхээр төлөвлөөд байна.</p>	30%	
	19	30	Газрын тосны бодлогын дундаж: 81.3 хувь			

САЛБАР ЧИГЛЭЛ: 3. УУЛ УУРХАЙН БОДЛОГО

3.а. Монгол Улсын хууль

46	1	1	<p>Ашигт малтмалын тухай /Шинэчилсэн найруулга/ 2006-07-08</p> <p>Дугаар 2006.08.26</p> <p>3.2.. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг журмаар зохицуулах</p>	<p>Засгийн газрын 2017.05.24-ний өдрийн 151 дугаар тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” батлуулж, мөрдөж байна. Бичил уурхайн эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч хууль бусаар ашигт малтмал олборлох, бичил уурхайн эрх зүйн орчныг буруугаар ашиглах явдал байсаар байна. Сум, дүүргийн засаг дарга нар эрх мэдлээ хэтрүүлэн дүгнэлт гараагүй талбайд гэрээ байгуулах, журманд тусгасан тоног төхөөрөмжийн хүчин чадлыг хэтрүүлэн ажиллуулах зэргээр бичил</p>	100%	
----	---	---	---	---	------	--

			бөгөөд уг журмыг Засгийн газар батална.	уурхайн журмыг дагаж мөрдөхгүй байгаа нь журмын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Дээрх хууль бус асуудлыг зохицуулах, улмаар таслан зогсоох талаар Засгийн газраас удаа дараа арга хэмжээ авч хэрэгжүүлсэн боловч тодорхой үр дүнд хүрээгүй. 2019.09.18-ны өдөр 355 дугаар “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай”, 2020.01.15-ны өдрийн 17 дугаар “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнд тавих хяналтыг сайжруулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолууд тус тус гарсан. Засгийн газрын 355 дугаар тогтоолын 1.1 -д “Бичил уурхай эрхлэгч этгээдэд тавигдах шаардлагыг хангахгүй болсон, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй этгээдийн гэрээг цуцлах, бичил уурхайн зориулалтаар ашигт малтмал олборлох дүгнэлт гарсан талбайд бичил уурхай эрхлэх гэрээ шинээр байгуулахгүй байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга даалгасан”-аас үүдэн бичил уурхайн гэрээ одоог хүртэл шинээр байгуулахгүй байгаа. Засгийн газрын 17 дугаар тогтоолтой холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.11.09-ний өдрийн А/279 дугаар тушаалаар “Бичил уурхайн зохицуулалтын талаар” Ажлын хэсэг байгуулагдан журмын шинэчлэл дээр ажиллаж байна.		
47	1	2	10.1.14. уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;	УУХҮС, БОАЖС-ын 2019 оны А/181, А/458 дугаар тушаалаар журмыг хамтран баталсан бөгөөд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4530 дугаарт бүртгүүлсэн.	100% Журмыг батлуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.	
48	2	3	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай 2009-07-16 Дугаар 2009.07.16 4.6.. Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцлахдаа уг тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор төлөх бөгөөд холбогдох журмыг Засгийн газар тогтооно.	Монгол улсын Засгийн газрын 2010.11.17-ны өдрийн 299 дүгээр тогтоолоор “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд нөхөх олговор олгох журам”-ыг баталсан.	100% Журмыг батлуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.	

49	3	4	<p>Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай /Шинэчилсэн найруулга/ 2013-01-31 Дугаар 2013.03.04</p> <p>6.3.. Мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагын болон шинжээчийн эрх олгох, сунгах, хүчингүй болгох журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/80 дугаар тушаалаар “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, “Пиротехникийн хэрэгслийг импортлох, ашиглах дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах, “Монгол Улсын нутагт дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт”-ыг тус тус боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулсан. Ажлын хэсгийн хүрээнд дүрмийн төслийг боловсруулахаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Багануур” ХК, “Оюутолгой” ХХК-ийн үйлдвэрлэлийн баазыг түшиглэн ажлын хэсэг вакуум орчинд ажиллан дүрмийн төслийг боловсруулсан. Мөн “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг 2018.10.09-ний өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан ёсны вэб сайт http://mmhi.gov.mn/public/forum/id/639-д олон нийтийн санал авахаар байршуулсан ба төслийн хэлэлцүүлгийг Тэсэлгээний ажил, үйлчилгээ эрхлэгчдийн холбоотой хамтран 2018.11.19-ний өдөр Нийслэлийн захиргааны V байрны ХАБ Иновацийн төвийн хурлын танхимд 45 орчим оролцогчтойгоор зохион байгуулсан. “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Засгийн газрын тогтоолын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг боловсруулсан. Мөн дүрмийн төслийн танилцуулга болон нөлөөллийн шинжилгээний тайланг боловсруулсан. Тогтоолын төсөлд санал авахаар яам, агентлагт хүргүүлэхээр бэлтгэж байна.</p>	100%	
50	3	5	<p>17.3.. Монгол Улсад ашиглах үзвэрийн болон хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийн жагсаалтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/80 дугаар тушаалаар “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, “Пиротехникийн хэрэгслийг импортлох, ашиглах дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах, “Монгол Улсын нутагт дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт”-ыг тус тус боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулсан.</p>	30%	
51	3	6	<p>17.6.. Пиротехникийн хэрэгслийн мэргэжилтний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/80 дугаар тушаалаар “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, “Пиротехникийн хэрэгслийг импортлох, ашиглах дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах, “Монгол Улсын нутагт дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт”-ыг тус тус боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулсан.</p>	30%	
52	3	7	<p>5.2.. Засгийн газар энэ хуулийн 5.1.5-д заасан жагсаалтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв</p>	<p>Жагсаалтыг Засгийн газрын 2021 оны 128 дугаар тогтоолоор, 2021.05.05-ны өдөр батлуулсан.</p>	100%	

			байгууллагын саналыг үндэслэн жил бүр шинэчлэн тогтооно. (5.1.5.Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалтыг батлах;)		
53	3	8	5.1.2.. 5.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн асуудлаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг батлах;	“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлуулсан.	100% Дүрмийг батлуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.
54	3	9	Хог хаягдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-05-12 Дугаар 2017.05.12 8.6.2.. 8.6.Хог хаягдлын талаар уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.6.2. Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих;	“Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам”-ын төслийг боловсруулан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.04.27-ны өдрийн А/87 дугаар тушаалаар баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 2020.05.15-ны өдрийн 4797 дугаарт бүртгүүлсэн.	100% Журмыг батлуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.
3.б. Улсын Их Хурлын тогтоол					
55	1	1	Хуулийн төслүүд буцаах, үндсэн зарчим, удирдамж батлах тухай 2008-12-04 Дугаар 2008 №40 3.1/. Таван толгойн нүүрс, Оюу толгойн зэс-алтны ордыг хамтарч ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний төслүүдийг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж болон энэ тогтоолын хавсралтуудад нийцүүлэн боловсруулах,	Тавантолгой нүүрсний ордод 2014 онд зарласан хөрөнгө оруулагчийг шалгаруулах уралдаант шалгаруулалтад БНХАУ-ын “Чайна Шенхуа Энержи” ТӨК, Японы “Сүмитомо корпораци” болон Монголын “Mongolian Mining Corporation” компанийн хамтарсан консорциум шалгарсан. Улмаар Засгийн газраас Улсын Их Хуралд дээр дурдсан консорциумтай байгуулах холбогдох гэрээний төслүүдийг бэлтгэн 2015. 04.23-ны өдөр өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын даргын 2015 оны 101 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс гэрээний төслийг судлан дүгнэлт гаргаж, Засгийн газарт буцаах шийдвэр гаргасан.	100% Цаашид Сангийн яамнаас биелэлтийг гаргуулах САНАЛТАЙ БАЙНА.

			шаардлагатай бол холбогдох хуулийн зохих зүйл, заалтад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамт боловсруулж 2009 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; (3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай.)			
56	1	2	1.2/. Хөрөнгө оруулалтын гэрээний төслүүдийг боловсруулах болон хэлэлцээ хийх ажлыг ил тод явуулж, уг ажлын явцыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд тухай бүр танилцуулж байх. (3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай.)	Тавантолгой нүүрсний ордод 2014 онд зарласан хөрөнгө оруулагчийг шалгаруулах уралдаант шалгаруулалтад БНХАУ-ын “Чайна Шенхуа Энержи” ТӨК, Японы “Сүмитомо корпораци” болон Монголын “Mongolian Mining Corporation” компанийн хамтарсан консорциум шалгарсан. Улмаар Засгийн газраас Улсын Их Хуралд дээр дурдсан консорциумтай байгуулах холбогдох гэрээний төслүүдийг бэлтгэн 2015.04.23-ны өдөр өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын даргын 2015 оны 101 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс гэрээний төслийг судлан дүгнэлт гаргаж, Засгийн газарт буцаах шийдвэр гаргасан.	100%	Цаашид Сангийн яамнаас биелэлтийг гаргуулах САНАЛТАЙ БАЙНА.
57	2	3	Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай 2009-07-16 Дугаар 2009 №57 2. Оюу толгой ордыг ашиглахтай холбогдуулан хөрөнгө оруулалтын гэрээг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид нийцүүлэн Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 40 дүгээр тогтоолоор баталсан үндсэн зарчим, удирдамж, Эдийн засгийн байнгын хорооны 2009 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн санал, дүгнэлтийг харгалзан байгуулахыг Засгийн газар /С.Баяр/-т зөвшөөрсүгэй.	Ашигт малтмалын тухай хуулийн 29 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын 2008.12.04-ний өдрийн 40 дүгээр тогтоол, 2009.07.16-ны өдрийн 57 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2009.10.06-ны өдрийн 308 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас эрх олгосноор түүнийг төлөөлж Монгол Улсын Сангийн сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Айвенхоу Майнз Монголия Инк ХХК, Айвенхоу Майнз Лимитед, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед хооронд Оюутолгойн ордын Хөрөнгө оруулалтын гэрээг 2009.10.06-ны өдөр байгуулсан.	100%	Гэрээг байгуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.

58	2	4	<p>3. Эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар анхны хөрөнгө оруулалтыг нөхсөний дараа төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг 50-иас доошгүй хувьд хүргэж нэмэгдүүлэх асуудлыг хөрөнгө оруулагчтай тохиролцон шийдвэрлэхийг Засгийн газар /С.Баяр/-т үүрэг болгосугай.</p>	<p>Монгол Улсын Сангийн сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Айвенхоу Майнз Монголия Инк ХХК, Айвенхоу Майнз Лимитед, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед хооронд 2009.10.06-ны өдөр байгуулсан Оюутолгойн ордын Хөрөнгө оруулалтын гэрээний 1.6-д “Төр нь Хөрөнгө оруулагчийн энгийн хувьцааны 34 /гучин дөрөв/ хувийг өмчлөх ба энэхүү Гэрээний хугацааг энэхүү Гэрээний 15.11-д заасны дагуу сунгасан бол ийнхүү сунгаснаас хойш 1 /нэг/ жилийн дотор Хувь нийлүүлэгчдийн гэрээгээр харилцан тохиролцсон нөхцөлөөр Хөрөнгө оруулагчийн энгийн хувьцааны 16 /арван зургаа/ хувийг нэмж өмчлөх сонголт хийх эрхтэй. Энэхүү Гэрээний 1.6 дахь заалт нь Хөрөнгө 4 оруулагчийн хувьцаанаас Төрд хувьцаа нэмж гарган өмчлүүлэх, эсхүл шилжүүлэх талаар хуулийн болон Улсын Их Хурлын тогтоолын дагуу үүсч болох бүх үүргийг хангаж байгааг Засгийн газар баталгаажуулав” гэж тусгасан байна.</p>	100%	Цаашид Сангийн яамнаас биелэлтийг гаргуулах САНАЛТАЙ БАЙНА.
59	3	5	<p>Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2016-09-09 Дугаар 2016 №47</p> <p>1.а/. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх; (1/Төсвийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр:)</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018.02.19-ний өдрийн А/34 тоот тушаалаар байгуулагдсан Стратегийн ордуудын талбайн хил зааг тогтоох ажлын хэсгийн хуралдаанд ажлын хэсгийг 2020.02.18-ны өдөр Стратегийн ордуудын лицензийн хил зааг, солбицол, ордын геологийн тогтоц, нөөц, ашиглалтын мэдээллээр хангаж ажилласан.</p> <p>“Оюу толгойн ордын ашиглалтад Монгол улсын эрх ашгийг хангуулах тухай” Монгол улсын Их хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол улсын Ерөнхий сайдын 2019 оны 174 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх, Монгол улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 23 дугаар тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсэг Оюу толгойн ордын ашиглалтын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх ажлын саналыг 2020.04.16-ны өдөр танилцуулсан. Ажлын хэсгийн хуралдаанд тухай бүр оролцсон.</p> <p>Мөн дээрх ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.02.09-ний өдрийн 45 дугаар захирамжаар, ажлын дэд хэсгийг ХЗДХ-ийн Сайдын 2021.02.24-ний өдрийн А/29 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулаад байгаа бөгөөд УУХҮЯ-наас холбогдох саналуудыг хүргүүлэн хамтран ажиллаж байна.</p> <p>Түүнчлэн Стратегийн ач холбогдол бүхий орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын хүрээнд тус яамнаас Улсын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулна”, “Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэнэ” гэж тусгуулж, батлуулан хэрэгжилтийг хангаж байна.</p>	100%	ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.

60	3	6	1.б/. Төмөр зам, авто зам, уул уурхай, эрчим хүчний томоохон төслүүдийг идэвхжүүлэх замаар эдийн засгийн бусад салбарыг дэмжих; (1/Төсвийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр:)	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолоор батлагдсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын дагуу тус компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн үүргийг гүйцэтгэж байна. Үүнтэй холбоотойгоор Зүүнбаян-Тавантолгой, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замд шаардагдах хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх талаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж чиглэлийг тухай бүр өгч ажиллаж байна. 2021 оны 5 дугаар сарын байдлаар дээр дурдсан төмөр замын төслүүдэд “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас 2.1 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг хийсэн байна.	100%	ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.
61	4	7	Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2016-11-17 Дугаар 2016 №69 2/1.. Коксжих нүүрсний экспортын үнийг дэлхийн зах зээлийн үнийн түвшинтэй нийцүүлэх, нэгдсэн нэг үнээр экспортод гаргах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх; (2/Төсвийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр:)	Дэлхийн зах зээлийн нүүрсний үнэ болон Монгол улсаас экспортод гарч буй нүүрсний үнийг Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоол, 2016 оны 81 дүгээр тогтоол, 2019 оны 342, 465 дугаар тогтоолын дагуу уул уурхайн экспортын бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийн дунджийг тогтоох зарчмаар тооцон олон нийтэд мэдээлдэг. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан бөгөөд бирж байгуулагдсанаар Монгол улсын хэмжээнд экспортод гаргаж байгаа нүүрс нь төрөл тус бүрээрээ нэгдсэн нэг үнээр борлуулагдах ноцол бүрдэх хүлээлттэй байна.	70%	
62	5	8	Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2018-06-29 Дугаар 2018 №73 1.1/. Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “б”, “в”-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд	Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор тус яамнаас “Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” саналыг боловсруулж, Засгийн газрын 2018 оны 296 дугаар тогтоолоор батлуулсан. Улмаар “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн охин компани “Эрдэнэс Тавантолгой Майнинг” ХХК-ийг компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 28 дугаар тогтоолын дагуу байгуулж, үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд нийцүүлэн олон улсын болон дотоодын зах зээлд үе шаттайгаар үнэт цаас гаргах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай зөвлөх үйлчилгээг үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, үйлчилгээ авах гэрээг байгуулан ажиллаж байсан. Гэвч УИХ 2018 оны 73 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр Засгийн газраас баталсан 2019 оны 296 дугаар тогтоолыг 2020 оны 146 дугаар тогтоолоор хүчингүй болгосон тул гадаадын хөрөнгийн биржид үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа зогсонги байдалд орсон.		Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.

			холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх;		
141	21	35	<p>III.2.4. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай үлдэгдэл санхүүжилтийг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэс-Тавантолгой”</p>	<p>Төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэхэд зайлшгүй шаардлагатай хөрөнгийг санхүүжүүлэх хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс “Монголын төмөр зам” ТӨХК-д 2020.10.20-ны өдөр 58,000,000,000 төгрөгийг, “Зүүнбаян төмөр зам” ХХК-д 2020.12.09-ний өдөр 75,000,000,000 төгрөг, “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагааны зардлын 1 дүгээр улирлын 917,875,750 төгрөгийг, 2021.05.17-нд 60,000,000,000 төгрөг, 2021.05.17-нд</p>	70%

			ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д;	40,000,000,000 төгрөгийг нийт 983,917,875,750 төгрөгийн санхүүжилтийг тус тус шилжүүлсэн байх бөгөөд үлдэгдэл санхүүжилтийг тус компанийн 2021 оны төсөвт суулган, төлөвлөгөөний дагуу санхүүжүүлэхээр ажиллаж байна.		
142	22	36	<p>2021 оны 5 дугаар сарын 12-ны өдөр 30 дугаар тэмдэглэл 2021-05-12</p> <p>Дугаар 2021_30</p> <p>ХИХ.5. . Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Өмнөговь аймагт ажилласан талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад даалгав: 1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх замаар “Ногоон бүс” түр журмыг бүрэн хэрэгжүүлж “Гашуунсухайт” боомтын үйл ажиллагааг хэвийн горимд оруулах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт;</p>	<p>Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 2021.04.30-ны өдрийн 38 дугаар тушаалаар Өмнөговь аймгийн нутагт орших Оюутолгой, Тавантолгой, Нарийнсухайтын орд, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам, Цагаан хадны гаалийн хяналтын бүс, хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж, ногоон бүс болгох эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг сахиулахад шаардлагатай арга хэмжээг тодорхойлж, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий Шуурхай бүлгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Батнайрамдалаар ахлуулан байгуулсан.</p> <p>Өмнөговь аймгийн нутагт орших Оюутолгой, Тавантолгой, Нарийнсухайты ордод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам, Цагаан хадны гаалийн хяналтын бүс, Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн авто зам, хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтод Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 38 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд шуурхай бүлгийн бүрэлдэхүүн 2021.05.01-ний өдрөөс 5 дугаар сарын 07-ны өдөр хүртэл томилолтоор ажиллалаа. Томилолтоор ажилласан тайланг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргад 2021.05.17-ны өдрийн 02/1286 албан бичгээр хүргүүлсэн.</p>	70%	
143	22	37	<p>ХИХ.5.3. Монгол Улс, БНХАУ-ын хилийн Гашуунсухайт-Ганцмод төмөр замын боомтын галт тэрэг солилцох технологийн асуудлаар БНХАУ-ын талтай тохиролцсоны үндсэн дээр Гашуунсухайт боомтын 1435 мм-ийн царигтай төмөр замын өртөө, шилжүүлэн ачих байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, тэдгээрийг үе шаттайгаар цогцоор нь барьж</p>	<p>Зам, тээврийн хөгжлийн яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах тул биелэлт гаргах боломжгүй.</p>	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй.	Цаашид ЗТХЯ-наас биелэлтийг гаргуулах САНАЛТАЙ БАЙНА.

			байгуулахад шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх санал боловсруулж Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Т.Цогтбаяр) нарт;			
144	22	38	ХИХ.5.4 . "Тавантолгой-Зүүнбаян" төмөр замын ажлын гүйцэтгэлийн үлдэгдэл санхүүжилтийг үе шаттайгаар шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт.	Тавантолгой-Зүүнбаян" төмөр замын ажлын гүйцэтгэлийн үлдэгдэл санхүүжилтийг үе шаттайгаар шийдвэрлэх хүрээнд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн ТУЗ-өөс 2021 оны 19 дүгээр тогтоолыг баталж, төмөр замын баталгаажсан гүйцэтгэлийн дутуу төлбөр болох 282,612,246,018 "төгрөгийн санхүүжилтийг үе шаттай санхүүжүүлэхийг даалгасан бөгөөд эхний ээлжинд 100,000,000,000 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлээд байна. Тус тогтоолын дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас 5 дугаар сардаа багтаан 100 тэрбум төгрөгийг "Зүүнбаян төмөр зам" ХХК-д олгосон бөгөөд үлдэгдэл 182.6 тэрбум төгрөгийг компанийн санхүүгийн боломжид тааруулан үе шаттай олгохоор ажиллаж байна.	70%	
	56	99	Уул уурхайн бодлогын дундаж: 83.1 хувь			

САЛБАР ЧИГЛЭЛ: 4. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГО

4.а. Монгол Улсын хууль

4.б. Улсын Их Хурлын тогтоол

145	1	1	<p>Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай 2018-11-15 Дугаар 2018 №84</p> <p>2.9/. Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх.</p>	<p>Үнэт металл боловсруулах хамгийн сүүлийн үеийн, инновацийн технологи болох "Вакуум дистилляцийн арга"-ын Патент эзэмшигч БНКаЗУ-ын нэр бүхий компаниар "Үнэт металл боловсруулах үйлдвэр"-ийн ТЭЗҮ хийлгэсэн бөгөөд УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ хэлэлцэх салбар зөвлөлийн 2019.09.09-ний өдрийн СТР/19-01-01 дугаар дүгнэлтээр ТЭЗҮ-ийг хүлээн авсан.</p> <p>Монгол Улсад Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг түлхүүр хүлээлцэх нөхцөлөөр барих гэрээг төсөл хэрэгжүүлэгч "Эрдэнэс алт ресурс" ХХК болон БНКаЗУ-ын "Сымбат Инженеринг" ХХК-ийн хооронд 2019.10.11-ний өдөр БНКаЗУ-д байгуулсан ба гэрээний хугацаа 2020.12.31-ний өдрөөр дуусгавар болсон.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.7.7-д "Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулна" гэж тусгасан ба төслийн бүтээн байгуулалтын ажлыг 2022 оноос эхлүүлэхээр</p>	<p>100%</p> <p>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>	
-----	---	---	--	---	---	--

			<p>төлөвлөсөн. Үйлдвэрийн хүчин чадал, бүтээгдэхүүний нэр төрлийг багасгах замаар төслийн хөрөнгө оруулалтыг бууруулах чиглэлээр олон улсруу хандсан өргөтгөсөн судалгааны ажлыг төсөл хэрэгжүүлэгч компанийн зүгээс хийж байна.</p> <p>Өнөөгийн байдлаар ХБНГУ-ын "Cronimet Mining Processing AG", Швейцар улсын "Argor Heraus SA", Турк улсын "Prosis Makina", БНКаЗ улсын "Сымбат Инженеринг, БНХАУ-ын "Зижин Майнинг" болон "Чинхай групп" зэрэг нийт 6 компаниас үнийн санал, технологийн танилцуулыг авч харьцуулан судалж байгаа бөгөөд дүгнэлт гарсны дараа ҮМЦҮ барьж, ашиглалтад оруулах гүйцэтгэгчийг сонгох юм.</p>		
4.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол					
4.г. Ерөнхийлөгчийн зарлиг					
4.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл					
4.е. Засгийн газрын тогтоол					
146	1	1	<p>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай 2017-03-15 Дугаар 2017_88</p> <p>2. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний талаар хэлцэл хийх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажлын явц, үр дүнг Засгийн газарт тухай бүр танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт даалгасугай.</p>	30%	
147	1	2	<p>3. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүй эзэмших асуудлыг зөвшөөрч, төрийн төлөөллийг зохих журмын дагуу хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч</p>	70%	

			ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт даалгасугай.	боловсруулах тендерийн баримт бичгийн төслийг Монгол Өмгөөлөл хуулийн фирмийн зөвлөх үйлчилгээний тусламжтайгаар боловсруулаад байна. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийг Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид үндэслэн Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкнаас гаргасан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаарх зөвлөмж, урьдчилсан сонгон шалгаруулалтын талаарх жишиг баримт бичигт үндэслэн боловсруулсан.		
148	2	3	<p align="center">Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төслийн тухай 2017-08-17</p> <p align="center">Дугаар 2017_232</p> <p>1.. Өмнийн говьд байгуулагдах томоохон бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, дэд бүтцийн болон бусад төслүүдийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх "Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төсөл"-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгасугай.</p>	Говийн бүсэд хэрэгжих төслүүдийн усны асуудлын талаар болон Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан "Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх Онги, Хэрлэн усан цогцолборын төслийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж бүтээн байгуулалтыг эхлүүлнэ." зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээлэл ирүүлэх тухай 2021.03.24-ний өдрийн 01/691 тоот албан бичгийг БОАЖЯ-нд хүргүүлсэн. Мөн Өмнийн говийн ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх болон Өмнийн говьд хэрэгжих уул уурхай, хүнд үйлдвэрийн төслүүдийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр БОАЖЯ-ны байр суурийг сонсох, харилцан мэдээлэл, санал солилцож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилго бүхий уулзалтыг УУХҮСайд Г.Ёндон, ХҮБГ-ын Дэд бүтцийн хэлтсийн дарга С.Сүхбат, Усны газрын дарга Ш.Мягмар, "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг, Дэлхийн банкны "2030 Усны нөөцийн бүлэг"-ийн Монгол дахь суурин төлөөлөгч Д.Доржсүрэн болон бусад холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан 2021.04.03-ны өдөр УУХҮЯ-ны хурлын зааланд зохион байгуулсан. Уулзалтаас гарсан шийдвэрийн дагуу өмнийн говийн ус хангамжийг нэмэгдүүлэх төслүүд болон уул уурхай, хүнд үйлдвэрийн төслүүдийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр бүх шатанд судалгаанд суурилсан нэгдсэн ойлголт, мэдээлэлтэй болгох ажлыг усны асуудал эрхэлсэн яам, агентлаг болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран III улиралд багтаан зохион байгуулахаар ажиллаж байна.	70%	
149	3	4	<p align="center">"Эрдэнэт үйлдвэр" хязгаарлагдмал хариуцлагатай компанийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, нийт хувьцааны тодорхой хэсгийгиргэдэд эзэмшүүлэх тухай 2018-01-10</p> <p align="center">Дугаар 2018_10</p>	Засгийн газрын 2019.03.04-ний өдрийн 90 дүгээр тогтоолоор "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийг Төрийн өмчит улсын үйлдвэрийн газар болгохоор шийдвэрлэсэн.Улмаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019.06.18-ны өдрийн 262 дугаар тогтоолоор "Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ыг 2031 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг батлуулсан.	100%	

			<p>1.. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулах, нийт хувьцааны тодорхой хувийг Монгол Улсын нийт иргэдэд эзэмшүүлэх асуудлыг боловсруулан Засгийн газарт оруулж хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай.</p>		
150	4	5	<p>Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай 2021-05-05 Дугаар 2021_129</p> <p>2. Энэ тогтоолын 1-д заасан үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны хүрээнд “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”, “Исэлдсэн хүдрээс нуруулдан уусгах SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр”, “Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр” болон “Засвар, механикийн заводын өргөтгөл”-ийг тус тус “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгөөр санхүүжүүлж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай.</p>	<p>Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн байгуулах “уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг зохих журмын дагуу Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар хэлэлцүүлж өгч, саналаа ирүүлэх тухай Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021.05.21-ний өдрийн 01/1334 дугаартай албан бичгийг Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргад хүргүүлсэн. Шинээр байгуулагдах паркийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэхэд 4.8 тэрбум төгрөг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ төлөвлөсөн бөгөөд 2021 онд багтаан зураг төсөл боловсруулах ажлыг дуусгахаар төлөвлөсөн.</p>	30%
151	4	6	<p>3. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай</p>	<p>“Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам”-д заасны дагуу паркийн удирдлага болон</p>	30%

		зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газартай Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.4-т заасны дагуу гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (Г.Ёндон), хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг хуульд заасан журмын дагуу төрийн өмчид бүртгэж авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай.	УУХҮЯ хооронд байгуулах гэрээний төслийг боловсруулан “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т хүргүүлсэн.			
4.ё. Ерөнхий сайдын захирамж						
4.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл						
152	1	1	<p>2018 оны 3 дугаар сарын 27-ны өдөр 15 дугаар тэмдэглэл 2018-03-27</p> <p>Дугаар 2018_15</p> <p>XXIX.14.. Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудалтай холбогдуулан хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх үндэслэл, тооцоог гаргасны үндсэн дээр аж ахуйн нэгж байгуулах тухай шийдвэрийн төсөл боловсруулан хууль тогтоомжийн хүрээнд Монголбанк болон яамдын саналыг авч, Засгийн газрын хуралдаанд зохих журмын дагуу оруулж хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд</p>	<p>“Алт 2” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, алтны олборлолт, баяжуулалт, цэвэршүүлэлтэд бүрэн хяналт тавьж, хууль бус алтны экспортыг зогсоох, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх төгрөгийн ханшийг тогтворжуулахад түлхэц үзүүлэх зорилгоор “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ыг 2018 оны 3 дугаар сард “Эрдэнэс Монгол” ХХК-ий (охин компани) 100 хувь төрийн өмчит компани хэлбэрээр байгуулсан.</p>	<p>100%</p> <p>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>	

			<p>үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.</p>			
153	2	2	<p>2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр 48 дугаар тэмдэглэл 2018-11-21 Дугаар 2018_48</p> <p>XII. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав:</p> <p>2.1. үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн бүтээн байгуулалтын ажлын явцыг Засгийн газарт танилцуулах;</p> <p>2.2. үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг зохих журмын дагуу дүгнэсний үндсэн дээр гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, газрыг зориулалтын бусаар эзэмшиж, ашиглаж байгаа аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцлах, газрыг чөлөөлөх арга хэмжээ авах;</p> <p>2.3. ашигт малтмал, газрын тосны салбарт олгосон хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг бусдад дамжуулан худалдаж байгаа эсэхийг шалгаж, тусгай зөвшөөрөл олголтыг цэгцлэх асуудлаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, дүнг Засгийн газарт танилцуулах.</p>	<p>2.1. “Эрдэнэт технопарк” ХХК, “Налайхын барилгын материалын үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ, “Дархан үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ, “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ-ын УУХҮЯ-тай байгуулсан гэрээг дүгнэсэн. “Нийслэлийн Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ нь Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасны дагуу паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгуулах хүсэлтийг Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэхээр ажиллаж байгаа тухай 2021.04.30-ны өдрийн 61 дугаартай албан бичгийг тус яаманд ирүүлсэн.</p> <p>2.2. УУХҮ-ийн сайдын 2021.01.08-ны өдрийн 01/46 болон 01/47 дугаар гэрээний биелэлтийн дүгнэлт хүргүүлэх тухай албан бичгийг “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ болон “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлсэн. Үйл ажиллагаа явуулж буй паркуудын гэрээний биелэлт урьдчилсан дүнгээр 60-аас дээш хувийн биелэлттэй, газрыг зориулалтын дагуу эзэмшиж, ашиглаж байгаа тайлан ирүүлсэн. “Дархан үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ-ын ТЭЗҮ-ийг шинэчлэх, техник, технологийн үнэлгээг гүйцэтгүүлэх зэрэг арга хэмжээ авах тухай 2021.01.25-ны өдрийн 07/210 дугаартай албан бичгийг тус ОНӨААТҮГ-ын даргад хүргүүлсэн.</p> <p>2.3. Монгол Улсын шадар сайдын 2020.03.02-ны өдрийн 17 дугаар тушаалаар хүчин төгөлдөр байгаа хайгуул, ашиглалтын болон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, сунгалт, цуцлалтын үйл ажиллагааны баримт бичгийг бүрдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгах ажлын хэсэг байгуулагдсан. Мөн хавсралтаар ажлын хэсгийн удирдамж батлагдсан. Ажлын хэсэгт УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ, МХЕГ, ЦЕГ зэрэг байгууллагын төлөөлөл оролцож 21 аймагт ажиллан Тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг ЗДТГ, МХГ, БОХГ, Газрын албаны мэргэжилтэн, сумдын холбогдох хүмүүсээс авсан. Ажлын хэсгийн тайланг МХЕГ-т нэгтгэн аймаг тус бүрээр гарсан дөрчил цаашид авах арга хэмжээний санал боловсруулан Монгол Улсын Шадар сайдад хүргүүлсэн.</p>	70%	
154	3	3	<p>2021 оны 2 дугаар сарын 24-ний өдөр 13 дугаар тэмдэглэл 2021-02-24 Дугаар 2021_13</p> <p>XI.3.6. Эрхлэх асуудлын хүрээнд хугацаа хоцорч, хэрэгжилт нь удаашралтай байгаа төслийн үйл</p>	<p>–“Эдийн Засаг Хөгжлийн Яам” /хуучнаар/ нь “Кью Эс Си” ХХК-тай 2014 онд “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээг 30 жилийн хугацаатай байгуулсан. Энэ хугацаанд 630 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, төслийн хэрэгжилтэд шаардлагатай уурхай, баяжуулах үйлдвэр байгуулах, дэд бүтэц /авто болон төмөр зам, төмөр замын ачих буулгах терминал, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц/-ийн ажлууд хийгдсэн</p>	100%	

			ажиллагааг эрчимжүүлж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцож ажиллахыг холбогдох сайд нарт.”	боловч төмөр, гангийн үйлдвэр байгуулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн ажил гэрээнд заасан хугацаандаа хийгдээгүй байна. Төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2020.09.23-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэл гарч, уг тэмдэглэлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Дархан-Уул аймагт хэрэгжих Уул уурхай, металлургийн цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гангийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, концессын гэрээнд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.10.28-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А-268 дугаар тушаалаар байгуулсан ба тушаалын 2 дугаар хавсралтад заасан удирдамжийн дагуу Уул уурхай, металлургийн цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гангийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын бэлтгэл хийх ажлын хэсгийн төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.12.08-ны өдрийн А-314 дүгээр тушзалаар батлуулан ажиллаж байна. Төслийн явцыг эрчимжүүлэх төлөвлөгөөний дагуу шинээр ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг БНХАУ-ын металлургийн инженерингийн компани болох “МСС-CERI” компаниар гүйцэтгүүлж ТЭЗҮ-ийн тайланг 2021 оны 4 дүгээр сард хүлээн авсан. ТЭЗҮ-ийг Монгол хэлнээ хөрвүүлэх ажил хийгдэж байгаа ба 2021 оны 6 дугаар сард багтаан ЭБМЗ-ийн Хүнд үйлдвэрийн салбар хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна.		
155	4	4	<p>2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 19 дүгээр тэмдэглэл 2021-03-24</p> <p>Дугаар 2021_19</p> <p>ХҮИ.5.2. Концессын гэрээ байгуулсан төслийн гүйцэтгэлд байнгын хяналт тавих талаар Концессын тухай хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлж ажиллахыг холбогдох сайд нарт үүрэг болгов.</p>	<p>“Эдийн Засаг Хөгжлийн Яам” /хуучнаар/ нь “Кью Эс Си” ХХК-тай 2014 онд “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээг 30 жилийн хугацаатай байгуулсан. Энэ хугацаанд 630 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, төслийн хэрэгжилтэд шаардлагатай уурхай, баяжуулах үйлдвэр байгуулах, дэд бүтэц /авто болон төмөр зам, төмөр замын ачих буулгах терминал, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц/-ийн ажлууд хийгдсэн боловч төмөр, гангийн үйлдвэр байгуулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн ажил гэрээнд заасан хугацаандаа хийгдээгүй байна. Төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2020.09.23-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэл гарч, уг тэмдэглэлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Дархан-Уул аймагт хэрэгжих Уул уурхай, металлургийн цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гангийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, концессын гэрээнд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.10.28-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А-268 дугаар тушаалаар байгуулсан ба тушаалын 2 дугаар</p>	100 %	

				хавсралтад заасан удирдамжийн дагуу Уул уурхай, металлургийн цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гангийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын бэлтгэл хийх ажлын хэсгийн төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.12.08-ны өдрийн А-314 дүгээр тушаалаар батлуулан ажиллаж байна. Төслийн явцыг эрчимжүүлэх төлөвлөгөөний дагуу шинээр ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг БНХАУ-ын металлургийн инженерингийн компани болох "МСС-CERI" компаниар гүйцэтгүүлж ТЭЗҮ-ийн тайланг 2021 оны 4 дугаар сард хүлээн авсан. ТЭЗҮ-ийг Монгол хэлнээ хөрвүүлэх ажил хийгдэж байгаа ба 2021 оны 6 дугаар сард багтаан ЭБМЗ-ийн Хүнд үйлдвэрийн салбар хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажил ажил хийгдэж байна.		
156	5	5	<p align="center">2021 оны 3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03</p> <p align="center">Дугаар 2021_14</p> <p>XII.4. 6. Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг дахин хянаад дүгнэлт гаргахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд;</p>	<p>"Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах" төслийн ТЭЗҮ-ийн дүгнэлт, танилцуулгыг ЗГ-ын хуралдаанд танилцуулахаар УУХҮ-ийн сайдын 2021.03.15-ны өдрийн 01/594 дугаартай албан бичгээр ГХ-ны Сайдад хүргүүлсэн.</p>	100%	
157	6	6	<p align="center">2020 оны 9 дүгээр сарын 23-ний өдөр 51 дүгээр тэмдэглэл 2020-09-23</p> <p align="center">Дугаар 2020_51</p> <p>XII.1. . Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Дархан-Уул, Сэлэнгэ аймагт ажилласан талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад даалгав: XII.1. 12. Дархан-Уул аймагт хэрэгжих уул уурхай, металлургын цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор гангийн үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, төсөлд</p>	<p>УУХҮСайдын 2020.10.28-ны өдрийн А-268 дугаар тушаалаар Дархан-Уул аймагт хэрэгжих Уул уурхай, металлургийн цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гангийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, концессын гэрээнд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан ба мөн УУХҮСайдын 2020.12.08-ны өдрийн А-314 дүгээр тушаалаар Уул уурхай, металлургийн цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гангийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын бэлтгэл хийх ажлын хэсгийн төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. Төслийн явцыг эрчимжүүлэх төлөвлөгөөний дагуу шинээр ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг БНХАУ-ын металлургийн инженерингийн компани болох "МСС-CERI" компаниар гүйцэтгүүлж ТЭЗҮ-ийн тайланг 2021 оны 4 дугаар сард хүлээн авсан. ТЭЗҮ-ийг Монгол хэлнээ хөрвүүлэх ажил хийгдэж байгаа ба 2021 оны 6 дугаар сард багтаан ЭБМЗ-ийн Хүнд үйлдвэрийн салбар хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажил ажил хийгдэж байна.</p>	30 %	

			шаардлагатай цахилгаан эрчим хүчний дэд бүтцийн асуудлыг судалж, үе шаттай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зориулалтаар газар ашиглах эрхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох арга хэмжээ авахыг Дархан-Уул аймгийн Засаг дарга Н.Насанбат нарт		
11	13	Хүнд үйлдвэрийн бодлогын дундаж: 71.5 хувь			

САЛБАР ЧИГЛЭЛ: 5. НИЙТЛЭГ АСУУДАЛ						
5.а. Монгол Улсын хууль						
158	1	1	<p>Статистикийн тухай /Шинэчилсэн найруулга/ 1997.06.05.</p> <p>11.6. Яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллага чиг үүргийнхээ дагуу статистикийн үйл ажиллагааг эрхэлнэ. Яамд бүтэцдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжтэй байна.</p>	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай Засгийн газрын 2020 оны 105 дугаар тогтоолоор УУХҮЯ-ны бүтцэд статистик, судалгааны нэгж байгуулсан. Үндэсний статистикийн хороо болон төрийн захиргааны байгууллагуудын статистикийн үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг нарийвчлан гаргах, уялдааг сайжруулах яам, агентлаг, төрийн байгууллага хоорондын мэдээлэл цуглуулах, боловсруулах, дамжуулах, солилцох арга механизмыг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой ажлууд хийгдэж байна. Тухайлбал, СЯ, ТЕГ, ҮСХ, АМГТГ, Монголбанктай хамтран 7 хоног, сар, улирал, хагас, бүтэн жилийн статистик мэдээллийг нэгтгэн гаргаж байна.	100%	
159	2	2	<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай 2011-06-16</p> <p>Дугаар 2011.06.16</p> <p>7.1.1. Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг эмх цэгцтэй, ойлгомжтой байдлаар байршуулан цаг тухай бүрт нь тогтмол шинэчилж, баяжуулалтыг хөтлөн явуулж байна.	100%	

160	2	3	<p>7.1.2. Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны www.mmhi.gov.mn сайтын толгой хэсэгт бичиг хэргийн ажилтны харилцах утас, цахим хаягийг, БИДНИЙ ТУХАЙ цэсийн “Холбоо барих” дэд цэс-д байгууллагын бүх газар, хэлтсийн нэр, чиг үүрэг, албан хаагчдын албан тушаал, овог, нэр, утасны дугаарыг https://www.mmhi.gov.mn/public/page/pageid/7 цахим хуудсанд тус тус байршуулсан.</p> <p>Өргөдөл гомдол хариуцсан албан хаагч нь цахимаар болон бичгээр ирүүлсэн иргэдийн өргөдөл гомдлыг тухай бүрт нь хүлээн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд иргэд, байгууллагаас захидал, өргөдөл хүлээн авах ажилтны нэр, холбогдох утасны дугаарыг яамны www.mmhi.gov.mn сайтын төгсгөл хэсэгт ил харагдахаар байршуулсан. Иргэд, аж ахуйн нэгжээс УУХҮЯ, АМГТГ-т ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх дэлгэрэнгүй тайланг улирал бүр ЗГХЭГ-т хүргүүлэн ажиллаж байна.</p>	100%	
161	2	4	<p>7.1.3. Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	<p>Яамны цахим сайтын ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ цэс-д Газрын тос, тэсэлгээ, хүнд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхэд авах тусгай зөвшөөрлийн журам, бүрдүүлэх материалын жагсаалт, хариуцсан, мэдээлэл өгөх ажилтны нэр, утасны дугаар болон тухайн чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийг ил тод мэдээлсэн. Тусгай зөвшөөрөл хэсгийн Хүнд үйлдвэрийн бодлогын газраас олгодог Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх болон Төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгахад бүрдүүлэх материалын жагсаалтыг 2021.05.21-ний өдөр шинэчлэн байршуулсан. Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг тухай бүр шинэчлэж байна. http://mmhi.gov.mn/public/page/pageid/7</p>	100%	
162	2	5	<p>7.1.4. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны www.mmhi.gov.mn цахим хуудасны ХУУЛЬ, ТОГТООМЖ цэс-д хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм журам, зааврыг тогтмол шинэчлэн байршуулж байна.</p>	100%	
163	2	6	<p>7.1.5. Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч,</p>	<p>Захиргааны хэм хэмжээ тогтоосон актын төсөл болон холбогдох дүрэм, журам, зааврын төслийг яамны www.mmhi.gov.mn цахим хаяг болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам гэсэн фейсбүүк хуудсаар мэдээллийг тогтмол байршуулж санал авч байна.</p> <p>Яамны цахим сайтын ХЭЛЭЛЦҮҮЛЭГ цэсэд 2 хууль, 8 журмын төслийг байршуулж тухайн хэлэлцүүлгийг хариуцах ажилтантай холбогдох мэдээллийг байршуулсан. Цахим хуудсаар хэлэлцүүлэг явуулсны үндсэн дээр Захиргааны ерөнхий хуулийн дагуу нийтийн сонсгол,</p>	100%	

			<p>эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;</p>	<p>хэлэлцүүлгийг зохион байгуулан ажилласан. Тус яамнаас боловсруулсан дараах хууль тогтоомжийн төсөлд иргэд, олон нийт, бусад байгууллагаас санал авахаар цахим хуудасны хэлэлцүүлэг хэсэгт байршуулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмын шинэчилсэн найруулгын төсөл; 2. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм, шинжээчийн хөлс тооцох аргачлал; 3. Тэсэлгээний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам; 4. Мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагын болон шинжээчийн эрх олгох, сунгах, хүчингүй болгох журам; 5. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль; 6. Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн төсөл; 7. Аюулгүйн бүс, түүний дэгпэмийг тогтоох журам; 8. Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн төсөл; 9. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журам. 10. Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төсөл. 		
164	2	7	<p>7.1.6. Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;</p>	<p>Яамнаас салбарын үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хүргэж буй гол тавцан нь яамны цахим хуудас гэж үзэж цаг үеийн асуудлаар яамны удирдлага болон газар хэлтсийн дарга нарын өгсөн ярилцлага, видео бичлэгийг тухайн бүр байршуулж байна.</p> <p>Яамны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах үүднээс иргэд, олон нийтэд хандан “Ил тод, хариуцлагатай уул уурхай” сэдэвт Хэвлэлийн хурлыг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч цар тахлын нөхцөл байдлын үед эрсдэлтэй гэж үзэн хугацааг тодорхойгүй хугацаагаар хойшлуулаад байна. Коронавирусын халдвараас сэргийлэхийн тулд яам болон харьяа агентлагуудын үйл ажиллагааг аль болох цахим хэлбэрт шилжүүлэн олон нийт, хэвлэл мэдээлэлтэй цахимаар холбогдон мэдээлэл өгөх, ажилчдын дийлэнх хувийг гэрээсээ ажиллах боломж нөхцөлөөр ханган ажиллаж байна. Мөн үүнээс гадна хэдий цар тахлын нөхцөл байдалд байгаа ч цахим боломжийг ашиглан салбарын эмэгтэй ажилчдын оролцоог хангах, тэдний жендэрийн болон хариуцлагатай уул уурхайн ойлголт, мэдлэгийг тэлэх, идэвхжүүлэх, урам зориг өгөх, чиглүүлэх зорилгоор “ЭРДЭС БАЯЛАГ-ЭМЭГТЭЙЧҮҮД ҮНДЭСНИЙ III ЧУУЛГАН”-ыг цахимаар зохион байгуулж салбарын манлайлагч эмэгтэйчүүд туршлага, амжилт ололтоо чуулганд оролцогч 300 гаруй эмэгтэйчүүдтэй хуваалцсан юм. Түүнчлэн хагас жилийн байдлаар УУХҮЯ-ны үйл ажиллагаа, арга хэмжээтэй холбоотой 340</p>	100%	

			мэдээ, мэдээллийг бэлтгэж яамны цахим хуудас болон сошиал хуудсаар нийтэлж, эдгээр мэдээ мэдээллийг гэрээт болон гэрээт бус хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж ажилласан. Мөн гэрээт болон гэрээт бус телевизүүдээр яамны үйл ажиллагааг сурталчилсан нэвтрүүлэг, шторк, ярилцлага цацагдсан болно.		
165	2	8	<p>7.1.7. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017.01.03-ны өдрийн А-01 дүгээр тушаалаар батлагдсан “Хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтэнд мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох журам”-ын дагуу металлург, металл боловсруулалт, машин үйлдвэрлэлийн салбарын мэргэжилтнүүдэд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик, тээврийн сургуулийн сургалтын баазыг, нефть, химийн салбарын мэргэжилтнүүдэд тус сургуулийн Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн сургалтын баазыг тус тус түшиглэн 2017 оноос хойш жил бүр сургалт зохион байгуулж, салбарын мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэргийг УУХҮСайдын тушаалаар, мөн Уул уурхайн сайдын 2015.03.12-ны 53 дугаар тушаалаар батлагдсан “Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох” журмын дагуу Монгол Улсын газрын тосны салбарын инженерүүдэд мэргэжлийн зэргийг “Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Геологи, газрын тосны сургуульд түшиглэсэн Сургалт-мэдээллийн сектор” төвөөр дамжуулан 2016 оноос хойш сургалт зохион байгуулж, салбарын мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэргийг УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар тус тус олгож байна.</p> <p>“Хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтэнд мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох журам” болон “Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журам”-ын дагуу хүнд үйлдвэрийн салбарын болон газрын тосны салбарын мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох Зөвлөл ажиллаж, мэргэжлийн зэрэг олгох шалгаруулалт зохион байгуулах, мэргэжлийн зэрэг олгох, сунгах, түдгэлзүүлэх, бууруулах, цуцлах, хүчингүй болгох талаар шийдвэр гаргах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, зэрэгтэй инженерийн талаар гарган гомдлыг хүлээн авч, хянаж, Зөвлөлд танилцуулах, Зөвлөлөөс гарсан аливаа шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг гүйцэтгэдэг.</p> <p>Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмын дагуу салбарын мэргэшсэн, зөвлөх зэргийг Монголын геологи, уул уурхайн мэргэжлийн институт байгууллага олгож байсан. Үүнтэй уялдуулан холбогдох мэдээллийг www.mpigmnet.com цахим хаяг болон The MPIGM фейсбүүк хуудсаар мэдээллэж ажилласан. 2020.07.01-ний өдрийн Эрх хүчингүй болгох тухай УУХҮСайдын А/182 дугаар тушаал гарснаас хойш мэргэшсэн болон зөвлөх зэрэг олгох үйл ажиллагаа явагдаагүй болно. Сургалтай холбоотой зарын мэдээллийг тухай бүр</p>	100%	

				яамны “Мэдээ, мэдээлэл” дэд цэсэд тогтмол байршуулж ажиллаж байна.		
166	2	9	7.1.8. Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Яамны цахим сайтын ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ цэсэд Газрын тос, тэсэлгээ, хүнд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхэд авах тусгай зөвшөөрлийн журам, бүрдүүлэх материалын жагсаалт, хариуцсан, мэдээлэл өгөх ажилтны нэр, утасны дугаар болон тухайн чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийг ил тод мэдээлсэн болно. Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг тухай бүр шинэчлэж байна. http://mmhi.gov.mn/public/page/pageid/7	100%	
167	2	10	7.1.9. Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж буй гадаадын зээл, буцалтгүй тусламж, хамтарсан төслүүдийн 2020 оны хэрэгжилтэд ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан нийтлэг журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, дүгнэлт зөвлөмжийг яамны цахим хуудасны ИЛ ТОД БАЙДАЛ цэсний ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ дэд цэсэд тогтмол байршуулж ажиллаж байна.	100%	
168	2	11	8.1.1. Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Яамны болон харьяа агентлагийн сул ажлын байранд Төрийн албаны тухай хуульд заасан Төрийн жинхэнэ албан тушаалд томилох журам болон бусад холбогдох журмын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх захиалгыг ТАЗ-д хүргүүлж, сонгон шалгаруулалтын зарыг Төрийн албаны зөвлөлийн болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны цахим хуудсанд тус тус байршуулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажиллаж байна. 2020 оны байдлаар сул ажлын байр гараагүй болно. 2021 оны хагас жилийн байдлаар УУХҮЯ-нд 5 ажлын байр, АМГТГ-т 9 ажлын байр, ҮГА-нд 4 ажлын байрны сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулахаар Төрийн албаны зөвлөлд хүсэлт хүргүүлээд байна.	100%	
169	2	12	8.1.2. Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба гэсэн 3 байгууллагын хэмжээнд Төрийн захиргааны 209, төрийн үйлчилгээний 48 ажилтан, албан хаагчид ажиллаж байна. Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн байгууллагын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээлэлд Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019.01.23-ны өдрийн 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг мөрдлөг болгон ажиллаж байгаа	100%	

170	2	2	<p>бөгөөд Абле системийн олон нийт дэд цэсэд ойлгомжтой байдлаар байршуулсан.</p> <p>2021 оны эхний хагас жилийн тайлант хугацаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал газрын тосны газар, Үндэсний геологийн албаны Ёс зүйн зөвлөлд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээлэл ирээгүй бөгөөд Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн зөрчилтэй холбоотой ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх асуудал 2021 оны эхний хагас жилийн байдлаар хэлэлцэгдээгүй болно.</p> <p>2021 онд нийт 3 байгууллагын Ёс зүйн зөвлөлийг чадавхжуулах чиглэлд анхааран сүүлийн хагас жилд Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний нийт албан хаагчдаа "Төрийн албаны үнэт зүйлс, зарчим, манлайлал" сэдвээр сургалт, мэдээлэл өгөхөөр бэлтгэж байна.</p>	<p>Төсвийн шууд захирагчийн болон нэгжийн менежер, төрийн жинхэнэ албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулах үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэхтэй холбогдон гарсан Төрийн албаны зөвлөлийн журмыг яамны цахим хуудсанд байршуулан мөрдөж ажиллаж байна.</p>	100%
171	2	14	<p>8.1.3.. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p> <p>8.1.4. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;</p>	<p>Яамны цахим хуудсанд "Хүний нөөцийн ил тод байдал" цэсэд хүний нөөцтэй холбоотой хууль тогтоомжууд, Сайд болон Төрийн нарийн бичгийн даргын тушаал, Төрийн албаны зөвлөлийн салбарын зөвлөлийн төлөвлөгөө, тайлан, хуралдааны тойм болон бусад мэдээллийг тогтмол байршуулж дотоод сүлжээгээр яамны нийт албан хаагчдад мэдээлэж байна.</p>	100%
172	2	15	<p>8.1.5. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх Үнэлгээний багийг Төрийн нарийн бичгийн даргын 2020.10.08-ны өдрийн А/107 дугаар тушаалаар баталсан. Төрийн жинхэнэ албан хаагчдын 2020 оны гүйцэтгэлийн тайланг 2021.01.15-ны өдөр нэгжийн даргаар үнэлүүлж, үнэлгээний багийн гишүүд болон төсвийн шууд захирагчаар баталгаажуулан үр дүнгийн гэрээг үнэн зөв, шударга дүгнэж ажилласан.</p> <p>Төрийн нарийн бичгийн даргын 2021.06.16-ны А/58 дугаар тушаалаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан хаагчийн гүйцэтгэлийн тайланг үнэлэх эрх бүхий Байгууллагын үнэлгээний баг байгуулагдсан. Үнэлгээний баг 2021.06.22-ны өдөр хуралдаж ЗГ-ын 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу нийт албан хаагчдын тайланг үнэлж баталгаажуулсан. Үнэлгээний мөрөөр авах арга хэмжээний зөвлөмжийг ТНБД-д хүргүүлсэн.</p>	100%

173	3	16	<p>Хууль тогтоомжийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-05-29</p> <p>Дугаар 2017.01.01</p> <p>49.1. Улсын Их Хурал, Засгийн газар хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байнгын тогтолцоог бүрдүүлж, холбогдох бүтцийн нэгжийг ажиллуулна.</p>	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 105 дугаар тогтоолоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны бүтцэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар байхаар батлагдсан бөгөөд тус газар нь 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.	100%	
174	3	17	52.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг Улсын Их Хурал, Засгийн газар жилд нэг удаа тогтмол хэлэлцэж хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хууль тогтоомжид зохих нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль тогтоомжийг хооронд нь уялдуулах, хууль тогтоомжийг системчлэн кодификаци хийх, шинээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжид үнэлгээ хийж, хуулийн давхардал хийдлийн судалгааг гаргаж, Хууль тогтоомжийн хуулийн дагуу Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, хийж, шаардлагатай хуулийн төслийг боловсруулан ажиллаж байна.	100%	
175	3	18	49.3.. Засгийн газраас хийх хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг холбогдох төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.	"Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хагас жил, жилийн эцсийн байдлаар гаргуулан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, холбогдох газруудад хүргүүлж байна.	100%	
176	3	19	49.5.. Улсын Их Хурал, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний бүтцийн нэгж нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн эерэг, сөрөг үр дагаврын талаарх хяналт шинжилгээний дүнг хууль санаачлагчид тогтмол мэдээлнэ.	"Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг жил бүрийн 1, 7-р сард ЗГХЭГ-т хүргүүлж ажиллаж байна. Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжид үнэлгээ хийж, хуулийн давхардал хийдлийн судалгааг гаргаж, Хууль тогтоомжийн хуулийн дагуу Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, хийж, шаардлагатай хуулийн төслийг боловсруулан ажиллаж байна.	100%	
177	3	20	49.6.. Энэ хуулийн 49.5-д заасан хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээний дүнд үндэслэн	"Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол	100%	

			хууль тогтоомжийн зорилгын түвшин хангалтгүй, хууль тогтоомжийн үзэл баримтлалд заасан үр дүнд хүрч чадахгүй тохиолдолд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийнэ.	шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, дүнг жил бүрийн 1, 7-р сард ЗГХЭГ-т хүргүүлж ажиллаж байна.		
178	3	21	49.7.. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг жилд 2 удаа гаргадаг бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.	100%	
212	11	14	<p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2020-12-30 Дугаар 2020_253</p> <p>3. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын дүнд хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэх;</p> <p>1.2. Монгол Улсад короновируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тохиолдол бүртгэгдэж бүх нийтийн</p>	<p>“Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 430, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 253 дугаар тогтоолын дагуу Хэнтий аймгийн Бэрх тосгонд баригдаж байгаа Далд уурхайн музейн ажлыг эрчимжүүлэх, 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдсан хөрөнгийг зүй зохистой зарцуулах талд анхааран ажиллаж байна.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/24 дүгээр тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд шинээр хэрэгжүүлэх 1:50000-ны масштабтай ГЗЕЭА-ын 4 төсөл, сэдэвчилсэн судалгааны 11 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан. Тендерийг 2021.03.19-ний өдөр зарласан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36.7-д заасан шаардлагыг хангасан 1:50000-ны масштабтай ГЗЕЭА-ын 3 төсөл, сэдэвчилсэн судалгааны 1 төслийн хураангуй жагсаалтад орсон аж ахуйн нэгжүүдэд</p>	<p>100%</p>	

			<p>бэлэн байдал болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээс шалтгаалан эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж байгаа 2020 онд хэрэгжиж дуусах боловч батлагдсан санхүүжилтийг бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн, мөн бусад салбарын зайлшгүй шаардлагатай болон Засгийн газрын 2019 оны 280 дугаар тогтоолын хүрээнд хийгдэж байгаа бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний 2020 оны үлдэгдэл санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах. 2. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төслүүдийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн дотор бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. 3. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосугай.</p>	<p>2021.04.12-ны өдөр урилга хүргүүлсэн. Геомэдээллийн санг цахимжуулах 3 төслийн тендер шалгаруулалттай холбоотойгоор Тагнуулын ерөнхий газраас албан бичиг ирүүлсэн тул эдгээр төслүүдийн тендер шалгаруулалт түр хойшлогдоод байна. Шаардлага хангаагүй буюу хураангуй жагсаалт үүсээгүй 8 багцын тендерийг 2021.04.12-ны өдөр дахин зарласан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36.7-д заасан шаардлагыг хангасан 2 багцын /7, 15/ хураангуй жагсаалтад орсон аж ахуйн нэгжүүдэд 2021.05.20-ны өдөр урилга хүргүүлээд байна. Шаардлага хангаагүй буюу хураангуй жагсаалт үүсээгүй тендерийг 2021.04.28-ны өдөр дахин зарласан.</p>		
213	12	15	<p>Жагсаалт батлах тухай 2021-01-15 Дугаар 2021_15</p> <p>2. “Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгөөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралт, “Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгөөр аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт, “Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалт”-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. Энэ тогтоолын 1 дүгээр</p>	<p>Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заагдсан Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгөөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт, 2 дугаар хавсралтад заагдсан аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцад хамаарах төсөл арга хэмжээ тусгагдаагүй болно. Уг тогтоолд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын шадар сайдын 2021.04.08-ны ЗГ-2/360 тоот яаралтай албан бичигтэй танилцаж, 2021.04.13-ны 01/978 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.</p>	<p>Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй.</p> <p>Арга хэмжээний жагсаалтад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцад хамаарах төсөл арга хэмжээ</p>	

			хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт, 2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээний зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг, техникийн хяналтын зардлын тооцооны хамт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2021 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор тус тус шилжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.		тусгагдаагүй тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.	
214	12	16	3. “Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгөөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралт, “Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгөөр аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт, “Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалт”-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. Энэ тогтоолын 3 дугаар хавсралтад заасан бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах ажиллагааг урьд нь байгуулсан ерөнхий гэрээний хүрээнд зохион байгуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралт болон 3 дугаар хавсралтад заасан ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, бүтээгдэхүүний жагсаалтад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцад хамаарах худалдан авалт тусгагдаагүй болно	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй. Тус хавсралтуудад УУХУСайдын багцад хамаарах худалдан авалт тусгагдаагүй тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.	
215	13	17	Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-02-17 Дугаар 2021_43 1. Монгол Улсын 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай	Монгол Улсын 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасан 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:	100%	

	<p>зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллаж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад улс, орон нутгийн төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус даалгасгай:</p> <p>1.1. үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;</p> <p>1.2. шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх;</p> <p>1.3. төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ,</p>	<p>1.1 Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсвийг хэмнэж ажиллаж байна.</p> <p>1.2 МУЗГ-ын 2020 оны 105 дугаар тогтоолоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь 78 орон тоотойгоор батлагдсан. 2021 оны хагас жилийн байдлаар 75 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд тэтгэвэрт гарсан 1 хүн байна.</p> <p>1.3 Цалин хөлсийг оны эхний 05 сарын байдлаар нэмээгүй бөгөөд дарга удирдлагуудад шагнал урамшуулал олгоогүйгээс гадна календарь, мэндчилгээ, ном хэвлэл гэх мэт зардлуудыг гаргаагүй болно.</p> <p>1.4 УУХҮЯ-ны 2021 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авах ажиллагаа тусгагдаагүй. Харьяа агентлагууд болон салбарын төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хянан, уг тогтоолтой зөрчилдөж байгаа худалдан авалтуудыг хасч, тухай бүр УУХҮ-ийн сайдын тушаалаар баталгаажуулан ажиллаж байна.</p> <p>1.5 Тайлант хугацаанд Төрийн албан хаагчдын мэргэшүүлэх багц сургалт, Төрийн албаны зөвлөлийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүдэд зориулсан сургалт, ХАБ-ын сургалт, бусад гаднын байгууллага, төсөл арга хэмжээний дэмжлэгтэйгээр зохион байгуулагдаж байгаа сургалтууд болон Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Яамны шуурхай хуралдаан. ажлын хэсгүүдийн хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулж байна.</p> <p>1.6 Тайлант хугацаанд баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зохион байгуулаагүй болно.</p> <p>1.7. Хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлээгүй болно.</p> <p>1.8 Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газартай байгуулсан гэрээний дагуу байр ашиглалтын зардлыг тухайн байгууллагад сар бүр тогтмол төлдөг болно.</p> <p>1.9 Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорын зэрэг зардлыг бууруулж ажиллаж байна.</p>	
--	---	---	--

		<p>түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх; 1.4. энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх; 1.5. салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх; 1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх; 1.7. хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх; 1.8.</p>		
--	--	---	--	--

			байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; 1.9. бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах.			
216	14	18	<p>Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2020-11-18 Дугаар 2020_183</p> <p>9. Ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүн экспортлогч аж ахуйн нэгжийг халдвар, хамгааллын онцгой дэглэм, горимд шилжүүлж, нийт ажиллагсдыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, хамгаалах, аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд үүрэг болгосугай.</p>	Газрын тос экспортлогч аж ахуйн нэгжийг халдвар, хамгааллын онцгой дэглэм, горимд шилжүүлж, нийт ажиллагсдыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, хамгаалах, аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрдүүлж ажиллах талаар УУХҮСайдын 2020.11.12-ны өдрийн 01/2832 албан тоотоор УУХҮСайдын А/282 дугаар тушаалаар гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны Шуурхай штабын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, А/289 дүгээр тушаалаар бэлэн байдлыг хангаж ажиллах үүргийг улсын албаны Шуурхай штаб болон мэргэжлийн ангиудад өгсөн. Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанд Тавантолгой, Нарийнсухайт, Айлбаян, Ерөө-Хүдрийн бүлэг ордод нэгдсэн байдлаар, Оюутолгой, Эрдэнэт, Бор-Өндөр, Хөшөөт, Таяннуур, Улаан, Төмөртийн овоо, Багануур, Шивээ-Овоо, Адуунчулуун, Шарын голын уурхай, газрын тосны Зүүнбаян, Тосон уул, Тамсагийн орд тус бүрт халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах Аюулгүйн тусгай бүс байгуулах тухай асуудлыг танилцуулж, хуралдааны 64 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан. Улмаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А-297 дугаар тушаалаар Халдваргүйжүүлэлт, хамгаалалтын аюулгүйн бүс байгуулах тухай тушаалыг батлуулж, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр аж ахуйн нэгж байгууллагуудтай цахим хурал хийж дээр дурдсан шийдвэрүүдийн талаар танилцуулсан.	100%	
217	14	19	10. Монгол, Хятадын хилийн боомтод хэрэгжүүлж буй “Ногоон гарц”-ын үйл ажиллагааг эрчимжүүлж, ашигт малтмал, газрын тосны экспортыг хэвийн, тасралтгүй явуулах саналыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд дипломат шугамаар тавьж харилцан тохиролцохыг Гадаад харилцааны сайд Н.Энхтайван, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	Тус яамнаас Монгол, Хятадын хилийн боомтод хэрэгжүүлж буй “Ногоон гарц”-ын журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх саналыг боловсруулж, Гадаад харилцааны яаманд 2021.02.16-ны өдрийн 01/373 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	100%	

			Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгасугай.			
218	14	20	11. Хилийн боомтуудыг халдвар, хамгааллын онцгой дэглэм, горимд бүрэн хүчин чадлаар ажиллуулах, Тавантолгойн бүлэг орд, Нарийнсухайтын бүлэг орд, Оюутолгойн ордын хүрээнд байгуулагдсан ариутгал, халдваргүйжүүлэлт, хамгаалалтын аюулгүйн бүсийн үйл ажиллагаа, нөхцөл байдалтай уялдуулан Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор тээвэрлэлт хийж байгаа жолооч нарыг шинжилгээнд бүрэн хамруулж, эдгээр боомтыг “Ногоон бүс” болгон зарлаж, тээвэрлэлтийн дараалал үүсгэхгүй байхаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 30, 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 37, 39 дүгээр тушаалаар тус тус байгуулагдсан Ажлын хэсгийг Өмнөговь аймгийн Өмнөговь аймгийн нутагт орших Оюутолгой, Тавантолгойн ордод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам, Цагаан хадны гаалийн хяналтын бүс, хилийн Гашуунсухайт боомт, Нарийнсухайтын ордод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн авто зам, хилийн Шивээхүрэн боомтод ажиллуулж, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахал хүн амын дунд тархахаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар, хамгааллын дэглэмийг сахиулах, боомтын аюулгүй байдлыг хангуулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй газар дээр нь үзэж танилцаж, хяналт тавьж, заавар, зөвлөмж өгч, холбогдох зохион байгуулалтыг тухай бүр гүйцэтгэсэн. Тухайлбал, Нүүрс тээврийн жолооч нарыг PCR шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж ЗӨСҮТ-ийн явуулын лабораторийг ажиллуулж байна. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн ажилтан албан хаагчдыг түргэвчилсэн оношлуурт хамруулах, ажилчдын ээлж солилцох асуудлыг шийдвэрлэсэн. Мөн Цагаанхадны гаалийн хяналтын бүс хилийн Гашуунсухайт боомт орчимд Дотоодын цэргийн 50 албан хаагчдыг ажиллуулж, халдвар, хамгааллын дэглэмийг сахиулах арга хэмжээг авсан болно. Түүнчлэн уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч томоохон аж ахуйн нэгжүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Тавантолгой, Нарийнсухайт, Айлбаян, Ерөө-Хүдрийн бүлэг ордод нэгдсэн байдлаар, Оюутолгой, Эрдэнэт, Бор-Өндөр, Хөшөөт, Таяннуур, Улаан, Төмөртийн овоо, Багануур, Шивээ-Овоо, Адуунчулуун, Шарын голын уурхай, газрын тосны Зүүнбаян, Тосон уул, Тамсагийн орд тус бүрт халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах Аюулгүйн тусгай бүсийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 297 дугаар тушаалын дагуу байгуулж хэрэгжилтийг хангаж байна.	100%	
219	14	21	18. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний төлбөрийг түргэн шуурхай барагдуулж ажиллахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх 44 аж ахуйн нэгж/урсгал зардлаас санхүүжүүлэх 33, хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 11/-тэй гэрээг байгуулан дүгнэж, санхүүжүүлсэн. Төсвийн орлого төвлөрүүлэлттэй холбогдуулан 1 гүйцэтгэгчийн санхүүжилт, Улсын комисс ажиллуулах 2 гүйцэтгэгчийн санхүүжилтийг тус тус Сангийн яаманд уламжилж, зохион байгуулалттай арга хэмжээнд оруулан Захиалагчийн барьцаа хөрөнгийн дансанд санхүүжилтийг байршуулах арга хэмжээг аваад	100%	Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн

				байна. Сангийн яамнаас 2020 оны жилийн эцэст санхүүжилтийн эрх нээгээгүйгээс 8 байгууллагад нийт 58,0 сая төгрөгийн өглөгтэй байна. 2021 оны эхний 05 сарын байдлаар 53,9 сая төгрөг болж бууруулан ажиллаж байна. 2021 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардалд 1,727.1 сая төгрөг эхний улирлын байдлаар 399,8 сая гүйцэтгэл гарч санхүүжилтийг бүрэн шийдвэрлэн ажиллаж байна., Геологийн судалгааны ажлын зардалд 27,430.0 төгрөг батлагдсанаас 2,900.0 сая төгрөг олгож 1,300.0 төгрөгийн санхүүжилт Сангийн яаманд хүлээгдэж байна.	тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.	
220	14	22	19. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, дотоодын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10, 10 ¹ дүгээр зүйлд заасныг баримтлан дотоодын барааг худалдан авах зохион байгуулалтын арга хэмжээг авахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай.	Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, дотоодын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10, 10 ¹ дүгээр зүйлд заасныг баримтлан дотоодын барааг худалдан авах зохион байгуулалтын арга хэмжээг авахыг харьяа бүх байгууллагууд, төрийн өмчит компаниудад зөвлөж, салбарын хэмжээнд 2020 онд дотоодын үйлдвэрлэлээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг нэгтгэн гаргаж 2021.01.25-ны өдрийн 01/205 тоот албан бичгээр ХХААХҮЯ-нд хүргүүлсэн. 2021 оны эхний хагас жилийн байдлаар дотоодын үйлдвэрлэлээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг нэгтгэж байна. Энэ ажлын хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийн газраас 2021.04.01-30-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулсан “Төрийн худалдан авалт-Үндэсний үйлдвэрлэл” үзэсгэлэнд салбарын аж ахуйн нэгж байгууллагуудыг оролцуулах ажлыг зохион байгуулсан.	70%	
221	14	23	22. Салбарын хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэвийн явуулах санал боловсруулан Улсын онцгой комиссын хуралдаанд танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5.1.4.-д "газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэвийн бус өсөлт, хангамжийн тасалдал, хомсдол үүсэх нөхцөлд зохицуулалт хийх" гэж, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.18-д "цар тахлын үед өргөн хэрэглээний болон стратегийн ач холбогдол бүхий зарим бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байхад чиглэсэн төрийн зохицуулалтын арга хэмжээг авах" гэж тус тус заасан байдаг. Дэлхий нийтэд тархаад байгаа Ковид-19 цар тахлын нөхцөл байдал ОХУ-д хүндэрсэнтэй холбоотойгоор коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор Засгийн газрын 2020.10.30-ны өдрийн 164 дүгээр тогтоолоор Монгол, Оросын хилийн Цагааннуур, Боршоо авто замын боомтыг 2020.11.02-ны өдрөөс мөн оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хүртэл хааж, түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг зогсоохоор шийдвэрлэсэн. Тус боомтуудыг хааж, нэвтрэх хөдөлгөөнийг зогсоосонтой холбоотойгоор тухайн боомтуудаар явагдаж байсан шатахууны импорт зогсож, баруун бүсийн шатахууны хангамж тасалдах, хомсдол үүсэх, үнэ өсөх нөхцөл байдал	100%	

				<p>үүссэн. Иймд баруун бүсийн шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хадгалах, хомсдлоос сэргийлэх хүрээнд тус боомтуудаар халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн, зөвхөн стратегийн ач холбогдол бүхий шатахуун импортлох асуудлыг судлан, шийдвэрлүүлэх тухай саналыг 2020.11.10-ны өдрийн 01/2785 тоот албан бичгээр УОК-т хүргүүлсэн. Засгийн газрын 2020.11.11-ний өдрийн 172 дугаар тогтоолоор хилийн Цагааннуур авто замын боомтыг 2020.11.23-ны өдрөөс эхлэн сар бүрийн 2, 4 дэх долоо хоногт хуваарийн дагуу ажиллуулж, зөвхөн шатахуун тээвэрлэх авто машиныг улсын хилээр нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн. Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд өөрийн аймгийн нутаг дэвсгэрт орших хилийн боомтоор явагдаж газрын тосны экспортын тээвэрлэлтийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх үйл ажиллагааг холбогдох талуудтай хамтран зохион байгуулж, холбогдох арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэн, хамтран ажиллах тухай 2020.08.13-ны өдрийн 01/1977 тоот албан бичгийг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Сүхбаатар аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар нарт тус тус хүргүүлсэн. Баянхошуу болон Бичигт боомтоор явагдаж буй газрын тосны экспортын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж байгаа ба өнөөдрийн байдлаар дээрх боомтуудаар явагдаж буй газрын тосны экспортын тээврийг 48 автоцистернээр гүйцэтгэж байсныг нэмэгдүүлэн, өдөрт 70-74 автоцистерн болгон нэмэгдүүлээд байна</p>		
222	15	24	<p>Журам батлах тухай 2021-03-03 Дугаар 2021_51</p> <p>2. “Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралт ёсоор баталсугай. 2. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг сайд нарт үүрэг болгосугай.</p>	<p>Засгийн газрын 51 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллахыг харьяа байгууллагуудад мэдэгдэж мэдээллийг цахимаар хүргүүлж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.</p>	100%	
223	16	25	<p>“Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл” батлах тухай 2021-03-10 Дугаар 2021_58</p> <p>3. Энэ төсөлд хамрагдсан залуучуудыг ажлын байраар хангах талаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтээн байгуулалтын болон бусад холбогдох</p>	<p>Ковид цар тахлын улмаас “Залуучуудын хөгжил залуучуудын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний хөгжлийн цогц сургалт”-ыг хариуцсан хариуцсан яамны зүгээс зохион байгуулаагүй тул холбогдох төсөл, арга хэмжээг тус яамнаас дэмжиж ажиллах нөхцөл бүрдээгүй.</p>	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй.	

			төсөл, арга хэмжээний хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл болгосугай.			
224	17	26	<p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-03-24 Дугаар 2021_70</p> <p>1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор дараахь арга хэмжээг авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай: 1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбогдуулан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 430, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 253 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах; 1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, санхүүжилтийн шуурхай, нээлттэй, ил тод байдлыг төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр дамжуулан хангах, төсвийн тухайн жилд багтаан санхүүжүүлэхэд онцгой анхаарах; 1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга</p>	<p>“Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019.12.11-ний өдрийн 430, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2020.12.30-ны өдрийн 253 дугаар тогтоолын дагуу Хэнтий аймгийн Бэрх тосгонд баригдаж байгаа Далд уурхайн музейн ажлыг эрчимжүүлэх, 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдсан хөрөнгийг зүй зохистой зарцуулах талд анхааран ажиллаж байна.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/24 дүгээр тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд шинээр хэрэгжүүлэх 1:50000-ны масштабтай ГЗЕЭА-ын 4 төсөл, сэдэвчилсэн судалгааны 11 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан. Тендерийг 2021.03.19-ний өдөр зарласан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36.7-д заасан шаардлагыг хангасан 1:50000-ны масштабтай ГЗЕЭА-ын 3 төсөл, сэдэвчилсэн судалгааны 1 төслийн хураангуй жагсаалтад орсон аж ахуйн нэгжүүдэд 2021.04.12-ны өдөр урилга хүргүүлсэн. Геомэдээллийн санг цахимжуулах 3 төслийн тендер шалгаруулалттай холбоотойгоор Тагнуулын ерөнхий газраас албан бичиг ирүүлсэн тул эдгээр төслүүдийн тендер шалгаруулалт түр хойшлогдоод байна.</p> <p>Шаардлага хангаагүй буюу хураангуй жагсаалт үүсээгүй 8 багцын тендерийг 2021.04.12-ны өдөр дахин зарласан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36.7-д заасан шаардлагыг хангасан 2 багцын /7, 15/ хураангуй жагсаалтад орсон аж ахуйн нэгжүүдэд 2021.05.20-ны өдөр урилга хүргүүлээд байна.</p> <p>Шаардлага хангаагүй буюу хураангуй жагсаалт үүсээгүй тендерийг 2021.04.28-ны өдөр дахин зарласан.</p>	100%	

			<p>хэмжээний худалдан авах ажиллагааг 2021 оны 7 дугаар сарын 1-ний дотор зохион байгуулж, гэрээ байгуулсан байхаар тооцож ажиллах;</p> <p>1.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймаг, нийслэлд баригдах барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэхэд орон нутгаас олгодог зөвшөөрлийг зохих журмын дагуу шуурхай олгоход дэмжлэг үзүүлж ажиллах;</p> <p>1.5. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, чанар, үр дүнд тавих хяналтыг бүх шатанд дээшлүүлж, хөрөнгийг бүртгэж, баталгаажуулахад онцгой анхаарч ажиллах;</p> <p>1.6. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн гэрээний үүргийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, гарсан зөрчил, дутагдлыг арилгуулах, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжид холбогдох гэрээ, хуульд заасны дагуу хариуцлага тооцож ажиллах.</p>		
225	18	27	<p>Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед Монгол Улсын иргэдэд мөнгөн дэмжлэг олгох тухай 2021-04-08 Дугаар 2021_93</p> <p>5. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагааг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй, хэмнэлтийн горимоор, төсвийн сахилга хариуцлагыг чанд баримтлан ажиллахыг төсвийн бүх шатны захирагч нарт тус тус үүрэг болгосугай.</p>	<p>2021.04.08-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 93 дугаар тогтоолын дагуу Сангийн сайдын тушаалаар төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 оны төсөвт зохицуулалт хийж зарим зардлуудыг бууруулж, үйл ажиллагаатай уялдах гол зардлуудыг 12 сард санхүүжүүлэхээр болсон. Тогтоолын хэрэгжилттэй холбоотойгоор УУХҮСайдын багцын 2021 онд батлагдсан төсвийг 39.8 тэрбум төгрөг болгон бууруулаад байна. Санхүүжилтийн хуваарьт оруулсан өөрчлөлттэй холбоотойгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан зайлшгүй санхүүжүүлэх шаардлагатай зарим зардлуудын санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт оруулах саналаа Сангийн яаманд хүргүүлж, үйл ажиллагааг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй, хэмнэлтийн горимоор, төсвийн сахилга хариуцлагыг чанд баримтлан ажиллаж байна.</p>	100%
226	19	28	<p>Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн</p>	<p>Алтны олборлолтыг нэмэгдүүлэх хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монголбанк хооронд алтны салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох ажлыг зохион байгуулахаар тогтсон. Энэ</p>	100%

		<p align="center">амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай 2020-05-06 Дугаар 2020_167</p> <p>1. Эдийн засгийг идэвхжүүлэхэд чиглэсэн дараахь арга хэмжээг ариутгал, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг чанд сахиулсны үндсэн дээр хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүдэд даалгасугай: 1.1. алт олборлолт, нүүрс, газрын тосны экспортыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгаланд;</p>	<p>хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч нарын 2020.05.20-ны өдрийн А/102, А-177 тоот хамтарсан тушаалаар алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээл олгох төлөвлөгөө, журмыг хамтран баталсан.</p> <p>Улмаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч нарын 2021.03.16-ны өдрийн А/52, А-82 дугаар тушаалаар дээр дурдсан алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээл олгох журамд нэмэлт, өөрчлөлт оруулсан.</p> <p>Энэхүү журмаар 6 хүртэлх сар буюу богино хугацаатай зээлийн санхүүжилтийн эргэн төлөлтийг энэ он дуустал сунгаж, урт хугацаат зээлийн санхүүжилтийн эргэн төлөлтийг 24 сар хүртэл байсныг 36 сар хүртэл болгон өөрчилсөн болно.</p> <p>Тус журмын 6.1-д заасны дагуу тус яамнаас уулын ажил гүйцэтгэх баримт бичгийн бүрдлийг хангасан нийт 87 алт олборлогч аж ахуйн нэгжийн жагсаалтыг Монголбанканд албан бичгээр хүргүүлээд байна.</p> <p>Журмын дагуу 2021.05.25-ны өдрийн байдлаар Монголбанкнаас 15 орчим тэрбум төгрөгний санхүүжилтийг аж ахуйн нэгжүүдэд олгосон бол 5 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар Монголбанкны худалдсан авсан үнэт металл 5.83 тн-д хүрсэн байна.</p> <p>Мөн Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 2020.11.21-ний өдрийн 30, 2020.12.02-ны өдрийн 39 дүгээр тушаалуудаар Өмнөговь аймгийн нутагт орших Оюутолгой, Тавантолгойн ордод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам, Цагаан хадны гаалийн хяналтын бүс, хилийн Гашуунсухайт боомт, Нарийнсухайтын ордод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн авто зам, хилийн Шивээхүрэн боомтод ажиллах Ажлын хэсгийг байгуулж, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахал хүн амын дунд тархахаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар, хамгааллын дэглэмийг сахиулах, боомтын аюулгүй байдлыг хангуулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй газар дээр нь үзэж танилцаж, хяналт тавьж, заавар, зөвлөмж өгч, холбогдох зохион байгуулалтыг тухай бүр гүйцэтгэсэн.</p> <p>Тухайлбал, Нүүрс тээврийн жолооч нарыг PCR шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж ЗӨСҮТ-ийн явуулын лабораторийг ажиллуулж байна. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн ажилтан албан хаагчдыг түргэвчилсэн оношлуурт хамруулах, ажилчдын ээлж солилцох асуудлыг шийдвэрлэсэн.</p> <p>Мөн Цагаанхадны гаалийн хяналтын бүс хилийн Гашуунсухайт боомт орчимд Дотоодын цэргийн 50 албан хаагчдыг ажиллуулж, халдвар, хамгааллын дэглэмийг сахиулах арга хэмжээг авсан болно.</p>	<p>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>
--	--	---	--	---

			<p>Түүнчлэн уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч томоохон аж ахуйн нэгжүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Тавантолгой, Нарийнсухайт, Айлбаян, Ерөө-Хүдрийн бүлэг ордод нэгдсэн байдлаар, Оюутолгой, Эрдэнэт, Бор-Өндөр, Хөшөөт, Таяннуур, Улаан, Төмөртийн овоо, Багануур, Шивээ-Овоо, Адуунчулуун, Шарын голын уурхай, газрын тосны Зүүнбаян, Тосон уул, Тамсагийн орд тус бүрт халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах Аюулгүйн тусгай бүсийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 297 дугаар тушаалын дагуу байгуулж хэрэгжилтийг хангаж байна.</p> <p>2020 оны төсвийн тухай хуулийн дагуу энэ онд улсын хэмжээнд нийт 6.6 сая баррель буюу 897.0 мянган тонн газрын тос олборлож, экспортлон, газрын тосны борлуулалтын орлогоос улсын төсөвт 266 тэрбум төгрөг төвлөрүүлэх үүрэг хүлээсэн боловч дэлхий нийтэд тархсан шинэ төрлийн Ковид 19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор газрын тосны экспортын үйл ажиллагааг 2020.01.30-ны өдрөөс эхлэн бүрэн зогсоосон. Улсын онцгой комиссоос баталсан үүл уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журмын дагуу 2020.04.15-ны өдрөөс эхлэн Тамсаг XXI талбайгаас Баянхошуу хилийн боомтоор хоногт 24 автоцистернээр, 2020.06.16-ны өдрөөс эхлэн Тосон-Уул XIX талбайгаас Бичигтийн хилийн боомтоор хоногт 25 автоцистернээр газрын тосны экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг тус тус явуулж эхэлсэн. 2020 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 555 мян.тонн газрын тос экспортолсон байна.</p>			
227	20	29	<p>Нийслэл Улаанбаатар хотын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-05-19 Дугаар 2021_146</p> <p>4. Нийслэл Улаанбаатар хотод багтаамж ихтэй, шинэ төрлийн нийтийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх төсөл, арга хэмжээг судалж, боломжит эх үүсвэрийг тооцож төслийн ажлыг 2021 онд багтаан эхлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт зөвшөөрсүгэй.</p>	Засгийн газрын 2021.02.17-ны өдрийн хуралдааны 11-р тэмдэглэлд “Богдхан төмөр зам” төслийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд эхний ээлжинд зураг төсөв, ТЭЗҮ боловсруулахад шаардагдах 23.0 тэрбум төгрөгийн санхүүжилтыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ий төсвийн тодотголд тусган компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэх саналаа хүргүүлсэн. Компанийн зүгээс Богдхан төмөр замыг хэрэгжүүлэх ажилд өөрийн охин компани болох “Тавантолгой төмөр зам” ХХК-иар дамжуулах оролцох боломжийг судлах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн яамтай хамтран өртгийн урьдчилсан судалгаа боловсруулах, холбогдох тогтоол шийдвэрүүдийн төслийг боловсруулах зэрэг ажлыг гүйцэтгэж байна.	30%	

5.ё. Ерөнхий сайдын захирамж

228	1	1	<p>Төлөвлөгөө батлах тухай 2020-07-01 Дугаар 2020_99</p> <p>2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2022)”-г хавсралт ёсоор баталсугай. 2. Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутагт хэрэгжүүлэх жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай.</p>	<p>Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт Жендэрийн талаар баримтлах бодлого /2019-2026/-ыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019.05.06-ны А/114 дүгээр тушаалаар батлуулсан. Жил бүрийн жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг яамны жендэрийн салбар зөвлөлийн даргаар батлуулж, тайланг хуулийн хугацаанд Жендэрийн үндэсний хороонд хүргүүлж, биелэлтийг ханган ажиллаж байна. Яамны жендэрийн салбар зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлүүдийг багасгахад чиглэсэн холбогдох сургалтыг зохион байгуулж, мэдлэг ойлголт өгөх ажлууд тусгагдан холбогдох сургалтууд хийгдэж байна. Түүнчлэн Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, Төрийн нарийн бичгийн даргын 2021.05.19-ний өдрийн А/49 дүгээр тушаалаар баталсан бөгөөд энэхүү журамд ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх ба хугацаат үзлэгт жил бүр хамруулах бөгөөд эрэгтэй, эмэгтэй ажилтны ялгаатай хэрэгцээг харгалзан үзэх, стресс дарамтын үед сэтгэл зүйн дэмжлэг зөвлөгөө авах боломжоор хангахаар тусгагдсан.</p>	100%	
229	2	2	<p>Ажлын хэсэг байгуулах тухай 2021-03-01 Дугаар 2021_53</p> <p>2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга)-тай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх, холбогдох хуулийн төслийг боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай. 2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай өөрийн эрхэлсэн салбарт хамаарах хууль тогтоомжийг нийцүүлэх, холбогдох хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг тухайн яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулан</p>	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 53 дугаар захирамжийн хүрээнд УУХҮС-ын 2021.03.26-ны өдрийн А/90 дугаар тушаалаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга) батлагдсантай холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулан салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсгийн зүгээс салбарын хууль тогтоомжид оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулсан бөгөөд 2021.04.29-ний өдөр ЗГХЭГ-аас зохион байгуулсан өргөтгөсөн хуралд оролцож, ажлын хэсгийн явцын танилцуулгыг хүргэсэн болно. Хуулийн төслийг 2021 оны 6 дугаар сардаа багтаан боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.</p>	70%	

			байгуулах, тэдгээрт хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.			
230	3	3	<p>Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай 2021-04-13 Дугаар 2021_89</p> <p>2. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай: Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг 2021 оны 5 дугаар сарын 9-ний дотор багтаан боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг (Г.Ёндон)-т даалгасугай.</p>	<p>Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын ерөнхий төлөвлөгөөг гарган Засгийн газрын 2021.03.10-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан. Үүнтэй холбоотойгоор эрх бүхий төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг байгуулахаар тогтож Ерөнхий сайдын 2021.04.13-ны өдрийн 89 дүгээр захирамжаар байгуулж, ажлын хэсгийг хуралдуулсан.</p> <p>Ажлын хэсгийн зүгээс хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулах хүрээнд холбогдох судалгааг АМЕП төслийн санхүүжилтээр гүйцэтгэж байна. Хуулийн төслийн явцын талаар УИХ-ын дарга Г.Занданшатарт холбогдох мэдээлэл, танилцуулгыг хийсэн.</p>	30%	
5.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл						
231	1	1	<p>2020 оны 3 дугаар сарын 14-ний өдөр 14 дүгээр тэмдэглэл 2020-03-04 Дугаар 2020_14</p> <p>ХҮ.2.3. Арилжааны банкны худалдан авсан үнэт цаасны хүүгийн орлого болон “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах тухай холбогдох хуулийн төслийг холбогдох журмын дагуу боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул</p>	<p>Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу холбогдох хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг ЗГХЭГ-т байгуулагдан ажилласан бөгөөд тус яамнаас төлөөлөл орж ажилласан. Тус яамны зүгээс хуулийн төслийг боловсруулан, үзэл баримтлалыг батлуулахаар Сангийн яаманд хүргүүлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авахуулахаар шилжүүлсэн. Гэвч, Сангийн яамны зүгээс аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нь Монгол Улсын нэгдэн орсон “Татварын суурийг бууруулах, ашиг шилжүүлэхийн эсрэг” конвенцтой зөрчилдөх тул хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд дэмжих боломжгүй талаар мэдэгдсэн. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дагуу төсөв, татварын асуудал нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний чиг үүрэгт хамаарах бөгөөд Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын үйл ажиллагааны журмын хүрээнд уг хуулийн төслийг боловсруулах үзэл</p>	100%	МУ-ын ЗГ-ын тухай хуулийн дагуу төсөв, татварын асуудал нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүний чиг үүрэгт хамаарах

			уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт.	баримтлалыг батлах эрх хэмжээ нь Сангийн яамны асуудал байх тул уг асуудлыг чиг үүргийн дагуу Сангийн яаманд хариуцуулах шаардлагатай. Цаашид татварын хуулийн хуулийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх асуудлаар Сангийн яамнаас биелэлт гаргах боломжтой тул УУХҮЯ-ны чиг үүргээс хасуулах саналтай байна.	бөгөөд ХТТХ, ЗГҮАЖурмын хүрээнд уг хуулийн төслийг боловсруулах үзэл баримтлалыг батлах эрх хэмжээ нь СЯ-ны асуудал байх тул уг асуудлыг чиг үүргийн дагуу СЯ-нд хариуцуулах шаардлагатай . Цаашид татварын хуулийн хуулийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх асуудлаар СЯ-аас биелэлт гаргах боломжтой тул УУХҮЯ-ны чиг үүргээс ХАСУУЛАХ САНАЛТАЙ БАЙНА.	
232	2	2	2020 оны 12 дугаар сарын 9-ны өдөр 69 дугаар тэмдэглэл 2020-12-09 Дугаар 2020_69 Ү.. Төрийн цахим шилжилтийн бодлогын уялдааг хангах, төрийн байгууллагуудын мэдээллийн санг	Засгийн газрын хэрэг эрхлэх газраас төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн порталыг ашиглалтад оруулсантай холбогдуулан www.opendata.gov.mn цахим хуудсанд эрдэс баялгийн салбарын статистик мэдээллийг сар бүр тогтмол байршуулж байна. Энэ хүрээнд дараах мэдээллийг холбогдох эх үүсвэрээс авч, цахим санд оруулж байна. Үүнд: геологи, уул уурхай, газрын тосны салбараас Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээлэл, аж үйлдвэрийн	100%	

			<p>нэгтгэн зохион байгуулах замаар төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай, чирэгдэлгүй, оновчтой хүргэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт даалгав.</p>	<p>салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон борлуулалтын хэмжээ, ашигт малтмалын голлох бүтээгдэхүүний экспорт болон импортын мэдээлэл, кадастрын бүртгэлийн мэдээлэл, геологи, хайгуулын мэдээлэл, нүүрс, газрын тос болон хүнд үйлдвэрийн салбарын статистик мэдээлэл, Ашигт малтмал, газрын тосны газрын Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээлэл зэрэг багтаж байна.</p> <p>Мөн түүнчлэн салбарын хэмжээнд статистик мэдээллийн бэлэн байдлыг сайжруулах зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.12.07-ны өдрийн А-311 дугаар тушаалын дагуу Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албанаас холбогдох мэдээ, тайланг хүлээн авч ажиллаж байна. Мэдээллийг тухай бүрт нь байршуулсан.</p>		
233	3	3	<p>2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр 58 дугаар тэмдэглэл 2020-11-04 Дугаар 2020_58</p> <p>ХҮҮ.2. . Монгол Улсын Ерөнхий сайдын Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын үйл ажиллагаатай танилцсан дүнгийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав: Салбарын хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах асуудлын хүрээнд Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, энэ онд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд;</p>	<p>1. Ашигт малтмалын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, мөн Ашигт малтмалын тухай хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хуулийн төслийг боловсруулах зорилгын хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар баталсан. Тус ажлын хэсэг нь 2021.02.25-ны өдрөөс 2021.05.21-ний өдрийг хүртэл хугацаанд вакуумжин ажиллаж Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж удирдлагуудад танилцуулсан. Мөн ажлын хэсгийн судлаачдын багийн гишүүдээс Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгааг хийж ажилласан.</p> <p>Хуулийн төслийг Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албаны албан хаагчдад танилцуулан санал хүлээн авч байгаа бөгөөд 2021 оны 7 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.</p> <p>2. Газрын тосны тухай болон Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮ-ийн сайдын 2021 оны А/12 дугаар тушаалаар байгуулсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох судалгаа хийх үүрэг бүхий хуулийн фирмийг сонгон шалгаруулах ажлыг АМГТГ хариуцан гүйцэтгэж байна. Хийсэн судалгааны ажил дээр үндэслэн ажлыг хэсэг хуулийн төслийг боловсруулна.</p>	70%	
234	4	4	<p>2021 оны 2 дугаар сарын 3-ны өдөр 8 дугаар тэмдэглэл</p>	<p>Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын ерөнхий төлөвлөгөөг гарган Засгийн газрын 2021.03.10-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан. Үүнтэй холбоотойгоор эрх бүхий төрийн</p>	30%	

			<p>2021-02-08 Дугаар 2021_8</p> <p>I.4. 5. Үндэсний баялгийн сан байгуулах ажлыг эрчимжүүлж, уг сангаас дэд бүтцийн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх асуудлыг судалж танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт;</p>	байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг байгуулахаар тогтож Ерөнхий сайдын 2021.04.13-ны өдрийн 89 дүгээр захирамжаар байгуулж, ажлын хэсгийг хуралдуулсан. Ажлын хэсгийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхой болгож, бусад баялгийн сантай хэрхэн уялдах, хөгжлийн банзны чиг үүрэгт уялдуулах зэрэг асуудлаар хэлэлцэн шаардлагатай судалгааг хийхээр тогтсон. Энэ хүрээнд АМЕП төслийн дэмжлэгээр гадаадын болон дотоодын хөндлөнгийн судалгааг хийж байгаа ба судалгааны үр дүнд үндэслэн, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулна.		
235	5	5	<p>2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр 17 дугаар тэмдэглэл 2021-03-10 Дугаар 2021_17</p> <p>XII.4. . Монгол Улсын Засгийн газраас 2020-2024 онд уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх төмөрхон бүтээн байгуулалт, “Үндэсний баялгийн сангийн тухай” болон “Эрдэс баялгийн биржийн тухай” хуулийн төслүүдийн явцын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав: 1. “Үндэсний баялгийн сангийн тухай” хуулийн төслийг хамтарсан Ажлын хэсэг байгуулж Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхлан нарт.</p>	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулаад байна. Хуулийн төслийн үзэл баримтлалын тандан судалгааг гүйцэтгэж байна.	30%	
236	5	6	<p>XII.4. 2. “Эрдэс баялгийн биржийн тухай” хуулийн төслийг хамтарсан Ажлын хэсэг байгуулж Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Б.Жавхлан,</p>	Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн төслийг боловсруулах холбогдох төрийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг УУХҮС-ын 2021 оны А/51 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсгээс хуулийн төслийг болон үзэл баримтлалын төслийг боловсруулсан. Үзэл баримтлалыг Сангийн ямаар батлуулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн боловч Хууль зүй, дотоод хэргийн яамнаас үзэл баримтлалыг төслийг хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлага, тандан судалгааг хийж ирүүлэх шаардлагатай гэсэн үндэслэлээр	30%	

		<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт</p>	
237	6	<p>2021 оны 3 дугаар сарын 03-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03 Дугаар 2021_14 XII.2. Засгийн газраас 2020-2024 онд санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав: 1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоол болон Засгийн газрын 2020 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын төлөвлөгөө"-нд тусгагдсан хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж, 2021 оны II улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</p>	<p>буцаан ирүүлсэн болно. Ийнхүү Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлага, тандан судалгааг боловсруулж байгаа болно. Үүний дараа Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хэлэлцүүлэг зохион байгуулж, Засгийн газрын гишүүдээс санал авахаар төлөвлөн ажиллаж байна. Энэ онд багтаан Засгийн газраар хэлэлцүүлэн Улсын Их хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Ашигт малтмалын тухай, Үндэсний баялгийн сангийн тухай, Эрдэс баялгийн биржийн тухай, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг тус тус боловсруулах ажлын хэсгийг байгуулж Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох судалгааг хийн, хуулийн төслийг боловсруулж байна. Хуулийн төслүүдийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Хуулийн төслийн боловсруулалтын явцаас танилцуулбал:</p> <p>1/ Ашигт малтмалын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, мөн Ашигт малтмалын тухай хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хуулийн төслийг боловсруулах зорилгын хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар баталсан. Тус ажлын хэсэг нь 2021.02.25-ны өдрөөс 2021.05.21-ний өдрийг хүртэл хугацаанд вакуумжин ажиллаж Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж удирдлагуудад танилцуулсан.</p> <p>Мөн ажлын хэсгийн судлаачдын багийн гишүүдээс Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгааг хийж ажилласан.</p> <p>Хуулийн төслийг Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албаны албан хаагчдад танилцуулан санал хүлээн авч байгаа бөгөөд 2021 оны 7 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.</p> <p>2/ Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөлөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулах хэрэгцээ шаардлагын тандан судалгааг АМЭП төслийн хүрээнд хийж байна.</p> <p>3/ Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий холбогдох төрийн байгууллагуудын төлөөлөөс бүрдсэн</p>

			<p>Ц.Нямдорж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт;</p>	<p>ажлын хэсгийг УУХҮС-ын 2021 оны А/51 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсгээс хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ шаардлагын тандан судалгааг хийж, хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төслийг боловсруулж байна. Хуулийн төслийн явц 80 хувьтай байна.</p> <p>4/ Үндсэн хуулиар иргэн байгалийн баялаг ашиглалтаас үр өгөөж хүртэх энэ талаар мэдэх эрхтэй байхаар заасны дагуу Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг УУХҮС-ын 2020 оны А/270 дугаар тушаалаар байгуулж, хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааг хийж, үзэл баримтлалыг батлуулсан. Хуулийн төслийг боловсруулж яамны цахим хуудаст тавьж олон нийтийн саналыг авч байна.</p>		
238	6	8	<p>XII.2.2. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгандсан хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлын төлөвлөгөөг баталж, үндсэн чиглэлд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Ашигт малтмалын тухай, Үндэсний баялгийн сангийн тухай, Эрдэс баялгийн биржийн тухай, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг тус тус боловсруулах ажлын хэсгийг байгуулж Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох судалгааг хийн, хуулийн төслийг боловсруулж байна. Хуулийн төслүүдийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Хуулийн төслийн боловсруулалтын явцаас танилцуулбал:</p> <p>1/ Ашигт малтмалын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, мөн Ашигт малтмалын тухай хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хуулийн төслийг боловсруулах зорилгын хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар баталсан. Тус ажлын хэсэг нь 2021.02.25-ны өдрөөс 2021.05.21-ний өдрийг хүртэл хугацаанд вакуумжин ажиллаж Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж удирдлагуудад танилцуулсан.</p> <p>Мөн ажлын хэсгийн судлаачдын багийн гишүүдээс Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгааг хийж ажилласан.</p> <p>Хуулийн төслийг Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албаны албан хаагчдад танилцуулан санал хүлээн авч байгаа бөгөөд 2021 оны 7 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.</p> <p>2/ Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс</p>	70%	

				<p>бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулаад байна.</p> <p>3/ Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий холбогдох төрийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг УУХҮС-ын 2021 оны А/51 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсгээс хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төслийг боловсруулаад байна. Хуулийн төслийн явц 80 хувьтай байна.</p> <p>4/ Үндсэн хуулиар иргэн байгалийн баялаг ашиглалтаас үр өгөөж хүртэх энэ талаар мэдэх эрхтэй байхаар заасны дагуу Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг УУХҮС-ын 2020 оны А/270 дугаар тушаалаар байгуулж, хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааг хийж, үзэл баримтлалыг батлуулсан. Хуулийн төслийг боловсруулж яамны цахим хуудаст тавьж олон нийтийн саналыг авч байна.</p>		
239	7	9	<p>2021 оны 3 дугаар сарын 17-ны өдөр 16 дугаар тэмдэглэл 2021-03-17 Дугаар 2021_18</p> <p>ХҮ.6.1. Эдийн засгийн тэргүүлэх ач холбогдолтой 100 төсөл, арга хэмжээний талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг дор дурдсан албан тушаалтанд даалгав:</p> <p>1. Эдийн засгийн ач холбогдол, үр өгөөжийг харгалзан 100 төсөл, арга хэмжээг сонгож улсын төсөв, Засгийн газарт өрийн дарамтгүйгээр, хувийн хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлийн арга хэлбэрүүдийг ашиглан 2021 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх, хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг эрчимжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд;</p>	<p>“Тэргүүлэх салбаруудад хэрэгжүүлэх 100 төсөл, арга хэмжээ”-ний төсөлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээний мэдээллийг шинэчилэн боловсруулж 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 01/972 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Эдийн засгийн ач холбогдол, үр өгөөжийг харгалзан уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн 8 төсөл, 2 арга хэмжээг тэргүүлэх ач холбогдолтой 100 төсөл, арга хэмжээнд оруулах талаар санал хүргүүлсэн болно.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 100 хоног буюу 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Ковид цар тахлын дараах эдийн засгийг сэргээх 100+ төсөл арга хэмжээг танилцуулсан бөгөөд УУХҮЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд Үндэсний аюулгүй байдал, стратегийн ач холбогдол бүхий 6 төсөл, хөрөнгө оруулагчдад санал болгож буй 2 төсөл нийт 8 төсөл багтсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэр 2. Эрдэнэтийн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр 3. Исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл 4. Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн ҮТП байгуулах төсөл 5. Газрын тос боловсруулах үйлдвэр 6. Оюутолгой төслийн далд уурхайг ашиглалтад оруулах 7. Дорноговь аймагт хар төмөрлөгийн үйлдвэр барих 8. Дарханы металлургийн цогцолбор <p>Эдгээр төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаж байна.</p>	100%	
240	8	10	<p>2021 оны 3 дугаар сарын 31-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл</p>	<p>Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой заадаг бөгөөд зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тухайн жилийн хүрсэн</p>	100%	

			<p>2021-03-31 Дугаар 2021_21</p> <p>Х.2.2. Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой зааж байх, үндсэн чиглэлд заасан зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тухайн жилийн хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлж байхыг Засгийн газрын гишүүд, холбогдох Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгов.</p>	түвшинтэй харьцуулан Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн үнэлгээг хийж байна.		
241	8	11	<p>ҮИ.9. Хилийн боомтуудын экспорт, импортын хэвийн үйл ажиллагааг хангах, ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэх, тасалдалгүй байхаар зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгав.</p>	<p>Улсын Онцгой комиссын даргын 2020 оны “Ажилчдын ээлж солих тухай” 41 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангаж, УУХҮ-ийн сайд, Эрүүл мэндийн сайд, Зам тээврийн хөгжлийн сайдын хамтарсан тушаалаар “Ажилтнуудын ээлж солилцож, шилжилт хөдөлгөөн хийх үйл ажиллагаанд баримтлах түр журам” –ыг баталж, уурхайнууд болон тэдгээрийн туслан гүйцэтгэгчид, ханган нийлүүлэгчид, тээвэрлэгчид, харуул хамгаалалтын гэрээт аж ахуйн нэгжүүдийн ажилчдын ээлж солилтыг 2020 оны 12 сараас эхлэн нэгдсэн зохион байгуулалтаар ханган ажиллаа. 3 дугаар сард 107 аж ахуйн нэгжийн 9926 ажилчдыг шинжилгээнд хамруулан орон нутаг руу ээлжинд гаргаж, 6328 ажилчдыг ээлжээс буулгасан ба УОК-ийн 02 дугаар тогтоол болон Өмнөговь аймгийн ОК-оос өгсөн чиглэлийн дагуу 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаагаар ажилчдын ээлж солилтыг зогсоож, уурхайн ажилчдыг вакцинжуулах ажлын бэлтгэлийг хангаж байна.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын томоохон 31 аж ахуйн нэгжээс Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвшөөрөлтэй түргэвчилсэн оношлуурыг нэгдсэн журмаар нийлүүлэхийг хүссэний дагуу Эрүүл мэндийн яамтай хамтран 2 удаагийн татан авалтаар нийт 321000 түргэвчилсэн оношлуурыг Солонгос улсаас нийлүүлсэн.</p> <p>Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн жолооч нарыг нэн түрүүнд вакцинд хамруулах шийдвэрийг Эрүүл мэндийн яамнаас гаргуулан Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газарт 11000 вакцины тун хүргүүлснээр Гашуун сухайт боомтын 5449, Оюутолгойн тээврийн 200, Шивээ хүрэн боомтын 1658, нийт 7307 тээврийн жолооч, тээвэр хариуцсан ажилчдыг Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг вакцинд хамруулаад байна. Вакцины 2 дахь тунг 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн хийх болно.</p> <p>Мөн уул уурхайн экспортын голлох нэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч уурхайнуудын 38.8 мянга гаруй ажилчдын дархлаажуулалтын</p>	100%	

вакцинжуулалтыг 5 чиглэлээр төлөвлөн, Зэвсэгт Хүчний Жанжин штабын даргын тушаалаар томилогдсон дархлаажуулалтын явуулын багтай хамтарч эхний 2 чиглэл/ Тавантолгой ба Нарийн сухайтын бүлэг орд/-ийн 84 аж ахуйн нэгжийн 9658 уурхайчдыг вакцинд хамруулсан ба 2 дахь тунг 4 сарын 17-ны өдрөөс эхлүүлнэ.

Эрүүл мэндийн яамтай хамтран Төвийн бүсийн томоохон 7 аж ахуйн нэгжүүдийн 17294 вакцины тунгийн хангалтыг тухайн орон нутгийн Эрүүл мэндийн газарт нь хүргүүлж, Шивээ-Овоо ХК, Дархан төмөрлөгийн үйлдвэр ХХК, Шарын гол ХК-ын ажилчдыг 100 хувь вакцинжуулалтад хамруулаад байна. Эрдэнэт үйлдвэр 12000 вакцины тунгийн татан авалтыг хийснээр өнөөдрийн байдлаар 6147 ажилчдыг вакцинд хамруулсан ба вакцинжуулалт үргэлжилж байна. Зүүн болон баруун бүсийн 9 уурхайн 5454 ажилчдын вакцинжуулалтыг Зэвсэгт Хүчний Жанжин штабын явуулын багтай хамтран зохион байгуулахаар бэлтгэлийг хангаж, вакцины хангалтыг хүлээж байна.

Түүнчлэн Өмнөговь аймгийн Шивээхүрэн боомтод нүүрсний чингэлэгт тээврийн хяналтын нэмэлт гарцыг өөрийн хөрөнгөөр барьж байгуулж, Хил хамгаалах ерөнхий газарт үнэ төлбөргүй шилжүүлэх тухай Монголын Алт (МАК) ХХК-ийн 2020 оны 02/1041 дүгээр албан бичгийн дагуу "Хяналтын нэмэлт гарц барьж хүлээлгэн өгөх тухай гэрээ"-ний төслийг боловсруулан батлуулахаар Хил хамгаалах газар, Монголын Алт (МАК) ХХК-иудад 2021.02.19-ний өдрийн 01/390 дүгээр бичгээр хүргүүлж, 2021.03.29-ний өдөр гэрээ байгуулсан. Улмаар Шивээхүрэн боомтод баригдаж байгаа нүүрс тээвэрлэлтийн чингэлэгтэй автомашины хяналтын нэмэлт гарцыг ашиглалтад оруулах ажилтай зэрэгцээ цаг алдалгүй гаалийн хяналтын бүс байгуулах ажлын зураг төслийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх зорилгоор Засгийн газрын тогтоолын төсөлд яамдаас санал авч байна. Засгийн газрын тогтоолын төсөлд 2021.04.12-ны өдрийн байдлаар 8 яамдаас санал ирүүлээд байна.

Ховд аймгийн Булган боомтын хилээр нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 7 хоногийн Даваа-Ням гарагт хил, гаалийн ажиллах цагийн хуваарийг сунгах, тогтмол хуваарьтай болгох асуудлыг ГХЯ-нд тавьж, 2021 онд Булган-Такашикэн боомтыг "Бямба", "Ням" гарагт 10:00-19:00 цагт түр горимоор ажиллуулж, нүүрсний тээвэр, уул уурхайн бүтээгдэхүүн нэвтрүүлэхээр болоод байна.

Уул уурхайн салбар 2021 оны эхнээс 7,016.4 мян.тн нүүрс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс 107 хувиар өссөн, 2,119.7 мян.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс 8.5 хувиар буурсан, 335.4 мян.тн зэсийн баяжмал экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс 1.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2021 он гарсаар Монгол

				<p>банкны худалдан авсан үнэт металл 3.3 тн-д хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 2.2 тн буюу 40.0 хувиар буурсан байна.</p> <p>2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 04 дүгээр сарын 11-ний өдрүүдэд 135.0 мян.бар газрын тос экспортолж, оны эхнээс 1,514.5 мян.бар газрын тос экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс 346 хувиар өссөн байна.</p>		
242	9	12	<p>2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр 22 дугаар тэмдэглэл 2021-04-07</p> <p>Дугаар 2021_22</p> <p>IX.3.2. Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан цахим систем бүхий аргачлалын дагуу боловсруулах, холбогдох бэлтгэл ажлыг 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.</p>	<p>Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн саналыг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлал"-ын дагуу боловсруулан 2021.05.06-ны 01/1194 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.</p>	100%	
243	10	13	<p>2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 19 дүгээр тэмдэглэл 2021-03-24</p> <p>Дугаар 2021_19</p> <p>II.. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" асуудлыг хэлэлцээд Засгийн газрын тогтоол гаргахаар тогтов. 2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай тайлан, үнэлгээний дүнг хэлэлцэн дэмжээд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, хууль, тогтоолд заасны дагуу эрх шилжүүлэн зохион байгуулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын</p>	<p>Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд УУХҮЯ-нд нийт 9 нэр төрлийн 29.7 тэрбум төгрөгийн, УУХҮС-ын багцын хэмжээнд 30.9 тэрбум төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөн, УУХҮС-ын 2021.04.13-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эдгээр батлагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу, хэмнэлттэй, үр ашигтай байх зарчмыг баримтлан зарцуулж байна. Засгийн газрын 2021 оны 15 дугаар тогтоолоор аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан бөгөөд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцад хамаарах төсөл арга хэмжээ тусгагдаагүй болно.</p>	100%	

			дагуу шуурхай зохион байгуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгав.		
244	10	14	<p>II.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удааширч байгаа төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг мэргэжлийн байгууллагатай хамтран нягтлан тогтоож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.</p>	<p>Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2021.03.29-ны өдрийн А/29 дугаар тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 317 дугаар тушаалаар батлагдсан төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан концессын гэрээгээр хэрэгжиж байгаа болон гэрээ байгуулагдсан боловч ажил эхлээгүй, хэоэгжилт удаашралтай байгаа концессын гэрээний хэрэгжилтэд дүгнэлт гарган, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт ХҮБГ-ын Дэд бүтцийн хэлтсийн дарга С.Сүхбат ажилласан. Улмаар УУХҮЯ-ны ТНБДаргын 2021.04.15-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар ХҮБГ-ын ДБХ-ийн дарга С.Сүхбат ахлах шинжээч Д.Отгонбаяр нар тус томилолтын хэсгийн бүрэлдэхүүнд орж Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн концессын бүтээн байгуулалттай газар дээр нь танилцсан. Ажлын хэсгийн гаргасан санал дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2021.04.28-ны өдрийн хуралдааны 27 дугаар тэмдэглэл гарсан. Монгол Улын Их Хурлын даргын 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн Ажлын хэсэг байгуулах тухай 18 дугаар захирамжаар концессын тухай хууль тогтоомж, гэрээний хэрэгжилтийг Дарханы төмөрлөгийн үйлдвэрт хэрхэн хэрэгжүүлж байгааг шалгах, санал, дүгнэлт гарган, шийдвэрийн төсөл боловсруулж УИХ-д танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Ажил хэсэг нь шалгалтын дүн, шийдвэрийн төслийг 2021 онд багтаан УИХ-д танилцуулах юм. Иймээс уг тэмдэглэлд Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн концессын гэрээний асуудлыг хэрхэн шийдвэрлэх асуудлыг оруулаагүй болно. Газрын тосны бүтээгдэхүүний Улсын нөөцийн агуулах 2012 онд 21.900.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр анх баригдаж эхэлсэн. Нийт гүйцэтгэсэн ажлын хэмжээ 3.6 тэрбум төгрөг, 2012 онд 750.0 сая төгрөг, 2017 онд шүүхийн шийдвэрээр 2833.9 сая төгрөг тус тус төсөвт тусган санхүүжүүлсэн. Төслийг төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний дагуу "НТТ" ХХК-тай концессын гэрээ байгуулагдах, төслийн бэлтгэл ажлыг хангах ажил хийгдэж байна.</p>	70%
245	11	15	<p>2021 оны 6 дугаар сарын 1-ний өдөр 33 дугаар тэмдэглэл 2021-06-01 Дугаар 2021_33</p> <p>Ү1.1. . Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээний талаар Монгол Улсын</p>	<p>“Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-нд УУХҮЯ-наас авч хэрэгжүүлж буй ажлуудын хэрэгжилтийг эрчимжүүлж, хариуцан болон хамтран хэрэгжүүлэх 7 зорилтын хүрээнд хэрэгжилтийн тайланг долоо хоног бүрийн Баасан гарагт Сангийн яаманд хүргүүлэн ажиллаж байна.</p>	100%

			<p>Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. ҮИ.2. “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:</p> <p>1. Төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, тайлагнах үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.</p>		
246	12	16	<p>2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2021-02-10 Дугаар 2021_9</p> <p>ХИ.3. . “Таван толгой түлш” ХХК-ийн Сонгинохайрхан дүүрэгт байрлах баруун бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орших зүүн бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр рүү нүүлгэн шилжүүлэх талаар Эрчим хүчний сайд Н.Тавинбэх Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах баруун бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг Төв аймгийн Сэргэлэн сумын 1 дүгээр багийн нутагт орших зүүн бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр рүү нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 10, тус үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг 2021</p>	<p>Эрчим хүчний сайдын 2021 оны А/71 дүгээр тушаалаар “Таван толгой түлш” ХХК-ийн Улаанбаатар хотын Сонгинохархан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах сайжруулсан шахмал түлшний баруун бүсийн үйлдвэрийг Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах зүүн бүсийн үйлдвэр лүү шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, зардлын тооцоог боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулсан. Ажлын хэсэг баруун бүсийн үйлдвэрийг шилжүүлэх зардлын тооцоог боловсруулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <p>-Баруун бүсийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийн байдалтай танилцах ажлыг зохион байгуулж, шилжүүлэх боломжтой тоног төхөөрөмжийн тооцоо судалгааг урьдчилсан байдлаар гаргав.</p> <p>-Зүүн бүсийн үйлдвэрийн ерөнхий төлөвлөгөөнд шинээр баригдах барилга, байгууламжийн төлөвлөгөөг тусгаж шинэчлэн боловсруулав.</p>	<p>30%</p> <p>ЭХЯ-ны эрхлэх асуудалд хамаарах тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.</p>

			оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, "Таван толгой түлш" ХХК (М.Ганбаатар) нарт;		
247	12	17	XII.3. 2. "Таван толгой түлш" ХХК-ийн үйлдвэрийг шилжүүлэхэд шаардагдах зардлыг судалж танилцуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ), "Таван толгой түлш" ХХК (М.Ганбаатар) нарт;	Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах зүүн бүсийн үйлдвэр лүү шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, зардлын тооцоог боловсруулах ажлын хэсэг баруун бүсийн 1, 2, 3 дугаар үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шилжүүлэх, шинээр баригдах барилга байгууламж, газар шорооны ажил, цахилгаан хангамжийн ажлын урьдчилсан төсөв тооцоог боловсруулсан	30%
248	12	18	XII.3. 3. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах баруун бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн ашиглаж байсан газар, барилга байгууламжийг сайжруулсан шахмал түлшний нөөцийн агуулахын зориулалтаар ашиглах арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, "Таван толгой түлш" ХХК (М.Ганбаатар) нарт;	Одоогийн байдлаар урьдчилсан төсөв боловсруулсан бөгөөд, үйлдвэрийг шилжүүлсний дараа баруун бүсийн үйлдвэрийн барилгыг сайжруулсан шахмал түлшний агуулахын чиглэлээр ашиглахаар төлөвлөсөн.	30% ЭХЯ-ны эрхлэх асуудалд хамаарах тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.
249	12	19	XII.3. 4. "Таван толгой түлш" ХХК-ийн Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших зүүн бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах талаар холбогдох хууль тогтоомжийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхийг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, "Таван толгой түлш" ХХК (М.Ганбаатар) нарт;	Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах Зүүн бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгдэж байна.	70% ЭХЯ-ны эрхлэх асуудалд хамаарах тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.
250	12	20	XII.3. 5. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт байрлах "Таван толгой түлш" ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний	"Таван толгой түлш" ХХК-ийн Хэрэглэгдэд үйлчлэх албаны хяналтын 250 ажилтнууд 2021.02.11-12-ны өдрүүдэд Сайжруулсан шахмал түлшний баруун бүсийн үйлдвэрийн орчны айл өрх, зам гудамж талбай, хөрсний бохирдлыг цэвэрлэх арга хэмжээ авч ажилласан.	100% Тэмдэглэлийн дагуу

			баруун бүсийн үйлдвэрийн түлш үйлдвэрлэх явцад бий болсон орчны болон хөрсний бохирдлыг цэвэрлэх ажлыг тус дүүргийн тохижилт үйлчилгээний байгууллагаар гүйцэтгүүлэхийг Нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазар, “Таван толгой түлш” ХХК (М.Ганбаатар) нарт.		холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.	
5.3. Засгийн газрын албан даалгавар						
251	1	1	Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай 2019-10-16 Дугаар 2019_03 1.1. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний төлбөр тооцоонд "Цахим төлбөрийн баримтын систем" /ebarimt/ нэвтрүүлэх ажлыг 2019 онд багтаан иргэдэд чиргэдэл үүсгэлгүйгээр шуурхай зохион байгуулах.	УУХҮ-ийн сайдын 2019.11.04-ний өдрийн А/216 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний геомэдээллийн сан үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2.6.2 “Цахим үйлчилгээний төлбөрийн систем нэвтрүүлэх” арга хэмжээг 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд оруулсан. Геологийн баримтын төв архив иргэд, аж ахуйн нэгжид үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг цахимаар авч, ebarimt ашиглаж байна. АМГТГ-т тусгай зөвшөөрлийн төлбөр, үйлчилгээний хөлсийг төрийн “ДАН” цахим төлбөр тооцооны нэгдсэн системд холбох ажлыг туршиж байна.	100%	
252	1	2	1.2. Цахим төлбөр тооцоонд шилжихтэй холбоотойгоор үйлчилгээний ажилтнуудыг сургаж бэлтгэх, төлбөр тооцооны системийн талаар иргэдэд сурталчилан таниулах.	Цахим төлбөр тооцоонд шилжихтэй холбоотойгоор үйлчилгээний ажилтнуудыг сургах, төлбөр тооцооны талаар иргэдэд сурталчилан таниулах ажлыг эхлүүлсэн. Салбарын 2021-2024 оны цахим шилжилтийн төлөвлөгөөний төсөлд тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна.	100%	
253	1	3	1.3. Цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх.	Салбарын хэмжээнд цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Мөн Пасс СА ХХК-иас УУХҮЯ-нд 2020.11.09-ний өдөр "Тоон гарын үсэг нэвтрүүлэх" тухай ирүүлсэн албан хүсэлтийн дагуу УУХҮ-ийн сайдад танилцуулга бэлтгэж танилцуулсан бөгөөд цаашид тус компанитай хамтарч ажиллахаар төлөвлөж байна. Мөн Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний дата төвийн хооронд 2020.05.28-ны өдөр байгуулагдсан БА99, 2020/34 дугаартай хамтран ажиллах гэрээний дагуу Тоон гарын үсгийн гэрчилгээ олгогдсон бөгөөд Уул уурхайн компьютержсан кадастрын системд нэвтрүүлэх ажил хийгдэж байна.	70%	
254	1	4	1.4. Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд зааснаар УУХҮЯ нь газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, газрын тос хайх, уламжлалт бус газрын тос хайх, газрын тос ашиглах, уламжлалт бус газрын тос ашиглах, төмөрлөг боловсруулах, машины	30%	

				<p>үйлдвэрлэл эрхлэх, үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх, үүсмэл орд ашиглах, тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлох, үйлдвэрлэх, пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах тэсэлгээний ажил явуулах зэрэг тусгай зөвшөөрлүүдийг олгодог.</p> <p>Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд тус яамнаас тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд цахим системийг нэвтрүүлэх ажлыг 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Энэ хүрээнд тусгай зөвшөөрлүүдийг цахимаар олгодог болсноор төрийн байгууллагын үйлчилгээ нээлттэй, ил тод, түргэн шуурхай болохын зэрэгцээ тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн зардал тодорхой хэмжээгээр буурах боломжтой. Төрийн цахим үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах асуудал нь хуулиар зохицуулагдана.</p>		
255	1	5	<p>1.5. Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэхтэй холбогдуулан шаардлагатай бол эрхлэх асуудлын хүрээнд болон нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөж байгаа эрх зүйн актуудад зохих өөрчлөлт оруулах.</p>	<p>УУХҮЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн ба шаардлагатай эрх зүйн актуудад өөрчлөлт оруулах холбогдох арга хэмжээг авч ажиллана.</p>	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.	
256	1	6	<p>3.. Албан даалгаврын хэрэгжилтийг дүгнэж, тайланг улирал бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг улирал тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд.</p>	<p>УУХҮЯ-ны эрхлэх асуудлын хүрээний цахим шилжилтийн арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж Төрийн нарийн бичгийн даргын 2020.12.25-ны өдрийн 03/3218 албан тоотой ЗГХЭГ-т хүргүүлсэн. 2021 оны эхний хагас жилд гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг боловсруулж ТЗУГ-т хүргүүлсэн.</p>	100%	
257	2	7	<p>Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2</p> <p>1.3. Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэх;</p>	<p>Эрдэс баялгийн салбарын хэмжээнд хэрэгжүүлэх цахим шилжилтийн арга хэмжээний төсөлд тусган ЗГХЭГ-т хүргүүлсэн. УУХҮЯ-нд төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх ажлын хүрээнд ХШҮДАГ-т Цахим бодлого, мэдээллийн технологийн хэлтэс байгуулан дарга, 3 мэргэжилтэнтэй үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү ажлыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж шинээр авч яамны дотоод ажлын хэрэгцээнд ашиглан төрийн үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Төрийн энтерпрайз архитектурын платформыг нэврүүлэх сургалтанд 2 мэргэжилтэн сургасан. Мөн "Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв" УҮГ-тай хамтран УУХҮЯ-наас олгогдох тусгай зөвшөөрлийг цахимжуулах системүүдийн</p>	70%	

				<p>суурилуулалт хийхээр серверийг бүрэн шинэчилсэн. Үүнд: R740 сервер 32 core, Vmware вертуал үйлдлийн систем хуулгах программ, PA-220 firewall, Microsoft 365 нэвтрүүлж ажилсан. "Office 365"-ийн Sharepoint хөгжүүлхэд 1 ажилтанг сургасан. УУХҮЯ-наас аж ахуйн нэгжид олгогдож буй тусгай зөвшөөрлүүдийг цахим системд шилжүүлэх болон ЭБМЗ-ийн үйл ажиллагааны бүртгэлийн систем хөгжүүлэх ажлуудыг гүйцэтгэгч компанитай хамтран хэрэгжүүлж байна.</p> <p>Цахим төлбөр тооцоонд шилжсэний дараа байгууллагын дотоод дүрэм, журамд өөрчлөлт оруулах санал боловсруулж батлуулан, холбогдох сургалтад ажилтнуудыг хамруулна.</p>		
258	2	8	<p>1.4. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарч буй аливаа лавлагаа тодорхойлолтыг шалган баталгаажуулж байх, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, харилцан солилцож байх;</p>	<p>Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж "e-Mongolia" цонхонд нэгтгэх салбарын 18 ажлуудын санал боловсруулж ХХМТГ-т ТНБД-ын 2020.12.24-ний өдрийн 03/3205 албан тоотой хүргүүлсэн.</p> <p>Улсын онцгой комиссын шийдвэрийн хүрээнд үйл ажиллагааг нь хязгаарлаагүй нэр бүхий 13 салбарын ажилтан, албан хаагчид нийтийн тээврийн хэрэгсэл, албаны болон хувийн автомашинаараа 06.00-22.00 цагийн хооронд нээлттэй зорчих болсон. Үүний дотор газрын тосны бүтээгдэхүүний хангалт, түгээлтийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн шатахууны тээврийн машины дугаар, жолоочийн мэдээллийг нэгтгэн гаргаж QR код авах хүсэлтийг Нийслэлийн Онцгой комисст хүргүүлэн авах ажлыг гүйцэтгэсэн. QR код баталгаажсан эсэхийг "Smart.mn" сайтаас татан авч хөдөлгөөнд хэвийн оролцуулсан.</p>	70%	
259	2	9	<p>1.5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах;</p>	<p>Салбарын хэмжээнд цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Мон Пасс СА ХХК-иас УУХҮЯ-нд 2020.11.09-ний өдөр "Тоон гарын үсэг нэвтрүүлэх" тухай ирүүлсэн албан хүсэлтийн дагуу УУХҮ-ийн сайдад танилцуулга бэлтгэж танилцуулсан бөгөөд цаашид тус компанитай хамтарч ажиллахаар төлөвлөж байна. Мөн Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний дата төвийн хооронд 2020.05.28-ны өдөр байгуулагдсан БА99, 2020/34 дугаартай хамтран ажиллах гэрээний дагуу Тоон гарын үсгийн гэрчилгээ олгогдсон бөгөөд Уул уурхайн компьютержсан кадастрын системд нэвтрүүлэх ажил хийгдэж байна. ГУУКХ-ийн Улсын бүртгэлийн мэдээллийн санд хандах эрх бүхий 5 албан тушаалтанд тоон гарын үсгийг олгож, үйл ажиллагаанд туршиж байна.</p>	100%	
260	2	10	<p>1.6. Төрийн цахим үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах;</p>	<p>Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд зааснаар УУХҮЯ нь газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, газрын тос хайх, уламжлалт бус газрын тос хайх, газрын тос ашиглах, уламжлалт бус газрын тос ашиглах, төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх, үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх, үүсмэл орд ашиглах, тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний</p>	30%	

				<p>хэрэгсэл импортлох, экспортлох, үйлдвэрлэх, пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах тэсэлгээний ажил явуулах зэрэг тусгай зөвшөөрлүүдийг олгодог.</p> <p>Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд тус яамнаас тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд цахим системийг нэвтрүүлэх ажлыг 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Энэ хүрээнд тусгай зөвшөөрлүүдийг цахимаар олгодог болсноор төрийн байгууллагын үйлчилгээ нээлттэй, ил тод, түргэн шуурхай болохын зэрэгцээ тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн зардал тодорхой хэмжээгээр буурах боломжтой. Төрийн цахим үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах асуудал нь хуулиар зохицуулагдана.</p>		
261	2	11	<p>1.7. ХУР системд холбогдсон мэдээллийн системийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай нягт хамтран ажиллах;</p>	<p>Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд тус яамнаас тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд цахим системийг нэвтрүүлэх ажлыг 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Уг систем нь төрийн мэдээлэл солилцооны ХУР системтэй холбогдон ажиллах бөгөөд системийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай нягт хамтран ажиллах болно.</p> <p>Үндэсний дата төв болон Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээлэл солилцох, систем ашиглах 2020 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн ХУР/20-12 2020/33 тоот гэрээний дагуу ХУР системтэй холбох аж ахуй нэгжийн мэдээллийн сантай Уул уурхайн компьютержсон кадастрын системийг холбох ажил хийгдсэн. Одоогоор туршилт сайжруулалтын ажил хийгдэж байна. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар болон Улсын бүртгэлийн газрын Мэдээллийн аюулгүй байдлын дүрэм, журамд нийцүүлэн ХУР системд холбогдож үйлчилгээ авч ажиллаж байгаа.</p>	70%	
262	2	12	<p>1.8. Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчлах;</p>	<p>УУХҮЯ-ны цахим хуудас /www.mmhi.gov.mn/, олон нийтийн бусад сүлжээ /facebook/-гээр дамжуулан холбогдох хууль, тогтоомжийн хэлэлцүүлэг, аж ахуйн нэгжид чиглэсэн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллийг түгээж салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан таниулдаг. Эрдэс баялгийн мэдээллийн хайлтын систем болох https://www.mgis.mn/ төрөлжсөн өгөгдлийн сангийн мэдээллийн хураангуйг хэрэглэгчдэд интернетийн орчинд нээлттэйгээр хүргэж байна.</p> <p>АМГТГ-ын www.mrpm.gov.mn цахим хуудсаар ЭБМЗ-ийн “Ашигт малтмалын хайгуулын асуудал” салбар хуралдааны мэдээлэл, Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн 2021 оны 2, 3, 4 дүгээр сарын хөдөлгөөний мэдээ, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд зориулсан мэдээ 12, Экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн мэдээлэл, Сонгон шалгаруулалтын мэдээ болон уул уурхайн салбарын нийт 37 мэдээ</p>	100%	

				<p>мэдээллийг олон нийтэд түгээсэн болно. Хайгуулын ажлын тайлан төлөвлөгөөний цахим программ www.inforef.mrpam.gov.mn , уул уурхайн кадастрын ашиглан https://cmcs.mrpam.gov.mn/cmcs , уул уурхайн боловсролыг дэмжих зорилгоор http://edu.mrpam.gov.mn/ , уул уурхайн хөрөнгө оруулагчдад зориулсан http://invest.mrpam.gov.mn/ , газрын тосны бүтээгдэхүүний газар зүйн байрлалын систем https://gisoil.mrpam.gov.mn/, газрын тосын бүтээгдэхүүний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд зориулан https://oil.mrpam.gov.mn/ зэрэг цахим хуудсаар дамжуулан уул уурхай, газрын тосны салбарт ажиллаж байгаа 4000 гаруй аж ахуйн нэгжтэй цахимаар холбогдон ажиллаж байна.</p>		
263	3	13	<p>Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2</p> <p>1.9. Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг "Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем"-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох.</p>	<p>УУХҮЯ, АМГТГ, ҮГА дотоод ажлын хэрэгцээнд ABLE cloud цахим систем ашиглаж албан бичиг болон бусад материалыг цахимаар солилцдог. УУХҮЯ нь "Майкрософт Оффис 365"-ийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж худалдан авсан. Програмын хөгжүүлэлтийг хийж УУХҮЯ-ны албан хэрэгцээнд нэвтрүүлсэн.</p>	100%	
<u>53</u>	<u>106</u>			<p><u>Нийтлэг асуудлын дундаж 87.6 хувь</u></p>		
<p><u>НИЙТ ДҮН: 84.3 хувь</u></p>						

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР